



Зөвлөмжийн Цуврал

ЗЦ115-1

Нэмэлт, өөрчлөлт 1 (2)

**Чөлөөт нисэхийн үйл ажиллагаа
эрхлэгчийн гэрчилгээжүүлэлт**

2016 оны 8 сарын 9

Ерөнхий зүйл

ИНЕГ-ын зөвлөмжийн цуврал (АС) нь холбогдох ИНД-ийг дагаж мөрдүүлэх зорилгоор Даргын зөвшөөрсөн стандарт, практик, журмын талаарх мэдээллийг агуулдаг.

Даргад танилцуулах нийцлийн бусад аргыг ч анхаарч үзэх бөгөөд шинээр стандарт, практик, журам хүлээн зөвшөөрөгдөхөд холбогдох АС-д нь нэмж оруулна.

Түүнчлэн, энэхүү АС нь дүрмийн шаардлагыг хангах зааварчилгаа материалыг агуулна. Зааварчилгаа материал нь хүлээн зөвшөөрөхүйц хэлбэрт тооцогдохгүй.

Зорилго

Энэ АС нь ИНД-115-ын дагуу чөлөөт нисэхийн үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээжүүлэлттэй холбоотой шаардлагын биелэлтийг ИНЕГ-ын Даргад үзүүлэхэд хүлээн зөвшөөрөх тайлбарласан материал, арга замыг оруулсан байна.

Холбогдох дүрмүүд

Энэхүү АС нь ИНД-115-д тусгайлан мөн ИНД-12, 19, 43, 61, 91 болон 141-ийн үйл ажиллагааны шаардлагатай холбоотой. Түүнчлэн, ИНД-д ашигласан тодорхойлолт, товчлолт орсон ИНД-1-тэй холбоотой.

Өөрчлөлтийн мэдээлэл

Гишүүн улсуудын иргэний нисэхийн Дүрмийг сайжруулах замаар иргэний нисэхийн салбарт нэгдсэн нэг Дүрмийн зохицуулалтад шилжих Олон улсын иргэний нисэхийн байгууллагын 1992 оны 29-р чуулганы А29-3 тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор, Монгол Улс болон Шинэ Зеланд улсын ИНЕГ-ын хооронд 1999 оны 5 дугаар сарын 6-нд байгуулсан “Техникийн Хамтын Ажиллагааны Санамж Бичиг”-ийг үндэслэн Монгол Улсын Иргэний нисэхийн багц дүрмийг боловсруулсан.

Гарчиг

Удиртгал	5
Холбогдох АС	5
Тодорхойлолт	5
Хураангуйлал	6
А Бүлэг - Ерөнхий зүйл	7
115.1 Зорилго.....	7
115.3 Тодорхойлолт	7
115.5 Гэрчилгээний шаардлага	7
115.7 Гэрчилгээ эзэмших хүсэлт	7
115.9 Гэрчилгээ олгох	8
115.11 Гэрчилгээ эзэмшигчийн эрх.....	8
115.13 Үйл ажиллагааны тодорхойлолт	8
115.15 Гэрчилгээний хугацаа	8
115.17 Үйл ажиллагааг зогсоох мэдэгдэл.....	9
115.19 Гэрчилгээг дахин олгох.....	9
115.21 Шилжилтийн үеийн зохицуулалт.....	9
В Бүлэг - Чөлөөт нисэхийн үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээжүүлэлтийн шаардлага	9
Ерөнхий зүйл	9
115.51 Ажилтанд тавих шаардлага.....	9
115.51 Ажилтанд тавих шаардлага (байхгүй байгаа удирдах ажилтан)	10
115.51(a)(1) Гүйцэтгэх захирал	11
115.53 Ажилтны ур чадварын шаардлага	12
115.55 Байгууламжид тавих шаардлага	13
115.57 Бататгах нислэг, эсхүл тест.....	14
115.59 Техник үйлчилгээний журам	14
115.61 Техник үйлчилгээний хөтөлбөр.....	15
115.61(b)(7) Гэмтлийг засах, эсхүл хойшлуулах	16
115.61(b)(8) Бүртгэлийг хадгалах.....	17
115.62 Эмийн бодис болон согтууруулах ундааны хөтөлбөр	18
115.63 Баримт бичиг	19
115.65 Ажилтны бүртгэл хөтлөх.....	20
115.67 Байгууламжийн бүртгэл	20
115.69 Нислэгийн зөвшөөрөл болон хяналт	20
115.71 Нислэг дагах хяналтын үйлчилгээ.....	21
АМС 115.71 Нислэг дагах хяналтын систем	21
115.73 Журмыг хэрэгжүүлэх	22
115.75 Осол, зөрчлийг мэдээлэх.....	25
115.77 Байгууллагын удирдлагын тогтолцоо	25

115.79	Чөлөөт нисэхийн үйл ажиллагаа эрхлэгчийн Ерөнхий заавар.....	27
С	Бүлэг - Үйл ажиллагааны хязгаарлалт болон шаардлага	30
115.101	Байнгын хэрэгжилт.....	30
115.103	Нисэх багийн гишүүний мэргэшил	30
115.105	Бизнесийн, эсхүл худалдааны нэр	31
115.107	Чөлөөт нисэхийн гэрчилгээ эзэмшигчийн хязгаарлалт	31
115.109	Гэрчилгээ эзэмшигчийн байгууллагын өөрчлөлт.....	31
115.111	Техник үйлчилгээний хөтөлбөрийн өөрчлөлт	31
D	Бүлэг - Нислэгийн үйл ажиллагаа	32
115.201	Үйл ажиллагааг хязгаарлах, эсхүл түдгэлзүүлэх	32
115.203	Зорчигчийн аюулгүй байдал.....	32
115.205	Зорчигчийн сургалт болон зааварчилгаа	33
115.207	Ослын төхөөрөмжид тавих шаардлага	33
115.209	Онцгой нөхцөлийн арга хэмжээний төлөвлөгөө	34
115.211	Нислэгийн үйл ажиллагааны аюулгүй байдлын шалгалт	34
115.213	Нислэгийн бэлтгэл болон нислэгийн төлөвлөлт	35
115.215	Агаарын хөлгийн удирдлагад оролцох	35
115.217	Усан дээгүүрх нислэг	36
115.219	Аэродром, буултын талбай болон хөөрөлтийн талбайг ашиглах.....	36
115.221	Цаг уурын нөхцөл.....	36
115.223	Агаарын хөлгийн ачааллын хязгаарлалт	36
115.225	НТЧ-ын үүрэг хариуцлага	37
115.227	Түлш.....	37
115.229	Аюултай бараа тээвэрлэх	38
115.231	Нислэгийн аюулгүй байдалд нөлөөлөх этгээд ажлын чадваргүй болох	38
E	Бүлэг - Сургалт	39
115.301	Сургалт - Ерөнхий зүйл	39
115.303	Нисэх багийн болон газрын багийн гишүүдийн сургалтын хөтөлбөр	40
115.305	Багийн гишүүд болон газрын багийн гишүүдийн анхан шатны сургалт	40
115.307	Багийн гишүүн болон газрын багийн гишүүдийн шилжих сургалт	41
115.309	Багийн гишүүд болон газрын багийн гишүүдийн давтан сургалт	41
105.311	Нисэх багийн гишүүнд багшлах эрх бүхий этгээдийн мэргэшил	41
105.313	Сургалтын бүртгэл.....	42
F	Бүлэг - Багийн гишүүн болон газрын багийн гишүүний ур чадварын шаардлага	42
115.351	Үйл ажиллагааны ур чадварын үнэлгээний хөтөлбөр	42
115.353	Нисэх багийн гишүүний ур чадварын шалгалт	42
115.355	Багийн гишүүн болон газрын багийн гишүүний ур чадварын шалгалт	42
115.357	Шалгагч-нисгэгчийн мэргэшил	42
115.359	Багийн гишүүний тест, эсхүл нислэгийн шалгалтыг шаардсан хугацаанаас өмнө гүйцэтгэх.....	44
115.361	Ур чадварын болон шалгалтын бүртгэл.....	44

Г Бүлэг - Нисэх багийн ажил, амралтын цагийн зохицуулалт	44
115.401 Үйл ажиллагаа эрхлэгчийн үүрэг хариуцлага - Нислэгийн болон үүрэг гүйцэтгэх цагийн хуваарь.....	44
115.403 Нисэх багийн гишүүний үүрэг хариуцлага - нислэгийн болон үүрэг гүйцэтгэх цаг	52
Н Бүлэг - Заавар, бүртгэлийн дэвтэр болон бүртгэл	53
115.451 Үйл ажиллагааны мэдээлэл	53
115.453 Бүхээгт авч явах баримт бичиг	53
115.455 Нислэгийн бүртгэлийн дэвтэр	53
115.457 Хадгалах хугацаа	54
Хавсралт А - Гэрээ - Ерөнхий зүйл	55
Удиртгал.....	55
Ерөнхий нөхцөл.....	55
Журам	56
Хавсралт В - ТҮ-г гэрээлэх	56
Удиртгал.....	56
Үүрэг хариуцлага	56
Ерөнхий нөхцөл.....	57
ТҮ-ний гэрээний дэлгэрэнгүй агуулга.....	58
Хавсралт С - Цахилгаан бүртгэл болон баримт бичиг	59
Ерөнхий мэдээлэл.....	59
Хавсралт D	60
Жишиг хөтөлбөр.....	60
ИНД-115-т шаардсан ТҮ-ний хөтөлбөр.....	60

Удиртгал

2021 оны 2 сарын 4-нд хүчинтэй болсон ИНД-115 нь чөлөөт нисэхийн үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээдийн гэрчилгээжүүлэлтийн болон үйл ажиллагааны шаардлагыг тогтооно. ИНД-115 нь чөлөөт нисэхийн үйл ажиллагаа эрхлэгчийг ИНД-119 болон ИНД-135-ын дагуу нисдэг тэрэг болон жижиг нисэх онгоц ашигладаг агаарын тээвэрлэгчтэй ижил төстэй арга замаар гэрчилгээжихийг шаардана. Энэхүү АС нь гэрчилгээ шаардлагатай хүсэлт гаргагчид зааварчилгаа өгнө.

Тайлбар: Биелүүлэх зааварчилгаа болон мэдээлэл/тайлбар материал шаардлагатай дүрмийг энэ хэсэгт оруулсан.

Холбогдох АС

Одоогийн байдлаар ИНД-115-тай холбоотой эдгээр АС-г боловсруулж байна.

АС115-2	Халуун агаарын бөмбөлгийн үйл ажиллагаа
АС 115-3	Шүхэр хаях агаарын хөлгийн үйл ажиллагаа
АС 115-4	Тандем-шүхрийн үйл ажиллагаа
АС 115-5	Глайдерын үйл ажиллагаа
АС 115-6	Ханг-глайдер болон параглайдерын үйл ажиллагаа
АС115-7	Тусгай категорийн агаарын хөлгийн үйл ажиллагаа
АС 115-8	Хэт хөнгөн агаарын хөлгийн үйл ажиллагаа
АС 00-3	Дотоод чанар баталгаажуулалт

Тодорхойлолт

ИНД-1-ийн дагуу “чөлөөт нисэхийн үйл ажиллагаа” гэдгийг дараах байдлаар тодорхойлсон байдаг:

Чөлөөт нисэхийн үйл ажиллагаа гэж нислэгт, эсхүл агаараас гүйцэтгэх үйл ажиллагаанд оролцож байгаа зорчигчид танин мэдэхүйн туршлага олгох зорилготой хөлс, эсхүл шан урамшуулалтай агаараар зорчигч тээвэрлэх дараах үйл ажиллагааг:

- (1) стандарт категорийн НТЧ-ын гэрчилгээ олгосон нисэх онгоц, эсхүл нисдэг тэргээр А-аас А цэг рүү жагсаалын нислэг, аэробатикийн маневр болон огцом өндөр авах, огцом өндөр алдах, огцом эргэлт хийх зэрэг ижил төрлийн стандарт бус нислэгийн маневр хийх;

- (2) тохирох тусгай категорийн анхдагч, тусгай категорийн спортын хөнгөн агаарын хөлгийн, эсхүл тусгай категорийн хязгаарлагдмал НТЧ-ын гэрчилгээ олгосон агаарын хөлгөөр А-аас А цэг рүү (үүнд газар уснаа явагч агаарын хөлгийн усан дээрх завсрын буулт багтана) жагсаалын нислэг, аэробатикийн маневр болон огцом өндөр авах, огцом өндөр алдах, огцом эргэлт хийх зэрэг ижил төрлийн стандарт бус нислэгийн маневр хийх;
- (3) А-аас А цэг рүү Ангилал-2 хэт хөнгөн агаарын хөлгийн нислэг;
- (4) халуун агаарын бөмбөлгийн нислэг;
- (5) глайдерын нислэг;
- (6) Хууль болон ИНД-119-ийн дагуу Даргын олгосон агаарын тээвэрлэгчийн гэрчилгээний эрхийн хүрээнд гүйцэтгэдэггүй шүхэр хаях агаарын хөлгийн үйл ажиллагаа;
- (7) тандем-шүхрээр буух үйл ажиллагаа;
- (8) тандем-ханг-глайдер, эсхүл параглайдерын нислэг.

Хураангуйлал

ИНД-1-д ороогүй дараах товчлол нь энэхүү АС-ын зорилгоор дараах утгыг илэрхийлнэ:

ЧНГ- Чөлөөт нисэхийн үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээ (ЧНГ).

ЧНҮА - Чөлөөт нисэхийн үйл ажиллагаа (ЧНҮА).

А Бүлэг - Ерөнхий зүйл

115.1 Зорилго

Чөлөөт нисэхийн үйл ажиллагааг ИНД-115-ын дагуу олгосон чөлөөт нисэхийн гэрчилгээний эрхийн хүрээнд гүйцэтгэнэ.

115.3 Тодорхойлолт

Энэ дүрэм нь “чөлөөт нисэхийн аэробатик нислэгийн үйл ажиллагаа”, “чөлөөт нисэхийн жагсаалын нислэгийн үйл тажиллагаа”, “газрын багийн гишүүн” болон “цэргийн сургуулилтын нислэгийн үйл ажиллагаа” гэсэн нэр томъёог тодорхойлсон. Энэ дүрэмд тодорхойлоогүй, ИНД-115-д ашигласан “чөлөөт нисэхийн үйл ажиллагаа” болон бусад нэр томъёог ИНД-1-ээс лавлана.

115.5 Гэрчилгээний шаардлага

Аливаа этгээд нь ИНЕГ-ын Даргаас олгосон ЧНГ эрхийн хүрээнээс гадна чөлөөт нисэхийн үйл ажиллагаа гүйцэтгэж болохгүй.

115.7 Гэрчилгээ эзэмших хүсэлт

ЧНГ эзэмших хүсэлт гаргахдаа, хүсэлт гаргагч нь ажилтны сургалт болон ур чадвар, төлөвлөсөн үйл ажиллагаанд ашиглах агаарын хөлгийн ТҮ-тэй холбоотой тодорхой хүчин зүйлсийг харгалзан үзэх хэрэгтэй болно:

(а) Хүсэлт гаргагч нь ЧНГ эрхийн хүрээнд байгууллага дотроо сургалт, ур чадварын шалгалтаа явуулахыг хүсч болно, эсхүл

(b) ИНД-141-ийн байгууллагаар сургалт, ур чадварын шалгалт хийлгэх гэрээ хийж болно.

Ашиглах агаарын хөлгийн хэмжээнээс шалтгаалан, тухайн агаарын хөлгийг ИНД-43 эсхүл ИНД-145-ын нөхцөлөөр ТҮ хийх шаардлагатай эсэхийг шийдэх шаардлагатай.

САА24115/01-ыг бүрэн бөглөж, гэрчилгээний дагуу явуулах хэрэгтэй сургалт болон ур чадварын шалгалтыг оруулан, төлөвлөсөн ажиллагааг бүрэн хэмжээгээр тодорхойлох ёстой. Энэхүү мэдээллийг үйл ажиллагааны цар хүрээ болон үйл ажиллагааны тодорхойлолтын үнэлгээ болон бэлтгэлд ашиглана.

Хүсэлтийн хамт зохих удирдах ажилтны хүсэлт (үүнд тохирох зөв хүн маягт), ИНД-115-ын матриц болон Ерөнхий зааврыг өгнө.

Гэрчилгээжүүлэх үйл ажилд хугацаа хэрэгтэй учраас төвлөсөн ажиллагааг эхлэхээс доод тал нь 90 хоногийн өмнө хүсэлт өгөхийг зааварчилдаг. Төлөвлөсөн ажиллагаа эхлэх өдрөөс 90-ээс бага хоногийн өмнө ЧНГ эзэмшихээр хүсэлт гаргаж байгаа үйл ажиллагаа эрхлэгч нь хүсэлтийн ажиллагааг цагт нь амжихгүй болгох эрсдэлтэй.

Богинохон хугацааг дүрмээс чөлөөлөлт гэж үзэх бөгөөд хүсэлт гаргагчаас тэгж хандана. Үйл ажиллагаа эрхлэгч гэрчилгээний хөтөлбөрөө урьдчилан төлөвлөх

хэрэгтэй бөгөөд ИНЕГ-тай эртхэн зөвлөж ярилцсанаар бүх асуудлыг эхлэхээр төлөвлөсөн өдрөөс өмнө шийдэх боломжтой болно.

Ингэснээр, гэрчилгээ эзэмшихэд шаардлагатай хугацаа нь хүсэлт болон Ерөнхий зааврын чанар, бүрэн бүтэн байдлаас шалтгаална.

115.9 Гэрчилгээ олгох

ИНЕГ-ын Дарга нь дүрэмд заасан шаардлагыг хангасан гэж үзвэл ЧНГ-г олгож болно. Дэлгэрэнгүйг дүрмээс үзнэ үү.

115.11 Гэрчилгээ эзэмшигчийн эрх

ЧНГ болон дагалдах Үйл ажиллагааны тодорхойлолт нь гэрчилгээ эзэмшигчийн гүйцэтгэж болох ЧНҮА-ны төрлийг заана. Дэлгэрэнгүйг дүрмээс үзэх.

115.13 Үйл ажиллагааны тодорхойлолт

ЧНГ-нд үйл ажиллагааны тодорхойлолт дагалдах бөгөөд гэрчилгээгээр эрх олгосон үйл ажиллагааны дэлгэрэнгүйг багтаасан байна. ИНЕГ-ын Дарга үйл ажиллагаа эрхлэгч үйл ажиллагааг өөрчлөх, хөгжүүлэх аливаа үед үйл ажиллагааны тодорхойлолтыг өөрчилж болно (115.109(e)-г харах). Үйл ажиллагааны тодорхойлолтыг ИНЕГ-аас гэрчилгээ олгох үед ИНЕГ-ын өгөгдлийн санд автоматаар оруулах бөгөөд энэ нь САА24115/01 хүсэлтийн маягтаас авсан өгөгдөлд үндэслэсэн байна. Иймд хүсэлт гаргагч энэ маягтанд төлөвлөсөн үйл ажиллагааны хамрах хүрээг тодорхой зааж өгөх нь чухал юм.

Үйл ажиллагааны тодорхойлолт нь зөвхөн үйл ажиллагааны төрлийг заана, явуулах үйл ажиллагааг дэлгэрэнгүй жагсаахгүй. Анхаарах ёстой мэдээллийн нарийн төвөгтэй байдал нь төлөвлөсөн үйл ажиллагааны нарийн төвөгтэй байдлаас шалтгаална.

Нэгээс олон төрлийн үйл ажиллагааг зөвшөөрч болно.

ЧНГ эзэмшигч нь дүрмийн эсрэг тодорхой чөлөөлөлтийг авсан бол, тэдгээрийг гэрчилгээ эзэмшигчийн үйл ажиллагааны тодорхойлолтод жагсаана.

115.15 Гэрчилгээний хугацаа

Шинээр хүсэлт гаргагч

Гэрчилгээг 5 жил хүртэл хугацаагаар олгож болно. Гэхдээ үйл ажиллагаа эрхлэгчийг Ерөнхий заавар болон ИНД-115-ын хэрэгжилтээ үзүүлэх боломж олгон, гэрчилгээг анхлан олгохдоо ихэвчлэн богино хугацаанд - ерөнхийдөө 2 жилээр олгодог. Энэхүү 2 жилийн хугацаанд ИНЕГ хяналт ажиглалтын үйл ажиллагаа явуулна. Гэрчилгээний хугацаа дуусахын өмнөх хоёр дахь жилд ИНЕГ “дахин гэрчилгээжүүлэх”, эсхүл “эргэн оруулах” гэж нэрлэдэг сунгах үйл ажиллагааг явуулна. Дүрмийн хувьд, энэхүү үйл явцыг ЧНГ-г “шинэчлэн олгох” гэдэг (115.19-ээс лавлаж харах). Үйл ажиллагаа эрхлэгч шинэчлүүлэхээр хүсэлт гаргах ёстой.

Хүсэлт гаргагч нь өөр ИНД-ийн дагуу байгууллагын гэрчилгээтэй бол (жнь ИНД-119, эсхүл 145), 5 жилийн гэрчилгээг ихэвчлэн олгох магадлалтай; гэрчилгээ эзэмшигч нь гэрчилгээтэй холбоотой гэрчилгээний шаардлагыг биелүүлсээр байх ёстой. Энэ нь тухайн байгууллага иргэний нисэхийн бусад чиглэлээр чадвараа үзүүлэх боломжтой байсныг харуулах бөгөөд энэ байгууллага нь шинэ гэрчилгээний эрхээ адил байдлаар хэрэгжүүлнэ гэсэн дүгнэлтэнд хүрэхээр байна.

115.17 Үйл ажиллагааг зогсоох мэдэгдэл

Энэ дүрэм нь ЧНГ эзэмшигчээс ИНЕГ-ын Даргад чөлөөт нисэхийн үйл ажиллагаагаа зогсоох өдрөөс 30 хоногийн дотор зогсоох талаар мэдэгдэхийг шаардана.

115.19 Гэрчилгээг дахин олгох

Нисэхийн баримт бичиг бүр хүчинтэй хугацаа дуусах өдөртэй байдаг. Хэрэв нисэхийн баримт бичиг эзэмшигч нь хүчинтэй хугацаа өнгөрснөөс хойш үйл ажиллагаагаа үргэлжлүүлэхийг хүсч байвал тэд САА24115/01-аар гэрчилгээ сунгуулах хүсэлт гаргах үүрэгтэй. Сунгуулах хүсэлтийг ИНЕГ хүсэлтийг боловсруулахаар, хүчинтэй хугацаа дуусахаас хангалттай хугацааны өмнө өгөх ёстой. Гэрчилгээний хугацаа дуусахаас доод тал нь 60 хоногийн өмнө хүсэлтийг өгөх ёстой гэж заадаг. Гэрчилгээ дэлгэрэнгүй байх бөгөөд анх гэрчилгээ олгохтой адил авч үзнэ.

115.21 Шилжилтийн үеийн зохицуулалт

Энэ дүрэм нь ИНД-115-ын биелэлтэнд хангалттай хугацааг зөвшөөрсөн. Гэхдээ тухайн шилжилтийн үе дууссан бөгөөд энэ заалтыг ИНД-115-ын дараагийн өөрчлөлтөөр цуцална.

В Бүлэг - Чөлөөт нисэхийн үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээжүүлэлтийн шаардлага

Ерөнхий зүйл

Энэ Бүлэг нь удирдах ажилтан, журмыг хэрэгжүүлэх, бүртгэлийг хадгалах болон Ерөнхий зааврыг боловсруулахад тавих шаардлагыг заана.

115.51 Ажилтанд тавих шаардлага

Хүсэлт гаргагчийн дэвшүүлсэн удирдах ажилтныг үйл ажиллагаа эрхлэгчийн бизнесийн хэмжээ, хамрах хүрээтэй холбоотой менежментийн үүргийг хүлээхээр үндсэн, гэрээгээр ажиллуулдаг, эсхүл өөрөөр зохицуулсан байх ёстой. ИНЕГ нь томилогдсон удирдах ажилтанд шаардлагатай ажил ихэнх тохиолдолд тухайн этгээдийг бүтэн цагаар ажилд авах нь тохиромжгүй, харин тухайн этгээдийн туршлагыг уян хатан байдлаар шаардаж болно гэдгийг мэддэг. Энэхүү заалт нь хэрэгцээнд үндэслэн ажилтан авах нөхцөлийг тусгасан байна. Энэхүү заалтын

“үндсэн”, “гэрээгээр ажиллуулах”, болон “өөрөөр зохицуулах” гэсэн нэр томъёо бүгд гэрээтэй хугацаанд үйлчилгээ, туршлагаар хангахаар урьдчилан тохиролцох утгатай.

115.51(a)(1),(2),(3) Энэ заалт нь үйл ажиллагааны байнгын үр дүнг бататгах, удирдлагын зохих хэмжээ, чиглэл, үүрэг хариуцлагыг хэрэгжүүлэх, байгууллагын аюулгүй байдлын чухал шаардлагатай гишүүнийг тодорхойлно. Зарим тохиолдолд хүсэлт гаргагч нь (115.79(a)(4)-т шаардсан) Ерөнхий заавартаа гүйцэтгэх захирлаас эхлээд байгууллагын ажилтны байрлах байрлал бүрийг хамарсан үүрэг хариуцлагын шугаман хамаарлыг харуулсан байгууллагын бүтцийн зургийг оруулсан байх ёстой. Байгууллагын бүтцийн зургийг цар хүрээнээс шалтгаалахгүй хийх хэрэгтэй гэж үздэг.

Хүсэлт гаргагч нь нийт бизнесийн бүтцийнхээ хэсэг болгон ямар ч бүтцийг ашиглаж болно, гэхдээ хүсэлт гаргагчийн хэрэгжүүлэх гэж байгаа мэдээлэх шугам болон хяналтын үр дүнтэй байдлыг ИНЕГ-ын Дарга хангалттай гэж үзэх ёстой. Хэрэв тухайн байгууллагын бүтэц нь дүрмийн шаардлагад үр дүнтэй байх эсэхэд эргэлзэж байвал хүсэлт гаргагч нь аль болох эртхэн ИНЕГ-тай зөвлөх ёстой.

ИНД-115 Хавсралт А Энэхүү хавсралт нь удирдах албан тушаалд томилогдсон ажилтанд шаардлагатай минимум туршлага болон мэргэшлийг заана. Энэ Хавсралтад ИНЕГ-ын Дарга дүйцэх стандартын үнэлгээ хийж болох зүйлс байгаа. Энэ заалтанд ЧНГ-ний үйл ажиллагаатай холбоотой туршлага, хүчинтэй байх хугацаа багтсан байна.

115.51 Ажилтанд тавих шаардлага (байхгүй байгаа удирдах ажилтан)

Хүсэлт гаргагч нь хүсэлт гаргах үедээ удирдах ажилтан байхгүй үед үүргийг бусад тохиромжтой, шаардлага хангасан этгээдэд хэрхэн шилжүүлэх талаар тооцох хэрэгтэй гэж зөвлөж байна. Хэдийгээр дүрэмд удирдах ажилтан урт хугацаагаар байхгүй, эсхүл албан тушаал сул байх тохиолдлын нөхцөл заагаагүй боловч энэ талаар урьдчилан төлөвлөхийг зөвлөдөг. Удирдах ажилтан чадваргүй болох нөхцөлийг бас тооцох ёстой. Чадваргүй болсон хугацаанд ажлын байр хүнгүй байх учраас энэ дүрмийн шаардлагыг биелүүлэх түр орлох этгээд шаардлагатай болно.

Үүрэг хариуцлагыг өөр этгээдэд шилжүүлсэн тохиолдолд тухайн этгээд нь бас “тохирох зөв хүн” байх, ИНД-115 Хавсралт А-д заасан холбогдох туршлага, мэргэшилтэй байх шаардлагатай.

ЧНГ эзэмшигч нь сул үлдсэн удирдах ажилтны ажлын байранд ажиллах этгээдийг томилоогүй тохиолдолд тухайн нөхцөлөө ИНЕГ-ын Даргад мэдэгдэх ёстой. Байнгын шийдэлд хүрэхийн тулд хийх урьдчилан тааварлаагүй нөхцөлийг зохицуулах талаар дэлгэрэнгүйг үйл ажиллагаа эрхлэгчээс шаардаж болно.

Өөрчлөлт хийхээр төлөвлөсөн тохиолдолд 115.109(b) нь ИНЕГ-ын Даргад өөрчлөлтийн талаар урьдчилан мэдэгдэж, зөвшөөрөл авсан байх ёстой гэдгийг тэмдэглэх хэрэгтэй.

ИНЕГ-ын Дарга нь урьдчилан тааварлаагүй нөхцөлийн зохицуулалтыг хүлээн авахдаа 115.109(d)-ийн дагуу урьдчилан тааварлаагүй хугацааны түр шинж байдалд

хязгаарлалт, эсхүл нөхцөл зааж болно. ИНЕГ-ын Даргын тавьсан нөхцөл, эсхүл хязгаарлалтыг ямар ч тохиолдолд үйл ажиллагаа эрхлэгчид бичгээр тодорхой зааж өгөх бөгөөд болох үйл явдлын цаг хугацааны хүрээ, эсхүл үйл ажиллагааны нийтэд нь түдгэлзүүлэх талаар оруулсан энгийн хэлбэртэй байж болно.

Дүрэмд заасан удирдах ажилтны албан үүрэг бүрд тусдаа хүмүүсийг оруулах ёстой гэж заасан. Гэхдээ дүрмээр ИНЕГ-ын Дарга үйл ажиллагаа эрхлэгчийн байгууллагын хэмжээ, хамрах хүрээ нь зарим үүрэг хариуцлагыг нэгтгэх нь хүлээн зөвшөөрөгдөхүйц болохыг харуулахын бол шийдвэр гаргах эрхийг олгоно. Хэрэв хүсэлт гаргагч нь удирдах ажилтны үүрэг бүрд тусдаа этгээд хэрэггүй гэж үзвэл ИНЕГ-тай хийх эхний уулзалтаар ярилцах ёстой.

Албан тушаалыг нийлүүлсэн тохиолдолд хүсэлт гаргагч нь үйл ажиллагаа эрхлэгчийн бизнесийн хэмжээ, хамрах хүрээг харгалзан үзэхэд тухайн этгээд нь тухайн албан тушаалыг гүйцэтгэх цаг зав, эх сурвалжтай гэдгийг харуулсан баталгаа гаргах шаардлагатай болно.

Төлөвлөсөн албан тушаалд харгалзах үүрэг хариуцлага нь хоорондоо зөрчилдөх учраас дараах зарим үүргийг нийлүүлж болохгүй:

- Гүйцэтгэх захирал болон байгууллагын удирдлагын тогтолцоог хариуцсан этгээдийн ажил үүрэг.
- Үйл ажиллагаа болон зөрчлийг шинжлэн шалгах үүрэгтэй этгээдийн ажил үүрэг.

115.51(a)(1) Гүйцэтгэх захирал

Тухайн этгээд нь дараах зүйлийг хариуцна:

- (a) байгууллагын гүйцэтгэж байгаа бүх үйл ажиллагааг санхүүжүүлэх;
- (b) эдгээр үйл ажиллагааг ИНД-115-ын дагуу гүйцэтгэх;
- (c) байгууллага ИНД-115-ын шаардлагыг дагаж мөрдөх.

Тухайн этгээд үйл ажиллагааг санхүүжүүлэх эрх мэдэлтэй байх хэрэгтэй гэдэг нь тодорхой юм. Үүнийг харуулах, санал болгосон арга зам бол жилийн бизнесийн урьдчилсан төлөв мэдээг гарган үзүүлэх, эсхүл ИНД-115-ын биелэлтийн хэсэг болгон, үйл ажиллагааг санхүүжүүлэх эрхийг гүйцэтгэх захирлын үүргийн нэг хэсэг гэдгийг тодорхой зааж өгөх явдал юм.

Гүйцэтгэх захирал нь мөн Ерөнхий зааврыг баримтлан ажиллагаа гүйцэтгэхийг хариуцах ёстой. Ерөнхий заавраа дагаж мөрдөж байгааг бататгахыг хариуцах нь 115.51(a)(2)(i)-д удирдах ажилтны үүрэг хариуцлага гэж заасан бөгөөд гүйцэтгэх захирлын шаардах баталгааг дотоод аудит, аудитын мэдээ, эсхүл шалгах хөтөлбөр г.м байгууллагын удирдлагын тогтолцоогоор харуулна.

Гүйцэтгэх захирал нь анх хүсэлт гаргахдаа болон бусад үед тэд байгууллага удирдах мэдлэгтэйг үзүүлэх ёстой.

115.53 Ажилтны ур чадварын шаардлага

Энэ заалтаар хүсэлт гаргагчийг ЧНҮА-тай холбоотой тодорхой үйл ажиллагааг гүйцэтгэхийг хүсэлт гаргагчаас эрх олгосон ажилтны ур чадварыг анх шалгах болон хадгалах журмыг Ерөнхий заавартай оруулсан байхыг шаарддаг.

“Төлөвлөх” шаардлагатай ажилтны хувьд үйл ажиллагааг өндөр түвшинд төлөвлөх гэсэн үг бөгөөд энэ нь хуваарь гаргах, баг, ажилтны түвшин болон төхөөрөмжийн шаардлагыг хэрэгжүүлнэ.

“Гүйцэтгэх” шаардлагатай ажилтны хувьд энэ нь чөлөөт нисэхийн үйл ажиллагаатай холбоотой аливаа үүргийг биелүүлэх, эсхүл хийх шаардлагатай этгээдийг хүсэлт гаргагчийн Ерөнхий зааварт жагсаасан байх ёстой гэсэн үг юм. Үүнд сургалтын хөтөлбөр, ур чадвар шалгах, байгууллагын удирдлагын тогтолцоо, эсхүл нислэг дагах хяналт орно. Үүнд: мөн үйл ажиллагааны дүрэмд заасан нисэх багийн ур чадвар багтана.

“Хянах” шаардлагатай ажилтны хувьд энэ нь ЧНҮА-ны аливаа хэсгийг хянах, хариуцах шаардлагатай этгээдийг хэлэх бөгөөд удирдах ажилтан гэж дэвшүүлсэн хүмүүс орно.

“Шалгах” шаардлагатай ажилтны хувьд энэ нь ЧНҮА-ны аливаа хэсгийг шалгах, үзлэг хийх шаардлагатай этгээдийг хэлэх бөгөөд удирдах ажилтан гэж дэвшүүлсэн хүмүүс орно.

“Гэрчилгээжүүлэх” шаардлагатай ажилтны хувьд энэ нь ТҮ-г оруулсан ЧНҮА-ны аливаа үйл ажиллагаа, эсхүл хэсгийн талаар албан мэдэгдэл хийх, эсхүл батлах үүрэгтэй этгээдийг хэлэх бөгөөд удирдах ажилтан гэж дэвшүүлсэн хүмүүс орно.

Хүсэлт гаргагчийн журам нь үйл ажиллагаандаа тохирсон байж болно. Журамд тухайн этгээд үйл ажиллагааг аюулгүй гүйцэтгэх чадвараа хэрхэн хадгалах болон мөн жилийн ур чадварын шалгалтын талаар заасан байна. Энэ нь зөвхөн нисгэгчийн ур чадварын шаардлагаар хязгаарлагдахгүй.

Чадвартай гэж үнэлэгдсэний дараа, ажилтнд ажил үүргээ гүйцэтгэх эрхийг бичгээр, энгийн эрхийн гэрчилгээ байдлаар өгөх ёстой.

Энэ журамд хоёр боломж өгсөн бөгөөд хүсэлт гаргагч нь аль чиглэлийг сонгох сонголтоо хийх хэрэгтэй болно.

115.53(a) Энэ сонголт нь хүсэлт гаргагчийг хүсэлт гаргагчийн Ерөнхий зааварт жагсаасан ЧНҮА-г төлөвлөх, гүйцэтгэх, хянах, шалгах болон гэрчилгээжүүлэх журмыг тогтоохыг шаардана. Мөн журамд параграфт заасан үйл ажиллагааны ажилтны ур чадварыг анх шалгах болон хадгалах талаар оруулна. Энэ тохиолдолд хүсэлт гаргагч нь хөтөлбөрийг бүхэлд нь гаргаж, хөтөлбөрийн хүрээнд сургалт, ур чадварын шалгалт явуулах зохих, мэргэшсэн шалгагчийг үндсэн, гэрээгээр ажиллуулах, эсхүл өөрөөр ажилд авна.

115.53 (b) Энэ сонголт нь хүсэлт гаргагчийг байгууллагын дотор ИНД-141, эсхүл ИНД-149-ийн дагуу гэрчилгээжсэн, зохих ёсоор зөвшөөрөгдсөн байгууллагатай гэрээ хийж, хүсэлт гаргагчийн ажилтнуунды ур чадварыг үнэлэх шалгалт, эсхүл ур чадварыг хадгалах сургалтыг зохион байгуулах ажлыг гүйцэтгүүлж болно.

ИНД-141, эсхүл ИНД-149-ийн байгууллагын зөвшөөрөл нь нисэх багийн үнэлгээ, сургалттай холбоотой бөгөөд ТҮ-ний ажилтныг оруулж болно. Удирдах ажилтан бүрийн менежментийн үүрэг хариуцлагыг үнэлэх, ур чадвараа хадгалах ажлыг ажлын байрны тодорхойлолтонд зааснаар ИНД-115 гэрчилгээний дагуу явуулах ёстой.

Байгууллага нь менежментийн үүрэгтэй холбоотой үйл ажиллагааг явуулах чадваргүй бол, тохиромжтой мэргэшсэн хүмүүсээр энэ ажиллагааг хийлгэх хэрэгтэй болно. Энэ нь адил тэнцүү хүмүүс шалгах, өмнөх гүйцэтгэлийг үнэлэх, зааварчилга семинар, симпозиум болон энгийн сургалтын курсээр тухайн салбартаа эксперт болох зөвлөхөөр хийлгэж болох жишээ болж болох юм.

115.53 (c) Энэ заалт нь хүсэлт гаргагчийг Ерөнхий заавартаа ИНД-141, эсхүл ИНД-149-т шилжүүлсэн үйл ажиллагаа болон тухайн багууллагын шалгах, сургах болон эрхийн хамрах хүрээг тэдгээр үйл ажиллагааны дэлгэрэнгүйг оруулахыг шаардана.

Үнэлгээ болон сургалтын үйл ажиллагаа нь хүсэлт гаргагчийн хүлээх үүрэг юм. Заалт нь ЧНҮА-г аливаа, эсхүл бүх үйл ажиллагааг ИНД-141, эсхүл ИНД-149-ийн байгууллагад шилжүүлэх боломжтой болгоно.

Энэ заалт нь Ерөнхий зааварт дэлгэрэнгүй мэдээлэл оруулахыг заадаг, тиймээс энэ хэсэг нь, ямар үйл ажиллагаа байгаа, ажиллагаа бүрийг хэн явуулах талаар эргэлзээ гарахаас сэргийлж, үйл ажиллагаа, хамрах хүрээг маш тодорхой, ойлгомжтой заах ёстой.

Хүсэлт гаргагч нь ИНД-141, эсхүл ИНД-149 байгууллагыг ажлыг гүйцэтгэж, заасан аливаа мэдээллийг өгөх эрхийг олгож болно.

Энэ дүрэмд шаардсан дэлгэрэнгүй мэдээлэл болон эрхийг үйл ажиллагаа эрхлэгч болон гэрээлэгч нарын хоорондын гэрээнд оруулж болно. Хавсралт А-аас гэрээ хийх талаар ерөнхий мэдээллийг үзнэ үү.

115.55 Байгууламжид тавих шаардлага

Энэ заалт нь ЧНҮА-г төлөвлөсөн үйл ажиллагааг дэмжих зохих хангалтаар хангахыг шаардана. Үүнд: ажлын байр, засварын цех, ангар, төхөөрөмж, хэрэглэл, сургалтын туслах хэрэглэл, өгөгдөл болон баримт бичиг багтана.

ИНЕГ нь ажлын байрны шалгалт хийх үеэрээ хангасан зүйлс нь төлөвлөсөн ажиллагаандаа таарч байгаа эсэхийг үнэлнэ.

Энэ нь яг таг зүйл биш боловч хүсэлт гаргагч нь олон өөр үйл ажиллагаа эрхлэгчийг шалгаж байсан, юу шаардлагатайг сайн мэддэг ИНЕГ-ын төлөөлөгчийн саналыг болгоомжтой харгалзан үзэх ёстой. ЧНҮА бүрд ажлын байр, засварын цех, ангар, эсхүл байгууламж шаардлагагүй, гэхдээ эдгээрийн аль нэг нь ЧНҮА-г явуулахад

хэрэгтэй бол, хүсэлт гаргагч хангах ёстой. Зарим ховор хэрэглэгддэг төхөөрөмж хэрэгтэй болох үед хангах зохицуулалт хийсэн бол байнга байлгахыг шаардахгүй байж болно.

115.57 Бататгах нислэг, эсхүл тест

Энэ заалт нь ИНЕГ-ын Даргыг хүсэлт гаргагчаас өөрийн тодорхой үйл ажиллагааг үзүүлэх замаар хүсэлт гаргагч тогтоосон шаардлагыг хангаж байгаагаа үзүүлэх зорилгоор бататгах нислэг, эсхүл тест хийхийг шаардахыг зөвшөөрнө.

Агаарын хөлгийн маяг, эсхүл үйл ажиллагааны төрөлдөө томоохон өөрчлөлт хийж байгаа, эсхүл одоо ажиллаж байгаа үйл ажиллагаа эрхлэгч нь ИНД-115-ын шаардлагыг биелүүлсээр байгаагаа үзүүлэх шаардлагатай болж болно.

ИНЕГ нь бататгах нислэгийг ажиглаж, хүсэлт гаргагчийг ЧНҮА-г төлөвлөсөн хүрээнд ердийн нислэгийн аль нэг, эсхүл бүх талыг үзүүлэхийг шаардаж болно. Үзүүлэх нислэг нь үйлчлүүлэгчид өгсөн анхны сургалтаас эхлээд нислэгийг дуустал өгсөн аливаа сургалтаас эхэлж болно. Үзүүлэх хэсэгт мөн баримт бичиг ашиглах болон бүртгэл хөтлөх орно.

115.59 Техник үйлчилгээний журам

Энэ заалт нь хүсэлт гаргагчаас ЧНГ-ний эрхийн хүрээнд үйл ажиллагаандаа ашиглаж байгаа агаарын хөлгийн болон агаарын хөлөгт суурилуулсан, эсхүл бэхэлсэн төхөөрөмжийн НТЧ-ын хадгалалтыг бататгах журам тогтоохыг шаардана.

Тиймээс хүсэлт гаргагч нь загварын төлөв байдал (маягийн тодорхойлолт, үйл ажиллагаа эрхлэгчийн сонголт, НТЧ-ын удирдамж, өөрчлөлт, НТЧ-ын хадгалалтын үйлдвэрлэгчийн зааварчилгаа) үйл ажиллагааны төхөөрөмж болон гүйцэтгэх шаардлагатай ТҮ-ний талаар хангалттай мэдлэгтэй байх ёстой.

Ерөнхий зааврын журамд хүсэлт гаргагч хэрхэн өөрийн агаарын хөлгийн НТЧ-ыг хадгалах талаар дэлгэрэнгүй оруулах үүрэгтэй. Тухайн үүрэг хариуцлагыг өөр этгээдэд шилжүүлж болохгүй боловч, тодорхой ТҮ-ний ажил, үйлчилгээг өөр этгээдээр (ТҮ үзүүлэгч) гүйцэтгүүлэхээр гэрээ хийх боломжтой.

Журам нь ТҮ-ний менежмент, эсхүл төлөвлөлтийн системээр хангах ёстой. Энэ нь компьютержсэн систем г.м ямар ч хэлбэртэй байж болно. Гэхдээ компьютержсэн системийг ашиглаж байгаа бол өгөгдлийг (нууц үг хамгаалах г.м) хамгаалах заалт оруулах, өдөр тутам хадгалж архивлах, төхөөрөмж эвдэрсэн тохиолдолд цаасан систем рүү шилжүүлэх урьдчилан хараагүй нөхцөлийн төлөвлөгөөг бодох ёстой.

Өөрсдийн болон гэрээт ТҮ үзүүлэгчийг гэрчилгээжүүлэх үйл явцын нэг хэсэг болгон үнэлнэ. Үнэлгээний түвшин болон гүнзгий байдал нь ТҮ үзүүлэгчийн нисэхийн систем дэх мэдэгдсэн гүйцэтгэлээс хамаарна. Үнэлгээгээр ТҮ үзүүлэгч нь үйл ажиллагаа эрхлэгчийн агаарын хөлөг, төхөөрөмж болон төлөвлөсөн ажиллагааг дэмжих чадварыг тогтооно.

Заалт нь туслах гэрээ байгуулах үед үйл ажиллагаа, хамрах хүрээ, эрх гэдэг үгсийг ашигладаг. Эдгээрийг дараах байдлаар уншиж ойлгоно:

Үйл ажиллагаа: үйлчилгээний бюллетин/захиа, НТЧ-ын удирдамж г.м өгөгдлийн үнэлгээ явуулах. Гэмтлийг мэдээлэх; ТҮ-ний хяналт; найдвартай байдал г.м.

Хамрах хүрээ: ТҮ үзүүлэгчийн үзүүлэх ТҮ-ний дэлгэрэнгүй Жнь: тогтмол ТҮ/нисэхийн электрон төхөөрөмж/иж бүрдлийн их засвар.

Эрх: Үйл ажиллагааг шилжүүлснээр ТҮ-г гүйцэтгэхтэй холбоотой бусад этгээдэд өгсөн эрх нь тухайн этгээд ямар шийдвэрийг үйл ажиллагаа эрхлэгчийн өмнөөс гаргаж болохыг зааж өгөх ёстой. Энэхүү эрхийг бичгээр өгнө.

Тайлбар: Хавсралт А болон В-ээс гэрээ хийх ерөнхий мэдээлэл болон ТҮ-г гэрээлэх талаарх дэлгэрэнгүйг үзэх.

115.61 Техник үйлчилгээний хөтөлбөр

ЧНГ эзэмших хүсэлт гаргагч нь шүхрийн иж бүрдлийг багтаасан, тухайн гэрчилгээний эрхийн хүрээнд үйл ажиллагаандаа ашиглаж байгаа агаарын хөлгийн ТҮ-ний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үүрэгтэй. Дүрмээс дэлгэрэнгүйг лавлах. ТҮ-ний хөтөлбөр нь ерөнхийдөө зөвшөөрсөн ТҮ-ний хуваарь, ИНД-91 болон ИНД-115-д шаардсан нэмэлт ТҮ (ихэвчлэн үйлдвэрлэгчийн), ИНД-91 болон ИНД-115-т шаардсан нэмэлт үйлчилгээ болон агаарын хөлгийн үйлдвэрлэгчээс хариуцахгүй, бусад суурилуулсан төхөөрөмжийн үйлдвэрлэгч нарыг хамтатгасан баримт бичиг юм. Үүнд мөн агаарын хөлгийн эцсийн хугацаа, их засварын хугацаа болон хөтөлбөрт агаарын хөлгийг оруулах үйл явц г.м зүйлс багтана.

Хөтөлбөрийг дараах тусдаа хэсэгт хувааж болно:

- (a) бүх агаарын хөлөгт хамаарах ерөнхий шаардлага
- (b) тухайн агаарын хөлгийн маягт тавих тусгай шаардлага.

Заах маягаар хэлэхэд тодорхой агаарын хөлөгт ТҮ-ний хөтөлбөрийг боловсруулахдаа (b)(1)-ээс (8) хүртэлх зүйлсийг оруулна. Хүсэлт гаргагчид туслах зорилгоор ИНЕГ ТҮ-ний хөтөлбөрийн ерөнхийлсөн загвар гаргасан байгаа. ИНЕГ-ын веб сайтаас татахдаа http://www.caa.govt.nz/GA/maint_prog_tmpl.doc линкийг ашиглана.

Хүсэлт гаргагч нь загварыг өөрчлөн, агаарын хөлгийн маягт тохирох зохих өгөгдлийг оруулна.

Дараах зааварчилгаа нь мөн ТҮ-ний хөтөлбөрийг боловсруулахад тусална.

- (a) шаардлагатай шалгалт, тестийг оруулаад агаарын хөлгийн ТҮ явуулах заавар болон журам. Энэ нь хоёр хэсэгтэй:
 - (i) тэдгээр шалгалтыг НТЧ-ын удирдамж болон ИНД-91-ийн G Бүлэгт шаардсан. Эдгээрийг ерөнхий хэсэгт оруулж болох бөгөөд бүх агаарын хөлгийн маягт хамааралтай.

- (ii) тэдгээр шалгалт нь агаарын хөлгийн маягт тусгайлсан бөгөөд агаарын хөлгийн үйлдвэрлэгчийн ТҮ-ний хуваарь, ТҮ-ний заавар болон НТЧ-ын хадгалалтын зааварт жагсааж оруулсан.
- (b) хөтөлбөр нь нөхцөлийг ажиглах ТҮ ашигладаг бол чиг хандлагын анализ хийх журам. Үүнийг ерөнхий шаардлагад багтааж болно.
- (c) хөтөлбөр дэх бүх шалгалтыг гүйцэтгэхийг баталгаажуулах журам. Үүнийг ажиллуулах бүх агаарын хөлгийн ерөнхий ТҮ-ний төлөвлөлтийн хэсэг болгон оруулж болно.
- (d) ТҮ-ний явцад илэрсэн дутагдлыг бүртгэх, засах болон хойшлуулах журам. Үүнийг бүх агаарын хөлгийн ерөнхий хэсэг болгон оруулж болно. ТҮ гэдгийг хамгийн өргөн утгаар нь нислэгийн өмнөх болон нислэгийн дараах шалгалтыг оруулж ойлгох хэрэгтэй.
- (e) агаарын хөлгийн ашиглалтад шилжүүлж байгаа этгээдийн нэрийг оруулаад гүйцэтгэх ажлын тодорхойлолтыг хадгалах журам. Үүнийг бүх агаарын хөлгийн ерөнхий хэсэг болгон оруулж болно.
- (f) шалгалтын интервалыг хэтрүүлэх, хамаарах нөхцөлийн заавар. Үүнийг бүх агаарын хөлгийн ерөнхий хэсэг болгон оруулж болно.
- (g) үйлчилгээний туршлагаас болж шалгалтын интервалийг өөрчлөх зааварчилгаа. Үүнийг бүх агаарын хөлгийн ерөнхий хэсэг болгон оруулж болно.

115.61(b)(7) Гэмтлийг засах, эсхүл хойшлуулах

91.503-ын дагуу агаарын хөлөгт суурилуулсан хэрэглэл, төхөөрөмж нь ажиллах боломжтой нөхцөлтэй байх ёстой, гэхдээ 91.537-д ажиллагаагүй төхөөрөмж, эсхүл хэрэглэлтэй агаарын хөлгийн тогтмол үйл ажиллагааг зөвшөөрөхийн тулд MEL гаргахыг заасан.

Энэ заалт нь хүсэлт гаргагчийг ТҮ-ний үед илэрсэн гэмтлийг бүртгэх, засах журамтай байхыг шаарддаг. Үүнд нисгэгчийн илрүүлсэн, үйлчилгээнд байхад, ердийн нислэгийн өмнөх болон нислэгийн дараах шалгалтаар илэрсэн гэмтэл багтана.

Эдгээр журмаар дараахийг баталгаажуулж бичсэн байх ёстой:

- (a) аливаа гэмтлийг бүртгэж, тухайн агаарын хөлгийг мэргэшсэн этгээд зөвшөөрсөн өгөгдлийн дагуу шалгаж, ашиглалтад шилжүүлнэ;
- (b) боломжтой бол гэмтэлтэй зүйлд зурагт хуудас хавсаргасан;
- (c) ТҮ-ний бүртгэлд тодорхойлсон гэмтэлд нисгэгчид агаарын хөлгийн ТҮ-ний статус мөн аливаа хамаарах нөхцөл, хязгаарлалтыг тодорхой заасан байна;
- (d) ашиглалтад шилжүүлэх мэдэгдлийг ТҮ-ний бүртгэлд хийж, агаарын хөлгийг зөвшөөрсөн өгөгдлийн дагуу шалгасан, эсхүл зассан болон ашиглалтад шилжүүлснийг бататгана.

ТАЙЛБАР: 91.615(a)(1)(ii)-т шаардсан НТЧ-ын шалгалт нь хөлс, эсхүл шан урамшуулалттай үйл ажиллагаанд (үүнд мөн ЧНҮА-ны агаарын хөлөг багтана) байгаа бүх тусгай ангиллын агаарын хөлгийг НТЧ-ын шалгалтанд орохыг шаарддаг.

115.61(b)(8) Бүртгэлийг хадгалах

Энэ заалт нь ТҮ-ний бүртгэл, өгөгдөлд хийсэн ишлэл болон ашиглалтад шилжүүлэхээр гэрчилгээжүүлсэн этгээдийн нэрийг хадгалахтай холбоотой. Энэ заалт нь ИНД-43.69, 91.617, 91.619, 91.623, 91.621 болон АС91-6-тай шууд холбоотой. Журмыг дараах элементэд хувааж болно:

- Гүйцэтгэсэн ажлын тодорхойлолт. Энэ нь ТҮ-ний бүртгэлийн дэвтэр, ТҮ-ний ажлын хуудас, эсхүл дэвтэрт оруулах тэмдэглэгээ хэлбэрээр байж болно. Ажлын дэлгэрэнгүй тодорхойлолт нь ажлын бүрэн тодорхойлолт, эсхүл тухайн ажлыг гүйцэтгэхэд ашигласан хүлээн зөвшөөрөхүйц өгөгдөлтэй товч тодорхойлолт байж болно. Энэ нь үйлдвэрлэгчийн үйлчилгээний заавар, үйлчилгээний бюллетин, ТҮ-ний заавар, эсхүл нэмэлт маягийн гэрчилгээнд байгаа зааварчилгаа байж болно. Энэ бол 43.69-ийн шаардлага.
- ТҮ-ний дэлгэрэнгүй мэдээллийг ТҮ-ний бүртгэлийн дэвтэрт бүртгэж болно. Гэмтлийг ТҮ-ний ердийн төвөөс ангид залруулах ёстой тохиолдолд ихэвчлэн ингэж бүртгэнэ. Техникийн дэвтэр, эсхүл агаарын хөлгийн дэвтэрт оруулахад хэтэрхий их дэлгэрэнгүй мэдээлэл байвал нэмэлт ажлын бүртгэлийг ашиглана. Аливаа тохиолдолд гэмтлийг арилгасан тэмдэглэл техникийн дэвтэрт үлдэх ёстой.
- ТҮ-ний ажлын дэлгэрэнгүйг бүртгэхэд ажлын бүртгэл, эсхүл ТҮ-ний бүртгэлийн дэвтрийг ашиглах бол эдгээр бүртгэлийн талаарх лавлагааг агаарын хөлгийн дэвтэрт оруулж өгөх ёстой. ТҮ-ний бүртгэлийн дэвтрээс агаарын хөлгийн дэвтэр рүү мэдээллийг шилжүүлэх ажлыг хөнгөвчлөх үүднээс ИНЕГ нь ТҮ-ний бүртгэлийн дэвтэртэй хамт ашиглах ТҮ-ний бүртгэлийн маягт (САА400)-ыг батлан гаргасан болно. Энэ маягт нь таслан авч үлдэх давхар бүртгэлийг хангах юм.
- ТҮ-ний бүртгэлийг хадгалах хугацааг 91.623-т заасан бөгөөд агаарын тээвэрлэгч тэдгээрийг заасан хугацаанд хадгалах үүрэгтэй. Зарим тохиолдолд ТҮ-ний байгууллага ТҮ-ний бүртгэлийг өөрсдийн өмч гэж үздэг. Энэ бол тийм тохиолдол биш бөгөөд агаарын хөлгийн амьдралын явцад гарсан бүх ТҮ-ний бүртгэлийг агаарын хөлгийн эд анги гэж үздэг учраас агаарын хөлгийн бүртгэлийн гэрчилгээг эзэмшигч этгээдийн өмч юм.
- ТҮ-ний бүртгэлийн шилжүүлэг нь бүртгэлийг өөр этгээдэд шилжүүлж байгаа тохиолдолд Монголын бүртгэлийн гэрчилгээ эзэмшигчийн үүрэг юм. Энэ талаар 91.621-д заасан.

115.62 Эмийн бодис болон согтууруулах ундааны хөтөлбөр

ИНЕГ нь эмийн бодис, согтууруулах ундаа болон бусад бодисоос ажлын байранд чадваргүй гүйцэтгэл хийхийг огт тэвчихгүй байхыг зорьдог бөгөөд чөлөөт нисэхийн салбар ч гэсэн тэр зорилгыг тавина байх.

Эмийн бодис, согтууруулах ундаа, эсхүл бусад бодисын буруу хэрэглээ нь ажлын чадварыг тодорхой хэмжээгээр алдуулах бөгөөд ажлын чадварын ямар нэг хэмжээгээр алдахыг хүлээн зөвшөөрөхгүй.

Энэ заалтын зорилго нь:

- (a) эмийн бодис, согтууруулах ундааг буруу хэрэглэснээр аюулгүй байдалд учруулах эрсдэлийг багасгах;
- (b) аюулгүй байдалд шууд нөлөөлөх ажилтай этгээд эмийн бодис, согтууруулах ундаа сөргөөр нөлөөлсөн байдалтай ажлаа гүйцэтгэх, гүйцэтгэхээр бэлэн байхаас сэргийлэх.

Эмийн бодис болон согтууруулах ундааны хөтөлбөр боловсруулахдаа, үйл ажиллагаа эрхлэгч нь дараах сэдвийг багтаах ёстой:

Бодлого - байгууллага нь эмийн бодис, согтууруулах ундаагүй ажлын газар болох талаар үүрэг, хариуцлага зорилго тавьж, түүндээ хэрхэн хүрэх талаарх байгууллагын байр суурийг бичгээр бодлого болгон гаргасан байна.

Хэрэгжүүлэлт - ямар ажил нь аюулгүй байдалд шууд нөлөөлөх, тийм учраас хөтөлбөрийн ажиглах, шалгах шаардлагын нарийн чанд байдалд багтахыг тогтооно. Гэхдээ үйл ажиллагаа эрхлэгч нь бүх ажлын байрыг эмийн бодис, согтууруулах ундаагүй байх ёстой гэж эрүүл мэнд болон аюулгүй байдлын үүрэгтэй хослуулан үзэж, эдгээр шаардлагыг гарах үр дагаврын хамт тодорхойлж болно.

Үүрэг хариуцлага - энэ нь гарч болох нөхцөл болон байгууллага хэрхэн арга хэмжээ авах тухай дэлгэрэнгүй мэдээлэл. Жнь: дараах тохиолдолд—

- Ажилтан ажилдаа ирэхэд тухайн этгээд ажлын чадваргүй байна гэж итгэх шалтгаан байвал
- Ажиллах чадваргүй байна гэж бодож байгаа, амарч байгаа ажилтныг ажилд дуудах үед
- Ажилтанд эмч нь эм бичиж өгсөн байх
- Ажилтны шинжилгээ сөрөг биш гарах
- Ажилтны шинжилгээ эерэг гарах
- Шинжилгээний үйл явцад саад гарах
- Шинжилгээг татгалзах.

Шинжилгээ - хөтөлбөрт дараах дэлгэрэнгүй мэдээллийг оруулна:

- Шинжилгээг хэзээ гүйцэтгэх. Хамгийн багаар ажилд авахын өмнө, осол зөрчил гарсны дараа, хангалттай шалтгаантай үед, мөн хааяа санамсаргүй үед

авснаар өгөх ёстой ажилтан бүрээс жилд доод тал нь нэг удаа шинжилгээ авна.

- Шинжилгээг хэн гүйцэтгэх, ямар мэргэшилтэй байх.
- Шилжилгээний үйл явцад юу орох.
- Сөрөг биш шинжилгээний дүн бүрийн тухайд ИНХууль (1990)-ийн S27C(2)-ын дагуу ИНЕГ-ын Даргад заавал мэдэгдэхийг оруулаад авах арга хэмжээ.

Хөтөлбөрийн боловсруулалтанд байгууллагын хэмжээ, чадамжаас шалтгаална. Үйл ажиллагаа эрхлэгчийг байгууллагадаа тохирсон хандлагыг боловсруулахад туслах хэд хэдэн эх сурвалж бий. Зааварчилгаа материал ИНЕГ-ын www.caa.govt.mn сайт дээр “Эрүүл мэнд болон Аюулгүй байдал - Мэдээлэл болон Зааварчилгаа - Эмийн бодис болон Согтууруулах ундааны хөтөлбөр болон менежмент”. Зааварчилгаа материалд эмийн бодис, согтууруулах ундаа болон бусад бодисоос ажлын чадваргүй болох үеийн удирдлага болон зохих бодлого, журмыг боловсруулахтай холбоотой нөхцөл байна.

115.62(4) энэ заалт нь аюулгүй ажиллагаанд шууд нөлөөлөх ажилтай бүх этгээдэд хамаарна. Энэ заалтанд ажил/үүргийн жагсаалтыг зориуд оруулаагүй орхисон учир нь тухайн жагсаалтыг өөрчлөхөд гарах хууль эрх зүйн бэрхшээл ихтэй. Гэхдээ аюулгүй байдалд ямар ажил шууд нөлөөлөхийг тогтооход баримтлах шаардлага бол энгийн - хэрэв ажлыг буруу гүйцэтгэвэл үйл ажиллагааны аюулгүй байдалд нөлөөлж, зорчигч, эсхүл ажилтанд аюул учруулна. Үүнийг санаж, агаарын хөлөг, эсхүл иж бүрдлийг үйлдвэрлэх, засварлах, эсхүл угсрах, шүхрийг баглах, агаарын хөлгийг түлшээр сумлах, агаарын хөлгийн ачааллыг тооцох, эсхүл нислэгийн мэдээллээр хангах дараах ажилтныг (дүрэмд жагсаасан ажилтан дээр нэмээд) ажил нь аюулгүй байдалд шууд нөлөөлөх ажилтан гэж үзнэ. Чөлөөт нисэхийн салбар дах төрөл бүрийн үйл ажиллагаанаас болоод энэхүү жишээ нь тийм их биш байж болох бөгөөд ИНЕГ үйл ажиллагаа эрхлэгчийг тодорхой үйл ажиллагаандаа холбоотой ажил/үүргийг ялгах ёстой гэж үзнэ.

115.63 Баримт бичиг

Энэ заалтаар шаардах журам нь хүсэлт гаргагчийн ашиглах шаардлагатай бүх баримт бичгийг харгалзан үзэх ёстой. Үүнд үйлчилгээний бюллетин, НТЧ-ын удирдамж, ТҮ-ний заавар, нислэгийн заавар болон үйл ажиллагааны гарын авлагыг багтаасан Ерөнхий заавар зэрэг бүх чухал техникийн өгөгдлийг оруулсан байх ёстой.

Журамд аливаа нэг баримт бичгийг хэрхэн системд оруулж, шалгаж, зөвшөөрөх, өөр баримт бичгийг орлож байгаа тохиолдолд хүчингүй болсон баримт бичгийг хэрхэн чөлөөлөх талаар заасан байх ёстой. Баримт бичигт тэмдэглэх зарим хэлбэрийг ашиглан, хяналтын үйл явцаар орсныг үзүүлнэ.

115.65 Ажилтны бүртгэл хөтлөх

Энэ заалтаар шаардсан журам нь хүсэлт гаргагчийг ашиглах шаардлагатай бүх ажилтны бүртгэлийг харгалзан үзэх ёстой. Эдгээрт гэрчилгээ, эсхүл зэрэглэлтэй байх шаардлагатай бүх этгээд, ИНЕГ-ын Даргын томилсон, эсхүл гэрчилгээ эзэмшигчээс олгосон эрхийг хэрэгжүүлж байгаа төлөөлөгч бүгд багтах ёстой. Үүнд нэр дэвшүүлсэн удирдах ажилтан багтаж болно. Бүртгэлд дүрмээс шаардах мэдээлэл багтах ёстой бөгөөд дүрэмд заасан тодорхой хугацаагаар хадгална. Баримт бичгийг цаасан, эсхүл электрон хэлбэрээр хадгалж болно.

Тайлбар: Хавсралт С-ээс электрон бүртгэл, эсхүл баримт бичгийг харгалзан үзэх талаар мэдээлэл авах.

115.67 Байгууламжийн бүртгэл

Хүсэлт гаргагч нь дүрмээс шаардсан тест, шалгалт болон тохируулгыг үнэн зөв бүртгэдэг болохыг бататгах журмыг тогтоох үүрэгтэй. Эдгээр тест шаардлагатай ердийн тоног төхөөрөмжид зорчигчдыг жигнэхэд ашиглах жин, түлшээр сумлах төхөөрөмж, цаг уурын төхөөрөмж, аргамж болон өргөх төхөөрөмж багтаж болно. Үүнд хүсэлт гаргагч ТҮ-гээг өөрсдөө хийж, үйл ажиллагаа эрхлэгчийн болон ТҮ үзүүлэгчийн Ерөнхий зааврыг нэгтгээгүй бол ИНД-43, эсхүл ИНД-145-т заасан ТҮ-ний төхөөрөмжийг оруулахгүй.

Энэхүү тодорхой заалт нь ИНД-91-ийн F Бүлгийн тоног төхөөрөмжийн шаардлагаар орсон бөгөөд зөвшөөрсөн агаарын хөлгийн ТҮ-ний хөтөлбөрөөр хадгалдаг тэдгээр зүйлсийг оруулах зорилгогүй.

115.69 Нислэгийн зөвшөөрөл болон хяналт

Хүсэлт гаргагч нь ЧНҮА-ны нислэг, эсхүл цуврал нислэгт эрх олгох журмыг тогтоох ёстой. Үүнийг хэрхэн хийх талаарх зарим санал:

- Төлөвлөөгүй үйл ажиллагааны хувьд өдөр тутмын нислэгийн хуваарь болон ээлжийн хуваарь нь хангалттай болно, эсхүл үйл ажиллагаа эрхлэгч нь нисэх этгээдэд зөвшөөрөл олгож, аль нислэгийг хувь хүний нөхцөлөөр явагдахыг тогтоож болно.
- Зарим нөхцөлд үйл ажиллагааны төрөл болон тухайн багийн гишүүнд зөвшөөрсөн ажил үүргийн нөхцөлийн дэлгэрэнгүй мэдээллийг нисэх багийн гишүүнд эрхийн захиа болгон өгөх нь илүү тохиромжтой.

ЧНГ эзэмшигч нь болж байгаа бүх үйл ажиллагааг цаг үргэлж хариуцах бөгөөд ЧНГ эзэмших хүсэлт гаргагч аливаа эрх олгох системийн төрлийн нөлөөллийг харгалзан үзэх ёстой. Ямар ч тохиолдолд нэр дэвшүүлсэн удирдах ажилтан (115.51(b)(1)(i)-аас лавлах) нь нислэг, эсхүл цуврал нислэгийн бүх байдлыг зөвшөөрсөн гэдэг нь тодорхой байх ёстой.

115.71 Нислэг дагах хяналтын үйлчилгээ

Энэ заалт нь хүсэлт гаргагчийг хэрэв агаарын хөлгийн хугацаа нь хэтэрвэл зохих онцгой нөхцөлийн арга хэмжээг хэрэгжүүлэх нислэг дагах хяналтын үйлчилгээний хэлбэрээр нислэг бүрийг ажигладаг болохыг бататгах журам тогтоохыг шаардана. Энэ заалт нь тухайн журамд заах асуудлыг тодорхойлно.

Энэхүү нислэг дагах хяналтын болон түгшүүрийн үйлчилгээг ихэвчлэн ИНД-172-ын гэрчилгээтэй байгууллага үзүүлдэг учир нь ихэнх нислэг нь нислэгийн төлөвлөгөөгөө НХҮ-ний нэгжид өгөх шаардлагатай байдаг. Гэхдээ ИНД-115-ын дагуу ажиллаж байгаа, нэг аэродромоос нисэн гараад буцаж ирэх, зогсохгүй нислэгийг явуулж байгаа хүсэлт гаргагч нь өөрсдөө нислэг дагах хяналтын үйлчилгээгээ зохицуулж болно.

Нислэг дагах хяналт нь компанийн үйл ажиллагааны баазад тухайн нислэг аюулгүй явагдаж байгааг болон хэрэв холбоо тасарвал онцгой нөхцөлийн идэвхижүүлэх үйлчилгээ үзүүлэх зорилготой юм. Энд үйл явцыг 115.209-өөс шаарддаг үйл ажиллагаа эрхлэгчийн онцгой нөхцөлийн арга хэмжээний төлөвлөгөөтэй холбож өгөх ёстой.

Үйл ажиллагаа эрхлэгч нь нислэг бүрийг хянах болон хугацаа нь хэтэрсэн, эсхүл алга болсон агаарын хөлгийн мэдээллийг Дарга хүлээн зөвшөөрөхүйц байгууллага (дараагийн хэсгийг харах) өгөхийг бататгах нислэг дагах хяналтын систем болон журмыг тогтоох үүрэгтэй.

Үйл ажиллагаа эрхлэгч нь бааздаа хамгийн доод тал нь 115.71(b)(1)-д шаардсан мэдээллийг хадгалах ёстой.

Үйл ажиллагаа эрхлэгч нь Ерөнхий заавартаа холбоо тогтоох боломжгүй үед авах арга хэмжээний журам оруулах ёстой. Энэ журам нь нислэгт эрх олгох этгээд нь үйл ажиллагааны бүс, гүйцэтгэх үүрэг болон агаарын хөлөг аюулгүй ажиллагаагаа үргэлжлүүлэхийг баталгаажуулах бусад нэмэлт арга замыг харгалзан үзэхийг шаардана.

Холбооны системийг асааснаар хоёр-талдаа холбоо байнга бэлэн байх ёстой. Радио хамрах хүрээгүй бүсэд нисэхдээ холбоо дахин барих 15 минутын цонхыг зөвшөөрнө. Нислэг дагах хяналтын системийг ашиглаж байгаа эсэхээс үл хамааран агаарт байх хугацаанд орон нутгийн нислэгийн мэдээллийн үйлчилгээний давтамж дээр сонсох цагийг ажиллуулахыг зөвлөдөг.

АМС 115.71 Нислэг дагах хяналтын систем

115.71(b)(3) Холбоо: Хэрэв компанийн нислэг дагах хяналтын үйлчилгээ үзүүлэгч, эсхүл үйл ажиллагааны баазтай хэт богино долгион, эсхүл богино долгионы радио холбоо байхгүй бол гар утас нь үйл ажиллагааны өндөрт үйл ажиллагааны бүсэд гар утасны хамрах хүрээ нь найдвартай бол хүлээн зөвшөөрөхөөр холбооны арга зам юм.

Олон тооны электрон ажиглах систем байдаг ба тэдгээрийг нислэг дагах хяналтын хэсэг болгон ашиглаж болно.

115.71(b)(5)(ii) Хүлээн зөвшөөрөхүйц байгууллага: Энэ нь НХҮ байгууллага, орон нутгийн цагдаагийн байгууллага, эрэн хайх, авран туслах төв, эсхүл бусад ийм төрлийн үйлчилгээ үзүүлдэг байгууллага байж болно.

Нислэг дагах хяналтын үүрэг гүйцэтгэх этгээд нь:

- (a) Сургалтанд хамрагдсан, сургалтын бүртгэлд сургалтыг бичсэн байна:
- (b) 115.71(b)(1)-д шаардсан мэдээллийг яаралтай бэлэн байлгана:
- (c) Алга болсон, эсхүл хугацаа нь хэтэрсэн агаарын хөлөгт баримтлах журмыг яаралтай бэлэн байлгана.

Тайлбар: Алга болсон, эсхүл хугацаа нь хэтэрсэн агаарын хөлгийн журам нь бүртгэл хийх цаг болон авах арга хэмжээг зааж, ингэснээр тухайн зөрчлийг бүрэн бүртгэж, мэдээллийг олох боломжтой байх ёстой.

- (d) Аливаа ашигласан гар утасны дугаар болон тухайн гар утас асаалттай байгааг батална.

115.73 Журмыг хэрэгжүүлэх

Энэ заалт нь хүсэлт гаргагчийг ИНД-115 болон холбогдох бусад дүрэмд заасан холбогдох шаардлагыг хангасан болохыг бататгах журам тогтоохыг шаардана. Хүсэлт гаргагч нь ажиллагааг хэрхэн явуулах талаар бодож, Ерөнхий заавартай ажилтны дагах ерөнхий журмыг баримт бичиг болгох хэрэгтэй. Тэд ажилтан дүрмийг дагахдаа Ерөнхий заавар болон үйл ажиллагааны журмыг ашиглана гэдгийг санах ёстой.

Журмын шаардлага нь олон хэсэгт тарж орсон байгаа бөгөөд үйл ажиллагаа эрхлэгч тэдгээрийг бүгдийг нь үзэх хэрэгтэй боловч зөвхөн өөрсдийн үйл ажиллагаанд шаардлагатай, журам тодорхой шаардсан дүрэмд журам боловсруулах ёстой.

Ажиллагаанд хамааралгүй журмыг биелэлтийн матриц дээр N/A - хамааралгүй гэж үзүүлэх хэрэгтэй, ингэснээр ИНЕГ-ын үнэлэгч нь үйл ажиллагаа эрхлэгч тэдгээртэй танилцсан гэдгийг мэдэх болно.

Том, дунд, эсхүл жижиг агаарын хөлгийн аль алийг ашигладаг үйл ажиллагаа эрхлэгч нь том агаарын (>5700кг) хөлөгтэй холбоотой бүх үйл ажиллагааг багтаасан иж бүрдэл журмыг тогтоох хэрэгтэй. Жнь: хэрэв том агаарын хөлгийн шаардлагыг биелүүлж байвал ерөнхий бүх шаардлагыг биелүүлнэ гэсэн үг бөгөөд дүрмийн хоорондох ялгааг сайн шалгах хэрэгтэй. Хөдөлгөөнгүй-далавчит онгоцны үйл ажиллагаа эрхлэгчийн хувьд чөлөөлөх бөгөөд мөн Ерөнхий зааварт оруулах шаардлагатай нисдэг тэргэнд тохирох үйл ажиллагааны төрөл байж болно.

ИНЕГ нь чөлөөт нисэхийн гэрчилгээний шаардлагыг таниулах дүрмийн матриц зохиосон. Эдгээр матрицыг ИНЕГ-ын вебсайтаас татаж авч болно.

ИНЕГ-ын дүрмийн матриц нь дараах шаардлагыг багтаасан:

- (a) ИНД-12 - осол, зөрчил, статистикийн талаар
- (b) ИНД-43 - ТҮ-ний шаардлагын талаар
- (c) ИНД-61 - Нисгэгчийн үнэмлэхний талаар
- (d) ИНД-91 - Нислэгийн үйл ажиллагааны ерөнхий дүрмийн талаар
- (e) ИНД-115 - Гэрчилгээжүүлэлтийн талаар
- (f) ИНД-141 - Сургалтын байгууллагын талаар.

Зарим дүрэмд хязгаарлалт, заавал биелүүлэх шаардлага, үйл ажиллагаа эрхлэгч “бататгах” ёстой асуудал болон журмыг тогтоох бүсийн талаар заасан байдаг.

Заавал биелүүлэх шаардлага, эсхүл хязгаарлалтыг заасан, дүрэм нь тодорхой бол үйл ажиллагаа эрхлэгч тухайн дүрэм, эсхүл дүрмийн хэсгийг Ерөнхий заавартаа дахин оруулах шаардлагагүй.

Үйл ажиллагаа эрхлэгчид ажилтан нь эдгээр дүрмийн хамрах хүрээнд ажиллах дүрмийн мэдлэг, чадвартай байгааг бататгах сургалтын болон ур чадварыг шалгах хөтөлбөртэй байх ёстой. Сургалт болон ур чадварын тестийн хөтөлбөрийг үйл ажиллагаа эрхлэгч үйл ажиллагааг дүрмийн хамрах хүрээнд явуулж байгаад сэтгэл ханамжтай байхад ашиглаж болно.

Хүсэлт гаргагч нь дүрмийн шаардлагыг хангаж байгааг бататгах шаардлагатай тохиолдолд журам хэрэгтэй болж болно. Өөрөөр, сургалт болон ур чадварыг шалгах хөтөлбөр нь дотоод аудитын байгууллагын удирдлагын тогтолцооны тусламжтай тухайн байгууллага дүрмийн биелэлтээ хангалттай гэж үзэж болно.

Гэрчилгээ эзэмшигчид нь олон дүрэм, шаардлагын биелэлтээ үзүүлэх шаардлагатай болно. Сургалт болон ур чадварыг шалгах хөтөлбөрийн бүрэн хэрэглэгээ нь үүнд тусална (Е Бүлгээс харах).

Үйл ажиллагаа эрхлэгч нь дүрмийн элементийг сургалт болон ур чадварыг шалгах хөтөлбөрөөр хангаж байгаагаа баталгая гэвэл эдгээр зүйлсийг сургалтын хөтөлбөрт оруулж, ур чадварын шалгалтын асуултын багцад оруулах хэрэгтэй. Хэрэв олон тооны зүйлсийг шилжүүлвэл хянах зүйлсийг боломжийн хэмжээтэй хэсэгт бүлэглэн, ээлжлэх хэлбэрээр ашиглаж болно.

Журам боловсруулах

Журам нь янз бүрийн хэлбэртэй, шаардлагатай бол нарийн дэлгэрэнгүй, эсхүл товч байж болно. Энэ талаар олон ном бичигдсэн байдаг бөгөөд үйл ажиллагаа эрхлэгч нь зорилгодоо ямар ч хэлбэрийг ашиглаж болох бөгөөд энэ нь:

- Доор дурьдсан хэлбэртэй;
- Урсгал график хэлбэртэй;
- Шалгах хуудсанд орсон;
- Гүйцээж бичих хэлбэрээр орсон;
- Сонсох, эсхүл харах үзүүлэнгийн хэлбэрээр байж болно (видео г.м.).

Тухайн этгээдийн сургалт, туршлага, эсхүл мэргэшлийн түвшин нь аливаа журмын гүн гүнзгий хамрах хүрээнд нөлөөлнө. Үр дүнтэй байлгахын тулд журам нь гүйцэтгэх ажил үүргийг хэн, юу, хэзээ, хаана, яагаад, яаж гүйцэтгэх вэ гэдгийг зааж өгөх ёстой. Журмын бүрэлдэхүүнийг үзүүлэх нэг арга замыг ингэж дүрсэлж болно:

Хэн:

- (1) Журмыг хэнд зориулсан
- (2) Хэн журмыг хэрэгжүүлэх
- (3) Журмын хэрэгжилтийг хэн хянах үүрэгтэй - этгээд, байгууллага

Юу:

- (1) Журам юуны тухай
- (2) Журмаар юунд хүрэх зорилготой
- (3) Журмыг гүйцэтгэж байгаа этгээд юу хийх ёстой

Хэзээ:

Журмыг хэзээ гүйцэтгэх

Хаана:

Журмыг хаана гүйцэтгэх

Яагаад:

Журам яагаад шаардлагатай

Яаж:

- (1) Журмыг яаж гүйцэтгэх - тодорхой гарын авлага, үйл ажиллагаа эрхлэгчийн хөтөлбөр, бусад баримт бичиг
- (2) Тухайн этгээд ямар журмыг ашиглах, гүйцэтгэсэн эсэхээ хэрхэн тодорхойлох.

Журам тогтоох өөр нэг арга зам нь ISO -Олон улсын Стандартчлалын Байгууллагын стандарт маягтыг ерөнхийд нь дагаж мөрддөг дараах маягтыг авч хэрэглэж болно. Журамд бүх элемент нь шаардлагагүй учраас өөр өөр байж болно.

Бодлого: Энэ хэсэгт тухайн сэдэвтэй холбоотой компанийн бодлогыг бичгээр оруулна. Энэ нь давтагдах шинжтэй байж болно, зарим тохиолдолд гүйцэтгэх захирлын ерөнхий бодлогын мэдэгдэлд багтсан байж болно.

Зорилго: Энэ нь журам, эсхүл үйл явцын зорилгыг илтгэнэ.

Хамрах хүрээ: Энэ нь журам, эсхүл үйл явцын хүрээ, эсхүл хязгаарлалтыг заана.

Үүрэг хариуцлага: Энэ нь журам, эсхүл үйл явцын хүрээ, эсхүл хязгаарлалтыг заана.

Лавлах: Энэ нь журам, эсхүл үйл явцын гүйцэтгэлд шаардлагатай бусад баримт бичиг, эсхүл лавлах материалыг лавлахаар оруулах бөгөөд аливаа чөлөөлсөн байдлыг бас оруулна.

Бүртгэл: Энэ нь бөглөх ёстой аливаа бүртгэл, эсхүл маягтыг таниулна. Жнь: нислэг болон ажлын бүртгэл, ачааллын хуудас, эсхүл техникийн бүртгэл г.м.

Үйл явц, эсхүл журам: Энэ нь үйл явц, эсхүл журмын зорилгыг биелүүлэх, үүргийг биелүүлэх тайлбар, эсхүл зааварчилгаа юм.

Журмыг энэ байдлаар, эсхүл үйл ажиллагаа эрхлэгчийн хүссэн үр дүнд хүрэхээр бусад арга замаар чиглүүлж болно. Тэд их ангийн, эсхүл нилээд төвөгтэй байж болно, энэ нь хүрэх гэж байгаа үр дүнгээс шалтгаална. Эдгээр нь бичсэн тодорхойлолт, урсгал диаграм, эсхүл шалгах хуудас бөглөх хэлбэрээр байж болно. Урсгал диаграм, эсхүл шалгах хуудасны хувьд заавар нь их энгийн байж болно.

Зарим тохиолдолд 115.203, 115.205, эсхүл 115.215 г.м зарим зүйлсийг оруулах нь зүйтэй байж болно. Эдгээр дүрэм нь журам боловсруулахыг шаардахгүй, гэхдээ агаарын тээврийн үйл ажиллагаа гүйцэтгэх этгээдийг дүрмийн шаардлага мөрдөхийг шаарддаг.

Журам нь хууль зүйн биелэлтийг хангахын тулд хангалттай мэдээлэлтэй байх ёстой. Энэ нь бусад холбоотой дүрмийн лавлагаа болон хязгаарлалтыг анхдагч журамд орсон байна гэсэн үг байж болно.

Энэ нь үйл ажиллагааны үүрэгтэй холбоотой хэсэгт нэгтгэсэн журамд нөлөөлөх бөгөөд дүрэм болгонд журам гаргах шаардлагаас гаргахад тусална.

115.75 Осол, зөрчлийг мэдээлэх

Энэ заалт нь хүсэлт гаргагчаас ИНД-12-ын дагуу бүх зөрчлийг мэдээлэх, шинжлэн шалгах болон тайлан гаргахад шаардлагатай журмыг тогтоохыг шаардана.

115.77 Байгууллагын удирдлагын тогтолцоо

Хэмжээнээс шалтгаалахгүй хүсэлт гаргагч нь байгууллага үр дүнтэй ажиллаж байгааг бататгах тогтолцоотой байх ёстой. Жижиг байгууллагын хувьд энэхүү тогтолцоо нь тэдний нийтлэг бизнесийн туршлагад аль хэдийн байж болно.

Энэ дүрэм нь чөлөөт нисэхийн үйл ажиллагаа эрхэлж байгаа байгууллагыг ИНД-115-т шаардсан журам нь шаардлага хангасан ба түүнийг хэрэгжүүлж байгааг бататгах байгууллагын удирдлагын тогтолцоотой байхыг шаардана.

Хүсэлт гаргагч нь тогтолцоог хэтэрхий хүндрүүлэх, эсхүл үйл ажиллагаанд нь чухал хамаагүй зүйлсийг танилцуулахаас санаа зовох ёсгүй. Байгууллагын удирдлагын тогтолцоо нь үйл ажиллагаанаас тусдаа байх ёсгүй, гэхдээ үйл ажиллагаа эрхлэгчийн бизнесийн стандарт туршлагын нэг хэсэг болох ёстой.

Жижиг байгууллага

2, эсхүл түүнээс цөөн баазаас 3, эсхүл түүнээс цөөн агаарын хөлгөөр үйл ажиллагаа гүйцэтгэдэг гэж тодорхойлдог жижиг байгууллагад удирдлагын тогтолцоо шаардлагатай, гэхдээ 115.77(с)-т шаарддаг байгууллагын удирдлагын тогтолцооны элементийг оруулахыг шаардахгүй. Жижиг байгууллага нь сайн дураараа 115.77(с)-ын зарим элементийг авч хэрэгжүүлж болно, гэхдээ том байгууллага болон өргөжөөгүй тохиолдолд дүрмийн аль нэг, эсхүл бүх элементийг хэрэгжүүлэхийг шаардахгүй.

Том байгууллага

2-оос дээш баазаас 3-аас дээш агаарын хөлөг ашиглаж байгаа томхон байгууллагын хувьд 115.77 (с)-ын элементийг багтаасан баримт бичигтэй удирдлагын тогтолцоотой байх ёстой бөгөөд шаардлагатай ажиллагаа нь үр дүнтэй, аюулгүй байхыг баталгаажуулах бодлого, журамтай байх ёстой.

Жижгээс том руу

Хэрэв компани нь хэмжээгээ өөрчилж, жижгээс том үйл ажиллагаа руу орвол цогц байгууллагын удирдлагын тогтолцоотой болох ёстой.

115.77(с)-ын дагуу цогц удирдлагын тогтолцоотой болох шаардлагагүй үйл ажиллагаа эрхлэгч нь байгууллагын хүрээгээ ихэсгэж, одоо удирдлагын тогтолцоо шаардлагатай болсон бол:

- (1) Ерөнхий заавраа өөрчилж, 115.77(с)-т заасан байгууллагын удирдлагын тогтолцоотой болно;
- (2) ЧНҮА-ны нэмэгдсэн түвшинг эхлүүлэхийн өмнө тухайн тогтолцоог ИНЕГ-ын Дарга хүлээн зөвшөөрөхүйц болохыг бататгана.

115.77(с)(4) болон (5) нь аюулыг таних болон эрсдэлийн үнэлгээний элементийг танилцуулдаг. Хүсэлт гаргагч нь хийхээр төлөвлөсөн үйл ажиллагааны аюул болон оролцогчид оногдох эрсдэлийн түвшинг үнэлж, оролцогчид тулгарах аюул/эрсдэлийг багасгах, арилгах арга хэмжээ авна. Аюул болон эрсдэлийн үнэлгээний журмыг боловсруулах талаар зааварчилгааг Монгол Улсын Стандарт хэмжил зүйн газраас болох MNS ISO 31000:2009-аас харж болно. Аюулыг таньж, эрсдэлийг удирдахдаа байгууллага нь мөн Хөдөлмөрийн Хуулийн Эрүүл мэнд болон Аюулгүй байдлын шаардлагын мөн оруулах, эрсдэлийг арилгах, тусгаарлах, багасгахын тулд (энэ дарааллаар) “бүх боломжтой арга хэмжээ”-г авахыг баталгаажуулна. Хүсэлт гаргагч нь <http://www.osh.govt.nz/order/catalogue/808.shtml>-ээс “Эрүүл мэнд болон Аюулгүй Ажиллагаа -Хөдөлмөрийн Хуулийн зөвлөмж” хэвлэлийг лавлаж болно.

115.79 Чөлөөт нисэхийн үйл ажиллагаа эрхлэгчийн Ерөнхий заавар

Ерөнхий шаардлага

Хүсэлт гаргагч нь Ерөнхий зааврыг үйл ажиллагаа нь хэрхэн явагдах ерөнхий тодорхойлолт мөн ажилтныг үүргээ хэрхэн гүйцэтгэх талаар зааварлах арга зам гэж үзэх ёстой. Зөв бичсэн Ерөнхий заавар нь тодорхой бөгөөд их үр дүнтэй байна.

Ерөнхий зааврын зорилго бол байгууллагыг ажиллуулах Гүйцэтгэх захирлын шаардлагыг тодорхойлж, байгууллага хэрхэн дүрмийн шаардлага хангахыг заах ёстой. Энэ нь гэрчилгээтэй байгууллагын журам, хэлбэр, аргыг харуулдаг. Ерөнхий зааврын философийн үр нөлөө маш их бөгөөд чөлөөт нисэхийн аюулгүй байдалд чухал нөлөөтэй. Нисэхийн төвөгтэй шинж чанар нь үйл ажиллагаа эрхлэгчийн мэдээгүй журмын тайлбарыг нэмэгдүүлж болно, үүнд дүрэмд ордог өөрчлөлт, агаарын зайн, хэрэгжилтийн шаардлага г.м, мөн тэдэнд Ерөнхий заавраас өгөх ёстой шинэчлэх систем шаардлагатай.

Ерөнхий заавар бол байгууллага үйл ажиллагаагаа тодорхойлж, ажилтандаа болон ИНЕГ-т өдөр тутмын ажлаа хэрхэн явуулах, дүрмийн хэрэгжилтийг бататгах хэлбэр болон аргыг харуулах зам мөн.

Олон гэрчилгээ

Байгууллага бүгдээрээ Ерөнхий заавар шаардах (жнь: ИНД-115, 141, болон 145) нэгээс илүү дүрмээр гэрчилгээжих гэж байгаа бол Ерөнхий зааврын зарим хэсгийг гэрчилгээ бүрд адилхан байлгаж болно. Жнь: ижил удирдлагыг бий болгон гэрчилгээ бүрд ашиглаж байгаа бол, Ерөнхий зааврын удирдлагын хэсэг нь ижил байж болно. Мөн нэг, эсхүл түүнээс дээш гэрчилгээний байгууллагын удирдлагын тогтолцоо/чанар баталгаажуулалтын бүх журмыг нэг гарын авлагад оруулж болно.

Ерөнхий заавар нь гүйцэтгэх захирлын корпорацийн дагаж мөрдөх зүйлээр эхлэх ёстой. Ерөнхий зааврын үлдсэн хэсгийг төлөвлөсөн үйл ажиллагааны хамрах хүрээнээс шалтгаалан тусдаа олон журам, хэсэг болгох, эсхүл нэг энгийн баримт бичиг болгон боловсруулж болно.

Байгууллагын бүтэц, хэмжээнээс шалтгаалан, Ерөнхий зааврын хэсгийг дараах байдлаар зохицуулж болно:

- (1) менежментийн бодлого
- (2) үйл ажиллагаа
- (3) сургалт
- (4) ТҮ-ний журам
- (5) байгууллагын удирдлагын тогтолцоо
- (6) гэрээний зохицуулалт
- (7) онцгой нөхцөлийн арга хэмжээний төлөвлөгөө

Тусдаа гарын авлага нь Ерөнхий зааврын менежментийн хэсэгт давхар лавлагаа болох ёстой.

ИНЕГ нь үйл ажиллагаа эрхлэгчид зааврын иж бүрдлийг хэрхэн хийх талаар хэлж өгөхийг хүсэхгүй байгаа боловч, туршлагаас харахад дээд төвшний менежментийн заавар, ихэвчлэн менежментийн бодлогын заавартай байх нь илүү хэрэглэгч хэрэглэхэд дөхөмтэй Ерөнхий заавар болдог. Энэхүү дээд төвшний гарын авлагатай холбоотой бусад холбоотой гарын авлага бүгд дараах байгууллагын мэдээллийг агуулна:

- (1) корпорацийн мэдэгдэл
- (2) зааврын шатлалын тодорхойлолт
- (3) шаардлагатай удирдах ажилтныг таниулсан байдал
- (4) байгууллагын жагсаалт
- (5) удирдах ажилтны үүрэг хариуцлага
- (6) Ерөнхий зааврыг өөрчлөх үйл явц
- (7) үйл ажиллагааны хамрах хүрээ
- (8) байгууллагын удирдлагын тогтолцоо

ИНД-115-ын болон бусад дүрмийн, ялангуяа ИНД-145-ын Ерөнхий зааврын агуулгын хооронд будлиан байх ёсгүй. Үйл ажиллагаа эрхлэгч эдгээр 2 гэрчилгээтэй бол, ТҮ-ний шаардлага нь дангаараа ИНД-115-ын Ерөнхий заавар дотор багтах бөгөөд ИНД-145-ын Ерөнхий зааварт орохгүй.

Удирдах ажилтан нь өөрсдийн үүрэгт нөлөөлөх хэсгийн хувийг авсан байх ёстой бөгөөд ажилтан нь өөрсдийн ажилтай холбоотой, Ерөнхий зааврыг хэсэгтэй танилцсан байх ёстой.

Ерөнхий зааврын ямар ч хэлбэрийг сонгосон байсан, холбогдох дүрмийн элемент бүрийг хэрхэн биелүүлж байгааг үзүүлсэн байх ёстой. ИНЕГ-ын үнэлгээний төлбөрийг багасгах, мөн бүх шаардлагатай дүрмийг оруулснаа баталгаажуулахын тулд ИНЕГ-ын бүрэн дүрмийн биелэлтийн матриц Ерөнхий зааврыг дагалдана. Энэ матриц нь ИНЕГ-т 11, эсхүл ИНЕГ-ын www.caa.govt.nz вебсайтын “Маягт” хэсэгт бий. Биелэлтийг тогтооход гарсан аливаа хүндрэлийг ИНЕГ шалгахад хугацаа хэрэгтэй бөгөөд хүсэлт гаргагчаас нэмэлт зардал гарна.

115.79(a)(1) Гүйцэтгэх захирлын мэдэгдэл. Гүйцэтгэх захирлын мэдэгдлийг ИНЕГ-ын Дарга байгууллагаас гаргасан корпорацийн дагах мөрдөх зүйл гэж хүлээн зөвшөөрөх ёстой. Энэ нь ИНД-115-д заасан аюулгүй байдлын стандарттай холбоотой байгууллагын зорилго, зорилтыг тодорхой заах ёстой. Үүнд мөн худалдааны үйл ажиллагаатай холбоотой байгууллагын зорилго, зорилт багтана. Ерөнхий заавар нь менежментийн нэг хэрэглэл болох бөгөөд байгууллагын ажиллагааг ажилтан, үйлчлүүлэгч нар болон ИНЕГ-т үзүүлэх арга зам болох ёстой.

115.79(a)(2), (3) Удирдах ажилтан. Байгууллага доторх удирдах ажилтны албан тушаал болон нэрсийг Ерөнхий зааварт жагсаах ёстой. Үүрэг хариуцлага болон ИНЕГ-ын Даргад шууд үүрэг хүлээдэг ажлыг тодорхой заасан байна.

115.79(a)(4) Байгууллагын бүтцийн зураг. Зохимжтой бол, байгууллагын мэдээлэх шугамыг үзүүлсэн байгууллагын бүтцийн зураг байх ёстой. Бүтцийн зураг нь нэр дэвшүүлсэн удирдах ажилтнаас гүйцэтгэх захиралд үүрэг хүлээх шугамыг үзүүлнэ. Ерөнхий заавар нь агаарын ажиллагаа явуулах гэж байгаа байгууллагын газар бүрд ажилтны зохицуулалтыг үзүүлнэ.

115.79(a)(5) Үйл ажиллагааны үндсэн байрлалын дэлгэрэнгүй мэдээлэл. Байгууллага нь үйл ажиллагааны үндсэн байрлалын дэлгэрэнгүй мэдээллийг өгөх шаардлагатай. Энэ байрлал нь ерөнхийдөө “үйлчилгээний хаяг” (Хуулийн хэсэг 8-аас лавлах) дээр байдаг бөгөөд байгууллагын захиргаа болон үйл ажиллагааны төв юм. Үүнд мөн байгууламжийн бодит шинж чанарын тодорхойлолт орсон байх ёстой. Зарим тохиолдолд, жинхэнэ ажиллагаа явуулах байрлал нь тусдаа байж болно, тийм тохиолдолд тэр газрын бас заана. Энэ заалт нь мөн ТҮ-ний үндсэн баазын дэлгэрэнгүй мэдээллийг шаарддаг.

115.79(a)(6) Дэлгэрэнгүй журам. Энэ заалт нь тусгай журмыг заадаггүй учраас хүсэлт гаргагч нь дүрмийг шалгаж, журам шаардлагатай бөгөөд үйл ажиллагаа эрхлэгчийн байгууллага, төлөвлөсөн ажиллагаатай хамаатай бүх дүрмийн шаардлагыг хангахыг шаардана. Журам нь үйл ажиллагаатай холбоотой байгууллагын туршлагыг тодорхой оруулсан байх ёстой.

Эдгээрийн жишээ нь:

- нислэгийн төлөвлөлт;
- шислэг болон ажлын цагийг зохицуулах, бүртгэх;
- зорчигчийн сургалт болон зааварчилгаа
- нислэг дагах
- онцгой нөхцөлийн арга хэмжээний төлөвлөгөө
- нисэх болон газрын багийн сургалт
- гэмтлийг бүртгэх, хянах.

Журмыг боловсруулах талаарх зааврыг 115.73-аас лавлах.

Сонирхогчийн нислэгийн олон төрлийн үйл ажиллагаа байдаг учраас, хүсэлт гаргагч бүр явуулах үйл явуулахтай холбоотой журмын дэлгэрэнгүй өөрсдөө тодорхойлох хэрэгтэй болно. Бүх хүсэлт гаргагч нар нь тодорхой хүрээ, төлөвлөсөн ажиллагаанд хамаарах хүрээнд шаардлагыг оруулах ёстой.

115.79(a)(7) ТҮ-ний шаардлага. Энэ дүрмээс шаардсан журмыг 115.59 болон 115.61-ын зааварчилгаа хэсэгт оруулсан бөгөөд энэ талаарх лавлагаа оруулах ёстой.

Гэхдээ 115.79(a)(7)(iii) нь хүсэлт гаргагчийг өөрийн агаарын хөлөгт ТҮ үзүүлдэг ТҮ-ний байгууллага бүрийн дэлгэрэнгүй мэдээллийг бүртгэхийг шаарддаг (үүнд шүхэр болон

параглайдер багтана). Энэ зорилгоор хавсралт ашигласнаар гарсан өөрчлөлтийг хялбар оруулах боломжтой учраас санал болгодог.

115.79(a)(8), (9), (10) Бусад дэлгэрэнгүй мэдээлэл. ИНД-115-ын хаа нэг газар шаардсан болон ерөнхийдөө илүү байгууллагад үндэслэн журам болон хөтөлбөр байна, үүнд:

- эмийн бодис болон согтууруулах ундааны хөтөлбөр. 115.62-ын зааварчилгааг лавлах.
- нислэгийн болон үүрэг гүйцэтгэх цагийн хуваарь. 115.405-ын зааварчилгааг лавлах.
- зорчигчийн сургалт болон зааварчилгаа. 115.205-ын зааварчилгааг лавлах.
- онцгой нөхцөлийн арга хэмжээний төлөвлөгөө. 115. 209-ын зааварчилгааг лавлах.
- нисэх багийн болон газрын багийн гишүүдийн сургалтын хөтөлбөр. 115.303-ын зааварчилгааг лавлах.
- нисэх багийн болон газрын багийн гишүүдийн ур чадварыг үнэлэх хөтөлбөр. 115.405-ын зааварчилгааг лавлах.

115.79(a)(11) Ерөнхий зааврын өөрчлөлт. Ерөнхий зааврыг хянах, нэмэлт өөрчлөлт оруулах болон түгээхийн өмнө ИНЕГ-ын Даргаас урьдчилан зөвшөөрөл авах ёстой 115.109-т шаардсан өөрчлөлт болон ИНЕГ-ын Даргаас урьдчилан зөвшөөрөл авах шаардлагагүй өдөр тутамд болдог маршрутын өөрчлөлтийг хийхэд шаардлагатай өөр өөр үйл явцыг харгалзан үзэх хэрэгтэй. Журмыг хэрэгжүүлэхийн тулд 115.73-ын зааварчилгааг ашиглах.

С Бүлэг - Үйл ажиллагааны хязгаарлалт болон шаардлага

115.101 Байнгын хэрэгжилт

Энэ заалт нь ЧНГ эзэмшигчийг 115.13-т шаардсан Үйл ажиллагааны тодорхойлолтыг дагаж мөрдөхийг шаардана. Энэ заалт нь мөн гэрчилгээ эзэмшигч гэрчилгээ эзэмшигчийн дүрэмд заасан холбогдох шаардлагыг дагаж мөрдөх, стандартыг тогтмол хангах, эзэмшигчийн Ерөнхий зааварт байгаа журам, хөтөлбөрийг дагаж мөрдөх, эзэмшигчийн Үйл ажиллагааны тодорхойлолтын хүчинтэй хувь болох эзэмшигчийн Ерөнхий зааврын хувийг заасан байрлалд хадгална. Бүрэн дэлгэрэнгүй мэдээллийг дүрмээс лавлах.

115.103 Нисэх багийн гишүүний мэргэшил

ЧНГ эзэмшигч нь аливаа этгээд ИНД-115-т шаардсан зохих зөвшөөрөл, зэрэглэл, эсхүл гэрчилгээтэй тохиолдолд нисэх багийн гишүүний үүрэг гүйцэтгэнэ. Энэ тохиолдолд нисэх багийн гишүүнд тандем шүхрийн мастер багтана. Зохих нисгэгчийн зөвшөөрөл, гэрчилгээ, эсхүл зэрэглэлгүй этгээд нисэх багийн гишүүнээр ажиллахгүй.

115.105 Бизнесийн, эсхүл худалдааны нэр

115.105(a) ЧНГ-г эзэмшигч нь эзэмшигчийн ЧНГ-т байгаа худалдааны, эсхүл бизнесийн нэрийг ашиглан ЧНҮА явуулах үүрэгтэй.

115.105(b) Үйл ажиллагаа эрхлэгч нь үйл ажиллагааг гүйцтгэхийн өмнө зорчигчид гэрчилгээ эзэмшигчийн бизнесийн, эсхүл худалдааны нэрийг тодорхой үзүүлэх зарим арга замыг олсон байх ёстой. Энэ нь агаарын хөлгийн үйл ажиллагааны хувьд агаарын хөлгийн орох хэсэгт түлшний хэсгийн зэргэлдээ тэмдэглэгээ тавих амархан арга байна. Ханг-глайдер/параглайдер болон тандем-шүхрийн үйл ажиллагааны хувьд зарим өөр аргыг ашиглах хэрэгтэй.

115.105(c) Энэ заалт нь үйл ажиллагаа эрхлэгчийн ЧНГ дээр байдаг бизнесийн, эсхүл худалдааны нэрийг тодорхой үзүүлэх сурталчилгааг шаарддаг.

115.107 Чөлөөт нисэхийн гэрчилгээ эзэмшигчийн хязгаарлалт

ЧНГ эзэмшигч нь ЧНГ-ний эрхийн хүрээнд агаарын тээврийн үйл ажиллагаа, эсхүл тусгай зохиулалтын нисэхийн үйл ажиллагаа эрхлэхгүй байх үүрэгтэй.

115.109 Гэрчилгээ эзэмшигчийн байгууллагын өөрчлөлт

115.109(a), (b) ЧНГ эзэмшигч нь дүрэмд заасан Ерөнхий зааварт өөрчлөлт оруулахтай холбоотой шаардлагыг биелүүлэх ёстой. Дүрмээс дэлгэрэнгүй мэдээллийг лавлах.

115.109(c) Энэ заалт нь ИНЕГ-ын Даргыг ЧНГ дээр нөхцөл тавих эрхийг олгодог. Жнь: үйл ажиллагааны шинэ төрлийг төлөвлөсөн бол бататгах нислэгийг зорчигчдыг тээвэрлэхээс өмнө хийх шаардлагатай.

115.109(d), (e) нь хангалттай тайлбартай. Холбогдох дүрмээс дэлгэрэнгүй тайлбар авах.

115.111 Техник үйлчилгээний хөтөлбөрийн өөрчлөлт

ЧНГ эзэмшигч нь ИНЕГ-ын Даргын хүсэлтээр НТЧ-ын хадгалалтын өөрчлөлт шаардлагатай тохиолдолд 115.61-д шаардсан ТҮ-ний хөтөлбөрт нэмэлт өөрчлөлт оруулна.

D Бүлэг - Нислэгийн үйл ажиллагаа

115.201 Үйл ажиллагааг хязгаарлах, эсхүл түдгэлзүүлэх

115.201(а)(2), (3) Үйл ажиллагааны бүс. ЧНГ эзэмшигч нь үйл ажиллагааны тодорхойлолтод үйл ажиллагааны тойрог, эсхүл үйл ажиллагааны бүсийн газарзүйн байрлалыг нэмэгдүүлэхийн тулд үйл ажиллагааны төлөвлөсөн бүсийг тодорхой үзүүлсэн зураг, эсхүл газрын зургаар хангах ёстой. Энэ нь энгийн тойрог, эсхүл тодорхой газарзүйн цэгээр тогтоосон бүсийг оруулж болно. ИНД-115-ын хүсэлтийн маягт (САА 24115/01) нь үйл ажиллагааны бүртгэлийн нөхцөлийг заасан байна.

115.201(б) Хүн ихтэй бүс. ЧНГ эзэмшигчийн үйл ажиллагааны тодорхойлолтод заагаагүй бол ЧНГ эзэмшигч нь том, жижиг хот, суурин газар, эсхүл нээлттэй агаарт цугласан хүмүүсийн хүн ихтэй бүс дээгүүр ажиллагаа явуулж болохгүй. Хүсэлт гаргагч нь хүсэлтдөө том, жижиг хот, эсхүл хүн ихтэй бүсэд эрсдэл учруулахгүйгээр хэрхэн ажиллах гэж төлөвлөж байгаагаа үзүүлэх ёстой. Энэ эрсдлийн үнэлгээг AS/NZS ISO 31000:2009-д байгаа эрсдлийн үнэлгээний зарчим болон зааварчилгааг ашиглан хийх ёстой.

115.201(с) Аюултай нөхцөл. ЧНГ эзэмшигч нь мэдэгдсэн аюулыг арилгах, эсхүл аюулыг зайлуулах хүртэл ажиллагааг хойшлуулах ёстой. Энэ дүрмээр ажиллагааг хязгаарлах, эсхүл хойшлуулах эрхтэй этгээдийн ажил үүрэгт, эсхүл ажлын байрны тодорхойлолтонд чадамжийг оруулсан байх ёстой. Логикийн хувьд нислэг болон буух ажиллагаа, байгууллагаын удирдлагын тогтолцоог хариуцсан ажилтан нь шийдвэр гаргах үйл явцад оролцох ёстой. Бүх ажилтан нь хэнд ийм эрх байдгийг мэдэж байх ёстой.

115.203 Зорчигчийн аюулгүй байдал

115.203(1) Эмийн бодис болон согтууруулах ундаа. Энэ заалт нь ЧНҮА гүйцэтгэж байгаа этгээд нь эмийн бодис, согтууруулах ундааны нөлөөлөлд орсон байдалтай, эсхүл хүлээн зөвшөөрөхөөргүй зан байдлын шинж чанар үзүүлж байгаа зорчигчийг ЧНҮА-нд зорчихийг оролцуулахгүй байхыг бататгахыг шаарддаг. Газрын болон нисэх багийн гишүүн ийм нөхцөлд хэрхэн ажиллах талаар ЧНҮА-ны журамд зааварчилгаа өгсөн байх ёстой.

115.203(2) Хөгжлийн бэрхшээлтэй зорчигч. ИНД-1-д хөгжлийн бэрхшээлтэй зорчигч гэдгийг агаарын тээврийн үйл ажиллагааны үед бие махбод, эрүүл мэнд, эсхүл сэтгэхүйн нөхцөлөөс шалтгаалан ердийн зорчигчоос илүү тусгайлсан анхаарал халамж шаарддаг зорчигчийг хэлнэ гэж заасан байдаг.

Боломжтой бол хөгжлийн бэрхшээлтэй зорчигчийг дараах байрлалд хуваарилах, эсхүл суудал, байрлал эзлүүлэхгүй:

- (1) багийг ажил үүргээ гүйцэтгэхэд саад болох;
- (2) ослын төхөөрөмжид хүрэхэд саад болох;
- (3) онцгой нөхцөлийн нүүлгэн шилжүүлэлтэд саад болох.

Газрын болон нисэх багт онцгой нөхцөлийн үед хөгжлийн бэрхшээлтэй зорчигчийг хэрхэн нүүлгэн шилжүүлэх, мөн тухайн зорчигчийн тусгай шаардлагыг хэрхэн сайн биелүүлэх талаар ЧНҮА-ны журамд зааварчилгаа оруулсан байх ёстой.

115.205 Зорчигчийн сургалт болон зааварчилгаа

ИНД-91.211-ийн холбогдох шаардлагаас гадна энэ заалт нь ЧНҮА-аюулгүй байдал болон онцгой нөхцөлийн журамд зааварчилгаа, эсхүл нэмэлт сургалтыг шаарддаг. Үүнийг Ерөнхий зааврын сургалт болон зорчигчийн зааварчилгааны хэсэгт оруулах ёстой. Тэдгээр зүйлсийг дараах байдлаар ангилна-

(a) Ерөнхий:

- (i) агаарын хөлөгт туслалцаагүй хэрхэн аюулгүй орох, гарах;
- (ii) бэхэлгээг ашиглах
- (iii) сүүлний сэнс болон дээшээ налуунаас болгоомжлох
- (iv) анхан шатны тусламж болон гал унтраагуурын хэрэглээ, байрлал
- (v) сул зүйлсийг цэгцлэх
- (vi) хаалгыг нээх, хаах
- (vii) онцгой байршил дохиологчийг багтаасан онцгой нөхцөлийн журам
- (viii) байдаг бол агаарын хөлгийн интерком системийг ашиглах зэрэг багийн гишүүдийн хоорондын холбоо.

(b) Нэмэлт сургалт:

- (i) хүндийн төвийг тооцоолох
- (ii) нислэгийн буултын шат
- (iii) явуулах үйл ажиллагааны төрөлтэй холбоотой аливаа нэмэлт харгалзан үзэх зүйлс

Эдгээр нь зорчигчид нэмэлт зааварчилгаа, эсхүл сургалт шаардлагатай болох зарим үйл ажиллагааны жишээ юм.

115.207 Ослын төхөөрөмжид тавих шаардлага

Энэ заалт нь өөрөө ойлгомжтой боловч үйл ажиллагаа эрхлэгч нь дараахийг харгалзан үзэх ёстой.

ЧНГ эзэмшигч нь авран туслах ажиллагааг зохицуулах төвтэй яаралтай холбоо барихад зориулж агаарын хөлөг бүрд байдаг аврах төрөөмжийн талаарх мэдээлэлтэй байх ёстой. Мэдээлэл нь 115.71-д шаардсан нислэг дагах хяналтын үйлчилгээний нэг хэсэг болох ёстой.

Ослын болон аврах төхөөрөмжийн дэлгэрэнгүй шаардлага нь 91.526-т байна. Энэ бүх мэдээлэл нь мөн 115.209-т шаардсан онцгой нөхцөлийн арга хэмжээний төлөвлөгөөний нэг хэсэг болсон байх ёстой.

Нислэг дагах хяналтын үйлчилгээ үзүүлэгч нь үйл ажиллагаа эрхлэгчийн Ерөнхий заавраас хайж олох хэрэггүй, мэдээллийг шууд үзэж болохоор хялбар байлгах ёстой.

115.209 Онцгой нөхцөлийн арга хэмжээний төлөвлөгөө

Энэ заалт нь ЧНГ эзэмшигчийг удирдах ажилтан, газрын ажилтан, эсхүл нисэх баг мэдэж байгаа онцгой нөхцөлийг зохицуулах ажлын төлөвлөгөөгөөр хангахыг шаарддаг. Энэ заалт нь агаарт болон газар дах онцгой байдалд зориулан төлөвлөгөө зохиож, нисгэгчид болон нисгэгчээс мэдээлэл хангах нөхцөл оруулахыг шаардана.

Энэ заалтыг биелүүлэхийн тулд үйл ажиллагаа эрхлэгч нь өөрсдийн тодорхой үйл ажиллагаанд эрсдэлийн удирдлагын үнэлгээ хийх хэрэгтэй. Эрсдэлд дараах орж болно:

- нисгэгч урьдчилан тохирсон цагтаа холбоо барихгүй байх (нислэг дагах хяналтын үйлчилгээний систем);
- нисгэгч нислэгт үүссэн онцгой нөхцөлийг зарлах;
- удирдах ажилтан, эсхүл газрын ажилтан, нисгэгчид мэдэгдэх шаардлагатай нислэг дэх нөхцөлийг мэдэх;
- хөөрөлт, эсхүл буулт үйлдэх үеийн осол, эсхүл зөрчил;
- газарт онцгой нөхцөл үүсэх (гал, түлшээр сумлах г.м);
- нисэх баг, эсхүл зорчигчийн эрүүл мэндийн байдал муудах.

Төлөвлөгөө нь зохих сургалтанд хамрагдсан ажилтан (115.53-аас лавлах) юу хийх, хэнтэй холбогдох, ямар мэдээллийг бүртгэхээ мэддэг байхыг бататгах хангалттай мэдээллийг агуулсан байх ёстой. Сургалт болон ур чадварын шалгалтын бүртгэлийг 115.65-т шаардсан бүртгэлд бүртгэсэн байна.

Онцгой нөхцөлийн арга хэмжээний төлөвлөгөөг Ерөнхий зааварт оруулах, эсхүл илүү хялбар хэрэглээг бодож тусад нь заавар болгож болно. Тусдаа гарын авлагад байгаа бол бүрэн Ерөнхий зааврыг бий болгох үйл ажиллагаа эрхлэгчийн гарын авлагад лавлагааг оруулах ёстой.

Төлөвлөгөөний үргэлжилсэн үр дүнтэй байдлыг баталгаажуулахын тулд байнга шалгаж үзэж байх ёстой.

Сургалт болон ур чадварыг шалгах шаардлагыг хангахын тулд үйл ажиллагаа эрхлэгч нь ширээн дээр онцгой нөхцөлийн арга хэмжээний төлөвлөгөөний бүх элементийг багтаасан онцгой нөхцөлийн хувилбарыг тавихаар сонгож болно.

115.211 Нислэгийн үйл ажиллагааны аюулгүй байдлын шалгалт

ЧНГ эзэмшигч нь нисэх багийн гишүүн бүрийг (үүнд тандем шүхрийн мастер багтана) нислэгийн өмнө болон нислэг бүрийн хугацаанд нислэгийн үйл ажиллагааны аюулгүй байдлын шалгах хуудастай байхыг баталгаажуулах ёстой.

ЧНГ эзэмшигч нь үйл ажиллагааны төрөлд тохирсон шалгах хуудсыг боловсруулж болно. Эдгээр шалгалт нь нислэгийн өмнөх, хөөрөхийн өмнөх, онцгой нөхцөлийн

шалгалт зэрэг байж болно, гэхдээ эдгээрээр хязгаарлагдахгүй. ИНЕГ-ын хүлээн зөвшөөрөхүйц шалгах хуудас нь агаарын хөлгийн нислэгийн гарын авлага, нмемоны зүй тогтол, эргүүлэх харах карт байж болно. Шалгах хуудасны агаарын хөлгийн ажиллагаатай холбохдоо холбогдох мэдээллийг агаарын хөлгийн үйлдвэрлэгчийн нислэгийн заавар, эсхүл үйл ажиллагааны гарын авлагаас авах ёстой.

Тогтоохтой холбоотой шалгалтыг баримтжуулж, сургалт болон ур чадварын үнэлгээний хөтөлбөрт оруулах хэрэгтэй болно.

Ерөнхий заавар нь ямар шалгалтыг ашиглах, мөн үйл ажиллагаа эрхлэгч ямар өөр хувилбарыг зөвшөөрөхийг тодорхой заана.

115.213 Нислэгийн бэлтгэл болон нислэгийн төлөвлөлт

ЧНГ эзэмшигч нь ЧНҮА-ны хувьд хөлгийн дарга нислэгийг төлөвлөх найдвартай мэдээлэл хэрэглэхэд зохих мэдээлэл бэлэн байхыг бататгах үүрэгтэй.

Энэ заалт нь нислэгийг төлөвлөх үед дараах зүйлсийг харгалзан үзэх ёстой 91.217-г агуулна:

- (a) цаг уурын мэдээлэл болон нөхцөл;
- (b) түлшний шаардлага;
- (c) хэрэв нислэгийг дуусгаж чадахгүй бол запас аэродром/буулт хийх газар;
- (d) НХҮ-нээс мэдэгдсэн, мэдэгдсэн байгаа болон гарч болох хөдөлгөөний саатал, эсхүл хязгаарлалт;
- (e) хэрэглэх гэж байгаа холбооны төхөөрөмжийн бэлэн байдал;
- (f) аэродром болон/эсхүл буулт хийх газрын одоогийн нөхцөл байдал;
- (g) аэродром, эсхүл буулт хийх газар дах агаарын хөлгийн гүйцэтгэл (хөөрөлт/буултын зай);
- (h) агаарын хөлөг нь 2, эсхүл түүнээс олон хөдөлгүүрээр ажилладаг тохиолдолд;
- (i) хөдөлгүүр ажиллагаагүй үеийн журам;
- (j) нэг хөдөлгүүр ажиллаа үеийн гүйцэтгэлийн өгөгдөл;
- (k) хүнд болон тэнцвэр;
- (l) нисэх багийн ажил амралтын цагийн зохицуулалт;
- (m) нислэг дагах хяналтын систем.

115.215 Агаарын хөлгийн удирдлагад оролцох

ЧНГ эзэмшигч нь дүрэмд заагаагүй бол этгээд биш бол ЧНҮА гүйцэтгэж байгаа агаарын хөлгийн удирдлагыг залахгүй байхыг баталгаажуулах ёстой. Дүрмээс дэлгэрэнгүй мэдээллийг лавлах.

Тайлбар: 115.613, 115.667 болон 115.759 нь тодорхой ЧНҮА-нд тодорхой чөлөөлөлт үзүүлдэг, үүнийг уншиж, тусад нь заах хэрэгтэй.

115.217 Усан дээгүүрх нислэг

Бөмбөлөг болон газар усанд явдаг агаарын хөлгийн үйл ажиллагаа эрхлэгч нь нислэгийн төлөвлөлтөндөө сайтар харгалзан үзэж, бодохыг шаарддаг 115.217(b)(2) болон (c)-г мэдэж байх ёстой.

Энэ дүрмээс явуулахыг шаардсан аюулгүйн төхөөрөмжийн ТҮ-г мөн зохих тохиолдолд зөвшөөрсөн ТҮ-ний хөтөлбөрт оруулна.

115.219 Аэродром, буултын талбай болон хөөрөлтийн талбайг ашиглах

Энэ заалт нь ЧНГ эзэмшигчийг ЧНҮА бүрийг энэ дүрэм болон нисдэг тэрэгний 91.127-гийн шаардлага хангасан аэродром, буултын талбай, эсхүл хөөрөлтийн талбайд үйлдэхийг бататгахыг шаарддаг.

Үйл ажиллагаа эрхлэгч нь агаарын хөлгийн гүйцэтгэлийн өгөгдлийг харгалзан үзэж, ойртолтын болон хөөрөлтийн талбайг багтаасан буултын талбай нь ашиглах агаарын хөлгийн маяг, шинж чанарт тохирсныг баталгаажуулж аэродром, буултын талбай болон хөөрөлтийн талбайд үнэлгээ тогтоох журмыг боловсруулах ёстой. Хийсэн аливаа үнэлгээний бүртгэлийг хадгална.

Аэродром, буултын талбай, эсхүл хөөрөлтийн талбайн үнэлгээнээс гарсан мэдээлэл нь 115.219(c)-ээс шаардсан бүртгэлийн хэсэг болно. Аэродром, эсхүл буултын газар нь Монгол Улсын хүчинтэй AIP-д хэвлэгдсэн бол энэ нь үнэлгээнд ашигласан лавлагааны мэдээлэл болно. Гүйцэтгэлийн өгөгдлийн үнэлгээний үр дүнг нислэгийн төлөвлөх үйл явцад багтаана.

Тайлбар: үйл ажиллагаа эрхлэгч нь зарим нөхцөл, ИНД-93 Тусгай Аэродромын Хөдөлгөөний Дүрэм, эсхүл Дуу чимээг багасгах журам, эсхүл бусад орон нутгийн хуулиар, аэродромын хэрэглээнд нөхцөл, хязгаарлалт тавьж болно гэдгийг мэдэж байх ёстой.

“Хөөрч буух зурвас” болон “нислэгийн зурвасны өргөн” гэсэн нэр томъёог ИНД-1-д тодорхойлсон.

115.221 Цаг уурын нөхцөл

ЧНГ дагуу агаарын хөлгийг ажиллуулж байгаа этгээд нь тогтоосон цаг уурын нөхцөл хангагдсан тохиолдолд нислэгийг эхлэхийг баталгаажуулах ёстой.

115.223 Агаарын хөлгийн ачааллын хязгаарлалт

ЧНГ эзэмшигч нь агаарын хөлгийн жин болон төвлөрөлт, зөвшөөрөгдсөн максимум жин болон агаарын хөлгийн хүндийн төвтэй холбоотой тогтоосон хязгаарлалтыг биелүүлж байгааг баталгаажуулах ёстой. О Бүлгийн тусгай ажиллагаатай холбоотой, эзэмшигч нь зорчигч, багийн гишүүдийн бодит жинг тодорхойлох ёстой. (115.223(b)-г харах).

115.223(c) Хөлгийн дарга нь 115.455(b)-д шаардсан өгөгдлийг ашиглан, агаарын хөлгийн хүндийн төв болон жин нь нислэгийн хугацаанд нислэгийн заавар, эсхүл үйл ажиллагааны гарын авлагад заасан хязгаарлалтад байгааг тогтоож, бататгах үүрэгтэй.

115.225 НТЧ-ын үүрэг хариуцлага

ЧНГ эзэмшигч нь дараах хариуцлага хүлээнэ:

(a) бүхэл агаарын хөлгийн НТЧ, үүнд агаарын хөлөгт суурилуулсан, эсхүл бэхэлсэн аливаа төхөөрөмжийг;

(b) агаарын хөлгийг ТҮ-ний хөтөлбөрийн дагуу ТҮ-нд оруулж байгааг бататгах.

Энэ нь ЧНГ эзэмшигч нь ямар ТҮ шаардлагатай, хэзээ хэн, ямар стандартаар гүйцэтгэх ёстойг тогтоож, ажиллуулж байгаа агаарын хөлгийн НТЧ-ын хадгалалтыг бататгана гэсэн үг. Тийм учраас ЧНГ эзэмшигч нь ажиллуулж байгаа агаарын хөлөг бүрд хамаарах дизайны стастус (маягийн гэрчилгээний үндэс, үйлчлүүлэгчийн сонголт, аэродром ADs, өөрчлөлт болон үйл ажиллагааны төхөөрөмж) болон ТҮ-ний шаардлагын талаар хангалттай мэдлэгтэй байх ёстой.

ЧНГ эзэмшигч нь нислэгийн үйл ажиллагаа болон ТҮ үзүүлэгчийн хооронд хангалттай зохицуулалт хийснээр хоёр тал агаарын хөлгийн нөхцөлийн талаар бүх мэдээллийг хүлээн авч, ажил үүргээ гүйцэтгэх боломжоор хангах ёстой.

Энэ нь ЧНГ эзэмшигч нь ТҮ-г гүйцэтгэх ёстой гэсэн үг биш. ЧНГ эзэмшигч нь ажиллуулдаг агаарын хөлгийн НТЧ-ын нөхцөлийг баталгаажуулах үүрэгтэй учраас төлөвлөсөн нислэгийн өмнө бүх шаардлагатай ТҮ-г зөв гүйцэтгэж, бүртгэл хийгдсэн байгаад сэтгэл хангалуун байх ёстой.

ЧНГ эзэмшигч нь ТҮ-г явуулдаггүй бол, гэрээлсэн ТҮ үзүүлэгчид ажлын тодорхой тушаалыг өгөх ёстой. ЧНГ эзэмшигч нь ТҮ-г гэрээлэн хийлгэж байна гэснээр гэрээлсэн ажлын аливаа зүйлийг шалгах журмыг тогтоож болохгүй гэсэн үг биш. Тийм журам нь агаарын хөлгийн НТЧ-ын талаарх ЧНГ эзэмшигчийн үүрэг биелэхийг баталгаажуулна.

115.227 Түлш

Энэ заалт нь ЧНГ эзэмшигчийн Ерөнхий зааварт түлшний бодлого байхыг шаардана. Энэ бодлогод бүх нислэгийн холбогдох үйл ажиллагааны нөхцөлийг авч үзэх хэрэгтэй. ЧНҮА-ны төрөл зүйл болон үндсэн шинж нь түлшийг төлөвлөх, нислэг төлөвлөх үндсэн бөгөөд энгийн хандлагыг шаардана. Хамаарах бол, харгалзан үзэх ёстой зүйлс:

(a) энгийн агаарын хөлгийн түлшний зарцуулалт - агаарын хөлгийн нислэгийн заавар, эсхүл бусад үйлдвэрлэгчийн өгөгдлөөс гарган авч, нислэгийн бодит нөхцөлд тохируулан зассан

(b) хэрэглэх боломжгүй түлш

- (c) тооцоолж байгаа цаг уурын нөхцөл
- (d) тооцоолж байгаа жин
- (e) НХҮ-ний шаардлага болон хязгаарлалт
- (f) аэродром, запас болон бэлтгэл аэродромын газарзүйн байрлал болон бусад чухал өгөгдөл
- (g) урьдчилан хараагүй нөхцөл байдал - төлөвлөх шатанд нислэгийн түлшний зарцуулалтанд нөлөөлөх бүх хүчин зүйлсийг урьдчилан харах боломжгүй. Тийм учраас урьдчилан хараагүй нөхцөл байдлын түлшийг дараах зүйлсэд зориулан тээвэрлэнэ:
 - (i) Тухайн агаарын хөлөг тооцоолсон түлшний зарцуулалтын өгөгдлөөс гажих
 - (ii) Цаг уурын урьдчилсан нөхцөл таарахгүй байх
 - (iii) Төлөвлөсөн нислэг болон/эсхүл чиг шулуун нислэгийн түвшин/далайн түвшнөөс дээших өндрөөс гажих
- (h) тодорхой үйл ажиллагааны түлшний урьдчилан хараагүй нөхцөл байдлыг бүгдийг тооцож үзээд, энэхүү өгөгдлийг 115.213-т шаардсан нислэгийн төлөвлөх үйл явцад оруулна.

Нислэгт төлөвлөх хамгийн бага түлшний шаардлага нь ил харааны нислэгийн үйл ажиллагааны 91.305-д багтсан. Хэрэв нисдэг тэргийг чөлөөт нисэхийн үйл ажиллагаанд явуулж байгаа бол 20 минутаас бага түлшний нөөцийг авч явах сонголтыг зөвшөөрөхгүй гэдгийг анхаарах хэрэгтэй. Энэхүү түлшний бодлого нь ханг-глайдер, параглайдер, глайдер, эсхүл тандем шүхрээр буух үйл ажиллагаанд хамаарахгүй.

115.229 Аюултай бараа тээвэрлэх

Энэ заалт нь аливаа этгээдийг ААО-ын үеэр аюултай бараа тээвэрлэхийг санал болгох, эсхүл хүлээн авахыг хориглоно. ИНД-1 нь “аюултай бараа” гэдгийг тодорхойлохдоо эрүүл мэнд, аюулгүй байдал, эд хөрөнгө, эсхүл байгаль орчинд эрсдэл учруулах чадвартай зүйлс, эсхүл шингэн зүйл бөгөөд -

- (a) Аюултай барааг агаараар аюулгүй тээвэрлэх ИКАО-ын Техникийн зааварчилгааны дагуух жагсаалт, эсхүл ангилалд орсон байна; эсхүл
- (b) Аюултай барааг агаараар аюулгүй тээвэрлэх ИКАО-ын Техникийн зааварчилгааны дагуух аюултай бараа гэж ангилсан зүйлс, эсхүл шингэн болох шинж чанартай байна.

115.231 Нислэгийн аюулгүй байдалд нөлөөлөх этгээд ажлын чадваргүй болох

115.62 нь чадваргүй болж болох хүмүүстэй холбоотой эрсдлийг ажиглах, удирдах хөтөлбөр шаарддаг бол энэ заалт нь ЧНГ эзэмшигчид үйл ажиллагаа эрхлэгч дүрэмд заасан, лавлаж оруулсан аливаа этгээдийг чадваргүй болсон байна гэж үзэх шалтгаан байвал ажиллагааг явуулахаас сэргийлэх үүргийг оноодог. Энэ дүрэмд заасан этгээд нь аливаа багийн гишүүн, тандем шүхрийн мастер, газрын багийн

гишүүн, эсхүл ЧНҮА-ны аюулгүй байдалд шууд нөлөөлөх ажил хийдэг бусад хүмүүс юм.

Е Бүлэг - Сургалт

115.301 Сургалт - Ерөнхий зүйл

115.301(а)(1) Сургалтын хөтөлбөр. ЧНГ эзэмшигч нь багийн гишүүн, эсхүл газрын багийн гишүүд нь оногдсон үүргээ гүйцэтгэхээр сургалтанд хамрагдсан, ур чадвартай болохыг баталгаажуулах сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх ёстой.

Хөтөлбөрт энэ Бүлэгт багтсан бүх элемент багтсан байх ёстой. Энэ нь мөн үйл ажиллагаа эрхлэгч бусад Бүлэгт багтсан байж болох хориглолт болон заавал биелүүлэх шаардлагыг нисэх баг мэдсэн байхыг баталгаажуулах шаардлагатай бусад олон шаардлагыг оруулах боломж юм.

Ажиллагаагаа уулархаг газраар мөн явуулдаг ЧНГ эзэмшигч нь Ерөнхий заавартаа тийм бүсэд ажиллахын өмнө урьдчилан шаардлага болгон багийн гишүүдээ сургалтанд хамруулан, ур чадвартай болгохыг баталгаажуулах ИНЕГ-аас хүлээн зөвшөөрсөн уулын сургалтын хөтөлбөрийг боловсруулж оруулах ёстой.

Өөрсдийн сургалтын курс болон үнэлгээг тогтоох нэмэлт заавар материал АС141-1-д байгаа.

115.301(а)(2) Багийн гишүүн болон газрын багийн гишүүний сургалт. ЧНГ эзэмшигч нь нисэх багийн гишүүн, эсхүл газрын гишүүнийг Ерөнхий зааварт орсон хөтөлбөрийн дагуу сургалтанд хамрагдсан болохыг бататгах үүрэгтэй. Хөтөлбөрийн дагуу нисэх багийг хөтөлбөржүүлэх, хуваарилах зарим арга зам хэрэгтэй болно.

Уулархаг орчинд ажиллаж байгаа тохиолдолд газардах курсын хөтөлбөрийн зүйлсийг үзүүлэхэд шаардлагатай хамгийн бага нислэгийн бага нь:

Анхан шатны сургалт, хамгийн багадаа 10 цагийн нислэг; эсхүл үйл ажиллагаа эрхлэгчээс нисгэх зохих уулархаг орчинд бүрэн таньж мэдсэн байхад шаардлагатай хангалттай нэмэлт цаг. Эдгээр 10 цагт олон төрлийн цаг уурын нөхцөлд ниснэ, ингэснээр нисгэгч нь зугтах болон нөөц маршрутыг оруулаад бүс дэх энгийн үйл ажиллагааны маршрут дээр цэлмэг тэнгэр, хэцүү цаг уурын нөхцөлийн хоорондын ялгааг үзэж, туршлагатай болно. Шаардсан олон төрлийн нөхцөлийг үзэхийн тулд дараах цагийг тодорхой хугацаанд хийж дуусгавал зохино. Үйл ажиллагаа эрхлэгч нь цаг уурын ердийн нөхцөлийг оруулах бүх боломжтой оролдлогыг хийх ёстой бөгөөд нисгэгч нь үйл ажиллагаа эрхлэгчид ажиллах маршрут дээр хангалттай стандарт, мэдлэгийг үзүүлж байж, нисгэгч шугаманд нисэх зөвшөөрөлтэй болно. Энэ зөвшөөрлийг нисгэгчийн сургалтын файлд багш гарын үсэг зурж өгнө.

115.301(а)(3) Сургалтын хөтөлбөрийн хяналт. Энэ заалтаар 115.301(а)(1)-ээс шаардсан сургалтын хөтөлбөрийн үүргийг ЧНГ эзэмшигчид өгнө. Энэ нь ЧНГ эзэмшигчийг ЧНГ эзэмшигчийн шаардлагын дагуу сургалтыг тодорхойлж, явуулахыг

хариуцуулна. Сургалт үзүүлэгч нь ЧНГ эзэмшигчээс санал оруулахгүй хэзээ юу шаардлагатайг шийдэхээр болгож болохгүй.

115.301(b) Байгууллага дээрээ хийх, эсхүл гэрээлэх. Энэ заалт нь ЧНГ эзэмшигчийг дараахийг зөвшөөрнө:

ИНД-115-ын байгууллагын хамрах хүрээнд сургалт явуулах. Явуулах (анхан шат, шилжих, давтан, маягийн зэрэглэлийн) сургалтыг заасан сургалтын журам мөн сургалтыг бүртгэх зарим арга зам шаардлагатай болно.

(b) ИНД-141, эсхүл ИНД-149 гэрчилгээ нь тухайн сургалтыг явуулах эрхийг олгодог бол ИНД-141-ийн дагуу гэрчилгээжсэн байгууллага, эсхүл ИНД-149-ийн гэрчилгээ эзэмшигчтэй сургалтыг гэрээлэх. Дээр дурдсанаар, сургалтын байгууллага нь явуулахаар гэрээлсэн сургалтыг явуулах журамтай байх ёстой.

Өөрсдийн сургалтаа явуулах СНОГ эзэмшигч нь 115.311-д заасан зохих мэргэшсэн багш нарыг ажилд авах, гэрээлэх, эсхүл бусад байдлаар ажиллуулах ёстой.

115.303 Нисэх багийн болон газрын багийн гишүүдийн сургалтын хөтөлбөр

Энэ заалт нь тусгай үйл ажиллагаанд хамааралтай, энэ бүлгийн бүх элементийг нисэх багийн болон газрын багийн сургалтын хөтөлбөрт нийлүүлдэг. Ямар ч үйл ажиллагааны төрөл байсан хөтөлбөр нь дараах элементийг багтаах ёстой:

- Анхан шатны сургалт
- Шилжилтийн сургалт
- Давтан сургалт

Энэ нь ЧНГ эзэмшигчийн заавал биелүүлэх шаардлага бөгөөд аль болох дүрмийн шаардлагыг нийлүүлэхэд ашиглах ёстой.

Хөтөлбөрийн нисэх багийг сургах хэсгийг 115.311-ийн шаардлагыг хангасан нисэх багийн гишүүн гүйцэтгэх ёстой гэдгийг анхаарах нь зүйтэй.

115.305 Багийн гишүүд болон газрын багийн гишүүдийн анхан шатны сургалт

ЧНГ эзэмшигч нь ЧНГ-ний хүрээнд ашиглах агаарын хөлөгт багийн гишүүн, эсхүл газрын багийн гишүүнээр ажиллахын өмнө багийн гишүүн болон газрын багийн гишүүн бүр нь дүрэмд заасан анхан шатны сургалтыг дүүргэсэн байх ёстой. Энэ нь багийн гишүүнийг ЧНГ эзэмшигчтэй ажиллагаа эхлэхийн өмнө ур чадварын шалгалтыг амжилттай өгөхөд бэлтгэх үр дүнтэй байна.

115.305(1), (2) Бүтэц болон сургалтын хөтөлбөр. Энэ дүрэм нь анхан шатын сургалтыг багийн гишүүн, эсхүл газрын багийн гишүүнийг хөтөлбөрөөр хөгжих логик дараалал бүхий бүтэцтэй байхыг шаардана. Дүрэм нь анхан шатны сургалтын хөтөлбөрт оруулах ёстой элементийг тодорхой заана.

ЧНГ эзэмшигч нь төлөвлөсөн чөлөөт нисэхийн үйл ажиллагаанд хамааралтай, 115.305(2)-т жагсаасан бүх элементийг оруулсан сургалтын хөтөлбөр хийх үүрэгтэй. Энэ нь зөвхөн агаарын хөлгийн маяг, загвар болон онцлог, маршрут болон аэродром

зэрэгт таарсан тусгай төхөөрөмжийн талаар сургалт биш мөн ЧНГ эзэмшигчийн бодлого, журам, стандартын талаар байна.

115.307 Багийн гишүүн болон газрын багийн гишүүдийн шилжих сургалт

Энэ заалт нь ЧНГ эзэмшигчийг багийн гишүүн нэг агаарын хөлгийн маягаас өөр маягт шилжих, эсхүл шинэ журам, эсхүл шинэ төхөөрөмжийг танилцуулах үед нисэх багийн болон газрын багийг шилжих сургалтанд сургах шаардлагыг үнэлж, сургалтаар хангахыг шаарддаг. Үүнд: шаардлагатай журам нь орж байгаа өөрчлөлтөөс шалтгаалан шаардлагатай сургалтын хэмжээг үнэлж, сургалтаар хангах ёстой.

Энэ дүрмийг шаардлагыг харгалзан үзэхдээ ИНД-1-д заасан төрлийн тодорхойлолтыг ашиглах хэрэгтэй бөгөөд энэ нь ИНЕГ-тай зөвлөлдөхийг шаардаж болно. Өөрөөр бол шинэ агаарын хөлөг, тоног төхөөрөмж, эсхүл журмыг танилцуулж, ашиглахад шаардлагатай сургалтын хэр хэмжээг өөрчлөлтийн хэмжээнээс шалтгаалан, аюулгүй байдал, ослын төхөөрөмж болон журамд тодорхой ач холбогдол өгч тогтооно.

Нислэгийн үйл ажиллагааг илүү хэцүү газар нутаг руу өргөжүүлвэл сургалтын хөтөлбөр нь үүнийг оруулах ёстой.

115.309 Багийн гишүүд болон газрын багийн гишүүдийн давтан сургалт

ЧНГ эзэмшигч нь бүх багийн гишүүн болон газрын багийн гишүүн агаарын хөлөг бүрд болон гүйцэтгэж байгаа үйл ажиллагааны төрөлд үргэлж шинэлэг, чадвартай байхыг баталгаажуулах ёстой.

Зорилго нь засах сургалт биш юм. Засах сургалтыг ихэвчлэн ур чадварын шалгалтын үеэр дутагдал илэрсэн үед хийдэг.

Давтан сургалтаар ихэвчлэн үйл ажиллагааны журмыг эргэн харж, байнгын ур чадварын шалгалт, санаандгүй үеийн чанарын шалгалтаас гарсан осол, зөрчил, сул талаас гарсан мэдээлэл болон сургалт хэрэгтэйг харуулсан аливаа бусад заалтаас гарсан мэдээллээр баяжна.

Нисгэгч нь чөлөөт нисэхийн үйл ажиллагаанд нэгээс олон төрлийн агаарын хөлгийг нисгэх шаардлагатай үед ЧНГ эзэмшигч нь нисэх багийн ур чадварыг шалгаагүй төрөл дээр давтан (энгийн болон онцгой нөхцөлийн журмаар) сургалтын хуваарь гаргах ёстой. Ингэснээр үйл ажиллагаа эрхлэгч багийн гишүүдийг агаарын хөлөг бүрд чадвартай байхыг баталгаажуулах шаардлагыг хангахад тусална.

105.311 Нисэх багийн гишүүнд багшлах эрх бүхий этгээдийн мэргэшил

ЧНГ эзэмшигч, нисэх багийн сургалтын хөтөлбөрт багш нисгэгчээр ажиллаж байгаа аливаа этгээд нь дараах шаардлага хангасныг бататгах үүрэгтэй:

- (a) Үйл ажиллагаанд хөлгийн даргаар ажиллах боломжтой байхын тулд ЧНГ эзэмшигчээс шаардсан сургалтыг хангалттай дүүргэсэн
- (b) 115.311(2)-ын шаардлагын нэгийг биелүүлж, багшаар ажиллах зохих мэргэшилтэй байна

(с) явуулах заавартай холбоотой анхан шатны болон давтан сургалтанд сурсан.

105.313 Сургалтын бүртгэл

ЧНГ эзэмшигч нь багийн гишүүн болон газрын багийн гишүүн бүрийн үнэн зөв бүртгэлийг хадгалахыг баталгаажуулах ёстой. Ерөнхийдөө, эсхүл тусгайлан энэ Дүрмийн хувьд чөлөөт нисэхийн үйл ажиллагаа эрхлэгчээс шаардсан бүртгэл хөтлөх, хадгалахыг багтаасан журмын иж бүрдлээр хийж болно. 115.65-аас лавлах.

F Бүлэг - Багийн гишүүн болон газрын багийн гишүүний ур чадварын шаардлага

115.351 Үйл ажиллагааны ур чадварын үнэлгээний хөтөлбөр

ЧНГ эзэмшигч нь дүрэмд заасан зорилгоор үйл ажиллагааны ур чадварын үнэлгээний хөтөлбөрийг гаргаж, хэрэгжүүлэх ёстой. Ур чадварын үнэлгээ нь сургалт биш боловч ур чадварын үнэлгээ нь E Бүлэг (115.301) шаардсан сургалтын хөтөлбөртэй холбогдсон байх нь ойлгомжтой.

115.353 Нисэх багийн гишүүний ур чадварын шалгалт

ЧНГ эзэмшигч нь дүрэмд заасан нисэх багийн гишүүн ур чадварын шалгалтыг заасан ёсоор өгсөн байхыг бататгах үүрэгтэй. Дүрмээс дэлгэрэнгүйг лавлах.

115.355 Багийн гишүүн болон газрын багийн гишүүний ур чадварын шалгалт

ЧНГ эзэмшигч нь өмнөх 12 сарын дотор тухайн этгээдийг заасан асуудлаар хангалттай мэдлэгтэй, ур чадвартай гэдгийг заасан ёсоор тогтоосноос бусад тохиолдолд багийн гишүүн, эсхүл газрын багийн гишүүнээр ашиглаж болохгүй. Жишээ нь, зорчигчийн менежмент, багийн гишүүн болон газрын багийн гишүүний ажил үүрэгт. Дүрмээс дэлгэрэнгүйг лавлах. Дүрэм нь мөн урдчилан заасан шаардлагыг биелүүлэхээс нааш аливаа этгээд багийн гишүүн, эсхүл газрын багийн гишүүнээр ажиллахыг хориглоно.

115.355(1) - (8) ур чадварын шалгалтанд орох ёстой зүйлсийг заасан байна.

АМС 115.355(8) Анхны тусламжийн ур чадвар. Энэ дүрэм нь NZQA Стандарт 424, эсхүл ИНЕГ-ын Дарга хүлээн зөвшөөрөх, түүнтэй дүйцэх анхан шатны ур чадварыг шаардана. ИНД-115-ын үйл ажиллагаанд I, J, K, L, O, P Бүлэг болон Сэнт Жоны анхан шатны тусламжийн түвшин 2-ын чадварыг ИНЕГ-ын Дарга хүлээн зөвшөөрөхөөр байна гэж үзнэ.

115.357 Шалгагч-нисгэгчийн мэргэшил

ЧНГ эзэмшигч үйл ажиллагааны ур чадварын үнэлгээний хөтөлбөрт шалгагч-нисгэгч үүргийг гүйцэтгэж байгаа этгээд дүрэмд заасан шаардлагыг биелүүлж байхыг бататгах ёстой.

Энэ заалт нь үйл ажиллагааны ур чадварын үнэлгээг зохих шалгагч-нисгэгчээр хийлгэхийг шаардана. Зохих шалгагч-нисгэгч нь:

(a) Шүхрийн буултын үйл ажиллагааны хувьд:

Шүхрийн буултын үйл ажиллагааг хязгаарласан, эсхүл оруулсан, ИНД-115-ын шалгагч-нисгэгчийн зэрэглэлтэй, ИНД-61-ийн ерөнхий зориулалтын нисэхийн, эсхүл агаарын тээвэрлэгчийн шалгагч-нисгэгч байна. Үндсэн, эсхүл гэрээгээр ажиллаж байгаа ИНД-141 байгууллагын шалгагч-нисгэгчийн гэрчилгээний үйл ажиллагааны тодорхойлолтд ИНД-115-ын үнэлгээ байх ёстой.

(b) Шүхрийн буултын үйл ажиллагааны хувьд:

ИНД-149 Шүхрийн буултын шалгагчийн зэрэглэл эзэмшигч.

(c) Хэт хөнгөн, эсхүл спортын хөнгөн агаарын хөлгийн ажиллагааны хувьд:

Хэт хөнгөн, эсхүл спортын хөнгөн агаарын хөлгийн үйл ажиллагааг хязгаарласан, эсхүл оруулсан, ИНД-115-ын ажиллагааг зөвшөөрсөн ИНД-61-ийн ерөнхий зориулалтын нисэхийн, эсхүл агаарын тээвэрлэгчийн шалгагч-нисгэгч. Үндсэн, эсхүл гэрээгээр ажиллаж байгаа ИНД-141-ийн байгууллагын шалгагч-нисгэгчийн гэрчилгээний үйл ажиллагааны тодорхойлолтод ИНД-115-ын үнэлгээ байх ёстой.

(d) Бөмбөлгийн үйл ажиллагааны хувьд

ИНД-61 Бөмбөлгийн шалгагчийн зэрэглэлийг ашигладаг болох хүртэл заалтыг чөлөөлсний дагуу үнэлгээг явуулах зөвшөөрөлтэй, ажиллаж байгаа агаарын тээврийн шалгагч-нисгэгч.

(e) Ханг-глайдер, параглайдерын үйл ажиллагааны хувьд:

Гэрчилгээн дээрээ ханг-глайдер болон параглайдерын хамрах хүрээтэй. ИНД-149-ийн байгууллагаас олгосон шалгагчийн зэрэглэл эзэмшигч.

(f) Глайдерын үйл ажиллагааны хувьд:

(4)-т байгаа шиг Авиэйшн Сервисэс Лимитэд компанийн шалгагч-нисгэгч, гэхдээ шалгагчийн зэрэглэлийг ИНД-115-ын глайдерын нисгэгчийн үргэлжилсэн ур чадварын үнэлгээний хүрээнд олгосон байна.

(g) Шалгагч-нисгэгчийн зэрэглэлийг ИНД-115-ын үйл ажиллагаанд олгосон бөгөөд ИНД-115-ын үргэлжилсэн ур чадварын үнэлгээний хамрах хүрээнд ИНД-141-ийн байгууллагын эрхийн хүрээнд ажиллаж байгаа, ИНД-61 ерөнхий зориулалтын нисэхийн, эсхүл агаарын тээвэрлэгчийн шалгагч-нисгэгч, эсхүл гэрчилгээ нь нисэх спортын арга хэмжээний эрхтэй, ажилтны эрхийг олгосон ИНД-149-ийн гэрчилгээний хүрээнд зөвшөөрөлтэй этгээд.

115.359 Багийн гишүүний тест, эсхүл нислэгийн шалгалтыг шаардсан хугацаанаас өмнө гүйцэтгэх

Хэрэв багийн гишүүн нь тест, эсхүл шалгалтаа дуусах хугацаанаас өмнө 60 хоногийн дотор өгсөн бол анхны тогтоосон он сар өдөрт өгсөн гэж тооцно. Өгөх ёстой өдрөөс хойш тестийг бөглөх эрх чөлөөг өгөхгүй.

Хэрэв багийн ур чадварын шалгалтыг өгөх ёстой өдөр гэхэд өгөөгүй бол, бүгдийг өгч дуусах хүртэл бүх ЧНҮА-г цуцална. Сүүлд өгсөн шинэ өдөр дараагийн шалгалтын хуваарийг тогтооно.

115.361 Ур чадварын болон шалгалтын бүртгэл

ЧНГ эзэмшигч нь багийн гишүүд болон газрын багийн гишүүдийн бүх ур чадварын үнэлгээ болон шалгалтын үнэн зөв бүртгэлийг хадгалах ёстой.

G Бүлэг - Нисэх багийн ажил, амралтын цагийн зохицуулалт

115.401 Үйл ажиллагаа эрхлэгчийн үүрэг хариуцлага - Нислэгийн болон үүрэг гүйцэтгэх цагийн хуваарь

ЧНГ эзэмшигч нь нисэх багийн ажил, амралтын зохицуулалтад шаардлагатай нислэгийн болон үүрэг гүйцэтгэх цагийн хуваарийг тогтоосноос бусад тохиолдолд ЧНҮА гүйцэтгэхгүй байхыг бататгах үүрэгтэй. Нислэг болон үүрэг гүйцэтгэх цагийн хуваарь нь ИНЕГ-ын Дарга хүлээн зөвшөөрөхүйц байх ёстой бөгөөд дүрэмд заасан хүчин зүйлсийг тооцсон байх ёстой. Дүрэм нь тухайн нөхцөлд уг этгээдийг нисэх багийн гишүүнээр ашиглахтай холбоотой хязгаарлалтыг заасан байдаг бөгөөд нислэгийн болон үүрэг гүйцэтгэх цагийн үнэн зөв бүртгэл хөтлөлтийг шаарддаг. Дүрмээс илүү дэлгэрэнгүй мэдээллийг лавлах.

Ерөнхий суурь зааварчилгаа

Ядаргаа гэдгийг хүчин чармайлт гаргаснаас ядарсан байдал гэж тодорхойлдог. Энэ нь тухайн этгээдийн гүйцэтгэлийн чадвар, анхааралтай байдал, сэтгэл санааны байдлыг бууруулах үр дүн гарч болно.

Судалгаанаас харахад 16 цагаас илүү байнгын сэрүүн байдал нь анхааралтай байдал, сонор сэрэмж, ажил үүрэгт тавих анхаарлыг багасган, хариу үйлдэл үзүүлэх хугацааг 12-15 хувиар бууруулсан үр дүн гарсан.

Ядаргаа нь нисэх багийн гүйцэтгэлийг багасгаж болох үйл ажиллагааны санаа зовоох асуудлын нэг болно.

Гүйцэтгэл буурах нь аажмаар, нуугдмал байж болох бөгөөд тухайн этгээдийн ажил үүргийн шаардлагаа биелүүлэх биеийн болон оюуны эх сурвалжийг ихээхэн багасгана.

Ядаргаа эхлэх үед энэхүү нөхцөлд байгаа этгээд нь гүйцэтгэлдээ үнэлгээ хийх чадваргүй байна.

Ядаргаа нь тухайн этгээд өвөрмөц, эсхүл илүү их ажлын ачааллын нөхцөлд, эсхүл хувь хүн цагийн дарамтанд ажиллах ёстой үед илүү ихсэх ханадлагатай бөгөөд энэ нь алдаа гаргахад нөлөөлнө. Ядаргаатай холбоотой гүйцэтгэл муудахад хүргэх олон мэдэгдсэн дараах хүчин зүйлс байдаг:

- Үүрэгт хугацааны үргэлжлэх хугацаа болон ажлын ачааллын хэлбэр.
- Хангалттай унталгүй ажиллахыг оролдох. Өмнөх унтлагын хугацаа болон чанар чухал.
- Хүмүүсийг шөнө унтуулж, өдөр нь сэрүүн байлгахаар програмчилсан биологийн цагийн эсрэг ажиллахыг оролдох.

Уртасгасан үүрэгт хугацаанд хуримтлагдсан үр нөлөө

Зорилго

Энэ мэдээллийн зорилго бол ЧНГ эзэмшигчийг өөрсдийн ажил, амралтын цагийн зохицуулалтын хуваарьтай болгох явдал юм. ЧНГ эзэмшигчийн нислэг, ажил, эсхүл амралтын хугацаанд аливаа хязгаарлалт тогтоохыг оролдох нь энэ мэдээллийн зорилго биш.

ЧНГ эзэмшигч нар нь өөрсдийн тусдаа үйл ажиллагааны шаардлагад нийцсэн өвөрмөц хуваарьтай болохыг дэмжиж байна. Хамаарах тохиолдолд харгалзан үзэх ёстой хүчин зүйлс нь 115.401(b)-д байна. Харгалзан үзэх ёстой хүчин зүйлс нь дүрмэнд зааснаар хязгаарлагдахгүй.

ЧНГ эзэмшигч нь нислэгийн болон үүрэг гүйцэтгэх цагийн хуваариа үзүүлэхээр өгөхдөө 115.401(b)-д байгаа хүчин зүйлсийг үйл ажиллагаатай холбон хэрхэн авч үзсэнээ баримтжуулах ёстой.

Дараах мэдээллийг хуваарийг үнэлэх, тогтооход туслах зорилгоор гаргасан.

Тодорхойлолт

Нислэгийн болон үүрэг гүйцэтгэх цагийн хуваарийг гаргахдаа ИНД-1-д орсон тодорхойлолтыг ашиглах ёстой. Гэхдээ ИНД-1-д тодорхойлоогүй байвал тухайн нэр томъёоны энгийн утгыг ашиглана. Энэхүү АС-д дараах нэр томъёог тодорхойлно:

Хангалттай амралтын байр гэдэг нь дуу чимээний хамгийн бага түвшинтэй, сайн агааржуулалттай бөгөөд температур болон гэрлийн түвшинг удирдах төхөөрөмж бүхий нэг хүний амьдрах унтлагын өрөөг хэлнэ, тийм унтлагын өрөө байхгүй бол тухайн байрлал болон улиралд тохиромжтой, дуу чимээний хамгийн бага түвшинтэй бөгөөд элементээс хангалттай хамгаалах байр байж болно.

Тасалдсан хуваарь гэдэг нь ЧНГ эзэмшигчийн хяналтаас гадуур нөхцөлийн шалтгаанаас хуваарьтай хугацааны дотор тэр дагуу явагдаагүй хуваарийг хэлнэ:

Үүрэг болон үүрэгт хугацаа

Ажил гэдэг нь ЧНГ эзэмшигчийн бизнестэй холбоотой багийн гишүүний гүйцэтгэх шаардлагатай аливаа ажлыг (байрлалаа сонгох багтана) хэлнэ.

Үүрэгт хугацаа гэдэг нь нисэх багийн гишүүн үйл ажиллагаа эрхлэгчийн бизнестэй холбоотой үүргийг гүйцэтгэхэд шаардлагатай үргэлжилсэн хугацааг хэлнэ. Үүнд нислэгийн үүрэгт хугацаа, байрлал сонгох, газрын сургалт, газрын үүрэг болон хүлээлгэд байх горим багтана.

Нисэх багийн гишүүнийг ЧНГ эзэмшигч 10-аас бага цагийн зайтай 2, эсхүл түүнээс олон хугацаанд ажилд гаргах, эсхүл ажилд бэлэн байлгахыг шаардвал хугацааг эхэлсэн анхны хугацаанаас хамгийн сүүлийн хугацаа дуусах хүртэл үргэлжилсэн гэж үзнэ.

Гадаад ажиллагаа гэж Монгол улсын нутаг дэвсгэрийн хилийн гадна явагдаж байгаа ажиллагааг хэлнэ.

Нислэгийн үүрэг гүйцэтгэх хугацаа гэдэг нь нисэх баг нислэгт илтгэх, эсхүл нисэх багийн гишүүн түр зогсолтын горимыг мэдээлэхэд эхлэн, агаарын тээвэрлэгчээс өгсөн үүргийг гүйцэтгэх шаардах хугацааг багтаасан хугацааг хэлнэ.

Нислэгийн инженерийн хувьд энэ нь нислэгийн өмнө, эсхүл нислэгийн дараа агаарын хөлгийн ТҮ-г хийж дуусгах ажлыг хэлнэ.

Байрлал олох гэдэг нь агаарын үйл ажиллагаа эрхлэгчийн хүсэлтээр зорчигчид гадна байхад, эсхүл агаарын тээвэрлэгчийн хүсэлтээр нисэх багийг нэг газраас нөгөө рүү шилжүүлэхийг хэлнэ.

Эдгэрэх хугацаа гэдэг нь нисэх багийн гишүүнийг хуримтлагдсан ядаргааны нөлөөнөөс гарах, урт ажлын циклийн дараа ажлаас чөлөөтэй амрах 48 цагаас илүү хугацаа.

Амрах хугацаа гэдэг нь нисэх багийн гишүүнийг үйл ажиллагаа эрхлэгч бүх ажлаас чөлөөлсөн, амралтыг үйл ажиллагаа эрхлэгч тасалдуулахгүй байх, газар дах цагийн хугацааг хэлнэ. Үүнд амрах газар руу, эсхүл газраас явах, хоол идэх, хувийн ариун цэвэрт зориулсан цагийг оруулахгүй.

Хүлээлгэд байх хугацаа гэдэг нь нисэх багийн гишүүн нь идэвхтэй үүрэг гүйцэтгэхэд бэлэн байлгах шаардлагатай хугацааг хэлнэ.

Хуваасан үүрэг гэдэг нь газарт тусгаарласан 2 үүргээс бүрдэх бөгөөд газарт нисэх багийн гишүүн нь бүх үүргээс чөлөөлөгдсөн байх нислэгийн үүрэгт хугацаа.

Хуваасан үүргийн хугацаа гэдэг нь өдрийн хугацаанд нисэх багийн гишүүн дараах -тай байхыг хэлнэ:

- (a) хуваасан үүргийн хугацааны урьдчилсан мэдэгдэл авсан байх.
- (b) багийн гишүүн нь тохиромжтой байранд хангалттай амрах.

Үүрэгт аялал гэдэг нь нислэгийн өмнө суурь баазаас ажлаа эхлэхэд эхэлсэн, үүргээ гүйцэтгээд суурь баазанд ирснээр дуусах хугацааг хэлнэ.

Хэрэв багийн гишүүн нь суурь бааздаа түр байгаа бол тухайн газрыг тэр хугацаанд түүний суурь бааз гэж тооцно.

Нийт үүрэг гүйцэтгэх хугацаа нь нисэх багийн гишүүн нь үйл ажиллагаа эрхлэгчийн мэдэлд байгаа аливаа тодорхой хугацааны дотор ажлын цагийн нийлбэрийг хэлнэ.

Урьдчилан хараагүй үйл ажиллагааны нөхцөл гэдэг нь урьдчилан мэдээлээгүй цаг агаарын байдал, тоног төхөөрөмжийн эвдрэл болон нислэгийн хөдөлгөөний удирдлагын саатал зэрэг үйл ажиллагаа эрхлэгчийн хяналтаас гадуурх үйл явдлыг хэлнэ.

Ажил, амралтын цагийн зохицуулалтын систем

Ажил, амралтын цагийн зохицуулалтын хуваарь нь ядаргаа үүсгэж болох бүх шалтгааныг тооцон, ядаргааг үйл ажиллагааны хүчин зүйл гэж үзэх өргөн хандлагыг барих ёстой. Энэ хандлагад ажлын газраас гадуурх хүчин зүйлс нь ядаргаанд их хувь нэмэр оруулдаг болохыг тооцох нь бага бөгөөд ажил, амралтын цагийн зорицуулалт нь агаарын тээвэрлэгч болон хувийн нисэх багийн хамтарсан үүрэг хариуцлага юм.

Ажил, амралтын цагийн зохицуулалтын хуваарь нь бодлого болон системд үндэслэх ёстой. Үүнд дараах асуудал орох бөгөөд үүгээр хязгаарлахгүй:

- (a) үүрэг хариуцлагыг таниулах болон оноох
- (b) менежмент болон ажилтны боловсролыг үргэлжүүлэн сайжруулах
- (c) ядаргаа болон зөрчил/ослыг мэдээлэх болон шалгах систем
- (d) ажлын ачааллыг хянах
- (e) ядарсан хүмүүсийг таних, зохицуулах
- (f) системийн үнэлгээ.

Ажил, амралтын цагийн зохицуулалтын хуваарийг гаргахад тооцох зүйлс

Нислэгийн болон үүрэг гүйцэтгэх цагийн хуваариа хүлээн зөвшөөрүүлэхээр танилцуулж байгаа ЧНГ эзэмшигч нь 115.401(b)-д тусгасан мэдээллийг оруулсан байх ёстой. Дүрмийг үзэж, ажил, амралтын цагийн зохицуулалтын хуваарийг гаргахдаа үйл ажиллагаа эрхлэгч нь хамгийн наад зах нь дараах хүчин зүйлсийг тооцсон болохыг бататгах үүрэгтэй:

- (a) тухайн хуваарь нь ядаргаанд нөлөөлөх бүх хүчин зүйлсийг таньж, эдгээрт зохих ач холбогдлыг өгөх ёстой.
- (b) байгууллагын удирдлага нь нисэх багтай хамтран тухайн хуваарийг гаргасан байна

(с) нисэх баг, эсхүл нисэх багийн төлөөлөгч нь хуваарийн бүх асуудлыг ярилцаж тохирсон бөгөөд хуваарь нь нисэх багийн саналыг албан ёсоор авах арга замыг оруулсан байна.

Үйл ажиллагааны зохицуулалтын системийн хэсэг болох хуваарь нь удирдлага болон нисэх багаас хуваарийг байнга шалгах нөхцөлтэй ажиглах системийг багтаасан байна. Энэ шалгалт нь хуваарийг үр дүнтэй бөгөөд хүссэн үр дүнд хүрч байна гэсэн баталгааг өгнө.

Үүрэг гүйцэтгэж байгаа нисэх багийн ажлын ачааллыг хянах

ЧНГ эзэмшигчийн нисэх багийн ажлын ачааллыг хянахаар сонгосон аргыг бодлогод тодорхойлно. Бодлого нь одоогийн нөхцөлийг дахин үнэлж, аливаа шаардлагатай өөрчлөлтийг хийх хэрэгцээг харуулах сэдэрэх түвшинг тогтоох ёстой. Удирдлага болон ажилтан нь тэдгээрийг тогтмол шалгах уулзалт дээр харгалзан үзэх ёстой. Дараах үзүүлэлтийг харгалзан үзнэ:

- (a) газарзүй - нутаг дэвсгэр
- (b) үйл ажиллагааны төрөл
- (c) цаг уурын нөхцөл - салхи, харагдах байдал, доогуур үүл, чухал аюултай үзэгдэл, тусгай үзэгдэл
- (d) хөдөлгөөний төрөл болон нягтрал - нислэгийн хөдөлгөөний төрөл, нягтрал, агаарын хөлгийн үйл ажиллагааны урьдчилсан төлөв байдал, хэрэглэлийн нислэгийн хамгийн их хөдөлгөөнтэй үе
- (e) нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ - нислэгийн хөдөлгөөний удирдлага үзүүлэх, нислэгийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх, түгшүүрийн дохионы үйлчилгээ үзүүлэх, хяналттай агаарын зайн ойр байдал
- (f) тойргийн хэлбэр - аэродромын тойрог сонголт, стандарт бус тойргийн хэлбэр, дуу чимээ багасгах журам
- (g) бусад аэродром - аэродромын ойролцоох аэродром
- (h) тусгай категорийн агаарын хөлгийн үйл ажиллагаа - хуваарьт бус томхон агаарын хөлөг, тусгай үйл явдал, радиогоор биш тоногдсон агаарын хөлөг, спорт/зугаалгын агаар хөлөг, цэргийн агаарын хөлөг.

ЧНУА-ны нислэгийн болон үүрэг гүйцэтгэх цагийн хуваарийн шаардлагыг биелүүлэхийн тулд ЧНГ эзэмшигч нь 2 сонголттой байна:

- (a) 115.401(b)-ын дагуу нислэгийн болон үүрэг гүйцэтгэх цагийн хуваарийг боловсруулах: эсхүл
- (b) Энэ дүрмийн зорилгоор ИНЕГ-ын Дарга хүлээн зөвшөөрөхүйц, АС119-2-т орсон нислэгийн болон үүрэг гүйцэтгэх цагийн хуваарийг ашиглах.

АС119-2 бол хуучин CASO 3-т үндэслэсэн хуваарь бөгөөд сайн гэдэг нь тогтоогдсон. Үүнийг авч ашиглавал ИНД-115-ын дагуу явуулах бүх ЧНҮА-нд ашиглах ёстой.

Зөвшөөрөл авах гэж байгаа хуваарь бүрд нислэг, ажил, амралтын хугацаатай холбоотой тогтоосон хязгаарлалт байх ёстой. Эдгээр хязгаарлалтыг ЧНГ эзэмшигч тогтоож, баримтлах ёстой. Эдгээр хязгаарлалтыг тогтоохдоо ЧНГ эзэмшигч нь дараах зүйлсийг харгалзан үзсэнээ харуулах үүрэгтэй:

- (a) чөлөөт нисэхийн үйл ажиллагаа
- (b) энгийн, эсхүл чөлөөт нисэх баг
- (c) ганц нисгэгчтэй баг
- (d) 2 нисгэгчтэй баг
- (e) нислэгийн үүрэг гүйцэтгэх нийт цаг
- (f) хүлээлгэд байх хугацаа
- (g) амрах цаг
- (h) амрах газар
- (i) урьдчилан хараагүй нөхцөл байдлаас болж тасалдсан хуваарь
- (j) нисэх багт байж болох бусад ажил.

Хуваарийг боловсруулахад ашиглах ажлын баримт бичгийг авч үзсэн элемент, элемент бүрд хамаарах жинг харуулсан матриц хэлбэрээр үзүүлж болно. Төлөвлөсөн үйл ажиллагааны хамрах хүрээтэй холбоотой ядаргаанд нөлөөлж болох бүх элементийг авч үзэх ёстой.

115.401(b)(1) Нислэгийн өмнөх амралтын хугацаа. Ажил эхлэхийн өмнөх амралтын хугацаа нь хамгийн багадаа 12 цаг байхыг зөвлөдөг. Энэ завсарлага нь ажлын мөчлөг эхлэхийн өмнө ядаргааны үр нөлөөг багасгах хангалттай унтах боломжийг олгох ёстой.

Хэвэндээ орох амралтын хугацааны үр дүн нь тухайн этгээд хэр их унтах боломжтой байгаагаас шалгаална. Энэ нь цаашлаад амралтын хугацааны хичнээн цаг нь хүний тархи болон бие, хоногийн биологийн цагт унтахад тохирсон үе таарахаас шалтгаална.

115.401(b)(2) Хамтатгасан ажил үүрэг. Энэ заалтын зорилго бол үүрэгт ажлын хугацаанд хийх ёстой ажлыг хамтатгахыг харгалзан үзэж, стрессийн түвшинд өгөх жинг тооцож үзэх юм. Жишээлбэл өндөр анхаарал шаардсан аэробатик ажиллагаа болон хамаагүй бага төвшний газар үзэх ажиллагааг нэг үүрэгт ажлын хугацаанд цуг хийвэл ажлын хугацааг багасгах, эсхүл ажлын хугацаан дахь сонор сэрэмжийн түвшинг хангалттай хадгалахын тулд амралтыг ихэсгэх шаардлага гарч болно.

115.401(b)(3) Хүлээлгэд байх хугацаа. Энэ заалт нь ажлын газар, ажлаас хол нөөц, эсхүл хүлээлгэд байх хугацааг ажлын нэг хэлбэр гэж үзэх бөгөөд ядаргаатай

холбоотой жинг тооцож үзэх ёстой. Ажилтай холбоотой хүлээлгэд байх эхлэх болон дуусгах хугацааны хоногийн цагийг тооцох ёстой.

115.401(b)(4) Нислэгийн үүрэгт хугацаа. Энэ заалт нь ЧНГ эзэмшигчийг нэг үүрэгт ажлын хугацаан дах ядаргааны нийт үр нөлөөг авч үзэхийг шаардана. Энэ тухайн этгээдийг үйл ажиллагаа эрхлэгчид ажилд ирснээс тухайн этгээдийг үйл ажиллагаа эрхлэгч ажил дээрээс чөлөөлөх хүртэлх хугацаа юм. Жишээлбэл энэ нь нисэх баг нэг сарын ээлжтэй, нэг сар чөлөөтэй, эсхүл аливаа ижил зохицуулалтаар ажилладаг бол үйл ажиллагаанд ихэвчлэн нөлөөлнө. Энэ нь уртасгасан амралтын хугацааны үр нөлөө байж болно.

115.401(b)(5) Үйл ажиллагааны төрөл. Энэ заалт нь ЧНГ эзэмшигчийг нисэх баг олон төрлийн үйл ажиллагааны гүйцэтгэх үед нөлөөлөх стресс, үүнээс үүсэх ядаргааг авч үзэхийг шаардана. Нисэх баг нислэгийн болон үүрэг гүйцэтгэх хугацаанд нэгээс олон төрлийн үйл ажиллагааг гүйцэтгэх шаардлагатай тохиолдолд харгалзан үзэх ёстой. Хэд хэдэн төрлийн үйл ажиллагаанаас үүсэх ажлын ачааллыг судалж, ядаргааны жинг тооцно. Тухайлбал:

- Хучилттай ХБЗ-аас хөдөлгөөн багатай, цаг агаарын сайн байхад А-аас А цэг хүртэлх үйл ажиллагаа. Энэ нь дунд зэргээс бага ядаргааны жин бүхий үйл ажиллагаа эрхлэгчийн анхдагч ажиллагаа юм.
- Их өндөрт тандем-шүхрийн үйл ажиллагаа нь ядаргааны өндөр түвшин болон ядаргааны их жинтэй байна.
- Аэробатик, эсхүл формац ажиллагаа нь анхаарлын өндөр түвшинг шаардах учраас стрессийн өндөр түвшин болон ядаргаатай холбоотой их жинг өгнө.

115.401(b)(6) Нийт үүрэг гүйцэтгэх цаг. Энэ заалт нь ЧНГ эзэмшигчийг цаг хугацааны турш дах ажлын нөлөөг харгалзан үзэхийг шаардана. Үүнд энгийн ажлын өдөр болон хуваарьт багтсан нийт цаг орно. Жишээлбэл үүнд амрах болон хоолны завсарлагыг оруулсан ажлын өдөр болон олон нийтийн амралтын өдөр, 7 хоногийн амралтын өдрүүд болон жилийн амралтын өдрүүдийг оруулсан жилийн ажлын мөчлөг байна. Ядаргааны жин нь өдөр тутмын хугацаанд сөрөг байж болно, харин олон нийтийн амралтын өдөр, 7 хоногийн амралтын өдөр, жилийн амралтыг авч үзэхэд эерэг байж болно. Ерөнхийдөө тэнцвэртэй байх ёстой.

115.401(b)(7) Нийт нислэгийн цаг. Энэ заалт нь ЧНГ эзэмшигчийг цаг хугацааны турш дах олон хүчин зүйлсийг багтаасан нислэгийн цагийн нөлөөг харгалзан үзэхийг шаардана. Үүнд энгийн ажлын өдөр болон хуваарьт багтсан нийт цаг орно. Ядаргааны жин нь өдөр тутмын олон тооны нислэг, өдөр дунд томхон амралтын хугацаа бүхий өглөө болон өдрийн үйл ажиллагаа болон үйл ажиллагааны холимог төрлийн нийлбэр г.м өөр өөр байж болно. Хуваарь нь мөн жилийн мөчлөг дэх ядаргааны үр нөлөөг харгалзан үзэх ёстой. Ажлын ачааллын үнэлгээг нисэх багийг үүргээ гүйцэтгэхэд үзүүлсэн дэмжлэг болон үйл ажиллагааны хамрах хүрээнд нислэгийн нарийн төвөгтэй байдалтай холбоотой хийнэ.

115.401(b)(8) Нислэгийн цагийн хязгаарлалт, эсхүл нислэгийн үүрэг гүйцэтгэх хугацааны хязгаарлалт, эсхүл аль алийг нь тусгай шийдвэрээр нэмэгдүүлэх. Энэ заалт нь ЧНГ эзэмшигчийг урьдчилан хараагүй үйл ажиллагааны нөхцөл байдлын улмаас хааяа гарах тооцоолоогүй байдлыг хангах, хуваарьт авч хэлэлцэхээр өгөгдсөн нэмэгдлээр хангахыг шаарддаг.

Нислэгийн үүрэгт хугацааны нэмэгдлийг ядаргаанд сөрөг нөлөө үзүүлнэ гэж үзэх бөгөөд амралтын хугацааг нэмэгдүүлэх, хоолны завсарлагаар хангах, эсхүл ядаргаанас гаргах өөр бусад стратегийн нөхцөлийг гаргах ёстой. Үйл ажиллагаа эрхлэгч нь нислэгийн, эсхүл ажлын цагийн хязгаарлалтын авч хэлэлцэхээр өгөгдсөн нэмэлтийг зөвшөөрөх журамтай байх ёстой. Журам нь бүх хүчин зүйлийг харгалзан үзээд ажил үүргийн байдал, цаг агаар, нисгэгчийн туршлага, сүүлийн 24 цагийн ажлын ачаалал, нисгэгчийн зөвшөөрөх байдал болон үйл ажиллагааны менежерийн зөвшөөрлийг оруулсан байна.

115.401(b)(9) Биоритм. Хүмүүс хоногийн 24 цагийн турш нэг жигд, өөрчлөлтгүй түвшинд бие физиологи болон сэтгэл санааны хувьд ажилладаггүй гэдгийг хүлээн зөвшөөрөх ёстой. Биеийн бүх эрхтэн нь өдөр тутмын оргил үе болон тархины биологийн цагтай холбоотой биоритмээр ажилладаг. Биологийн цаг нь биеийг өдөр/шөнийн мөчлөгтэй “хөл нийлүүлж”, гэрэл, харанхуйд мэдрэмтгий байх, ажиллах/амрах хэлбэр болон бусад хүмүүсийн үйл ажиллагааны хэлбэрийг мэдрэхэд тусална. Цаг нь генетикт үндэслэсэн бөгөөд биеийг шөнө унтах, өдөр сэрүүн байлгахар программчлагдсан байдаг. Бие нь шөнийн ажиллагаанд ихэвчлэн дасдаггүй, учир нь бие өөрчлөгдөөгүй өдөр/шөнийн мөчлөгийн илүү дуртай байдал болон өдрийн турш идэвхтэй бусад олон нийтийн үйл ажиллагаанд байнга татагдаж байдаг.

Биоритмийн хоёр тал нь ажил, амралтын зохицуулалт болон арилжааны нислэгийн үйл ажиллагааны аюулгүй байдалд шууд ач холбоотой.

(а) Анхаарал сэрэмж болон гүйцэтгэлийн чадамжид байдаг биоритм нь тухайн этгээд ажлын шаардлагад хэрхэн хандахад нөлөөлнө.

Анхаарал сэрэмж нь физиологийн унтах хэрэгцээ хамгийн их байдаг өглөөний эрт цагт (өглөөний 3-5 цагт) өдөр тутмын хамгийн бага хэмжээнд хүрнэ. Анхаарал сэрэмж буурах, нойр хүрэх нэмэгдэх хоёр дах тохиолдол нь үдийн амралт авдаг газрын унтлагын цагтай таарсан үд дунд юм.

Өмнөх унтлага хангалтгүй байсан үеэд эдгээр цагт унтах хэрэгцээ илүү их байна.

Физиологийн болон оюун ухааны гүйцэтгэлийн чадамж өдөр тутмын хамгийн бага цэгт өглөө эрт (өглөөний 3-5 цагт) ойролцоо цагт хүрдэг. Цагийн дарамтан дор, эсхүл их ачаалалтай ажиллаж байгаа хүмүүс нь энэ үед алдаа гаргах магадлалтай байна. Ялангуяа сэрэмж шаардсан ажлын хувьд гүйцэтгэлийн чадамж хоёр дах удаагаа өдөр дунд багасдаг. Хамгийн сайн гүйцэтгэлтэй байх өдрийн цаг нь тухайн ажлын шинж чанараас шалтгаална. Жишээлбэл хүмүүс ихэвчлэн төвөгтэй оюуны боловсруулалт шаардсан ажил дээр өдөр хамгийн сайн байдаг. Нөгөө талаас

физиологийн тохиргоо, сэрэмж шаардсан ажилд орой эртхэн хамгийн сайн гүйцэтгэдэг.

Бодит утгаар гүйцэтгэлийн чадамж дах биоримт гэдэг нь хүмүүс өдрийн бүх цагт яг адил тэнцүү ажиллана гэж бодож болохгүй гэсэн үг юм.

(b) Унтаж чадах байдалд мөн биоримт байдаг. Өөрөөр хэлбэл, хүмүүс ердөө “санасны зоргоор” унтаж чадахгүй. Өмнө дурдсанаар унтах физиологийн шаардлага нь өглөөний эрт цагт (өглөөний 3-5 цагт) хамгийн хүчтэй байдаг. Сэрэх физиологийн шаардлага түүнээс 6 цагийн дараа хамгийн хүчтэй байдаг.

Бодит утгаар унтах сонирхлын биоритм гэдэг нь шөнийн цагаар амрах хугацаанд адилхан урттай өдрийн цагаар амарсан хугацаанаас илүү сайн унтах боломжтой гэсэн үг юм. Тийм учраас шөнийн ажил нь хамгийн их нойрны алдагдал болон гүйцэтгэлийн чадамжийн өдөр тутмын бага цэг дээр ажиллахтай холбоотой байна.

115.401(b)(10) Амралтын өдөр. Энэ заалт нь ЧНГ эзэмшигчээс нийт хуваарьт хэдэн амралтын өдөр байгааг тооцохыг шаардана. Жилийн амралтын өдрийг багтаасан тоо нь өмнө хэлснээр ядаргааны нийт үр дүнд нөлөөлөх учраас хуваарийг нэг бүхэл хэсэг болгон үнэлэх ёстой.

115.401(b)(11) Бүртгэл хөтлөлт. Энэ заалт нь ЧНГ эзэмшигчийг үйл ажиллагаа эрхлэгч нийт хуваарийн дагуу үүрэг гэж тооцох нисэх багаас шаардах аливаа бүртгэл хөтлөлтийн ажиллагааг харгалзан үзэж, тогтоох ёстой. Үүнд мөн бүртгэл, маягт, хуваарийг хянах явцад гарсан шалгалтын уулзалтын үр дүн орно.

115.401(c)(1) Энэ заалт нь чөлөөт нисэхийн үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа ЧНГ эзэмшигчээс хэрэв үйл ажиллагаа эрхлэгч нь тухайн этгээдийг ядарсан, эсхүл ядарна гэж үзэх шалтгаан байгааг мэдэж байгаа бол агаарын хөлөгт нисэх багийн гишүүн, эсхүл тандем шүхрийн мастерын үүрэг гүйцэтгүүлэхгүй байхыг шаарддаг.

Хувь хүмүүсийн ядаргааны нөлөө нь өөр өөр учраас хуваарь нь дангаараа энэ заалтыг биелүүлэхэд хангалттай биш бөгөөд үйл ажиллагаа эрхлэгч нь хувь этгээдийн ядаргаанаас үүдэлтэй гүйцэтгэлийг хянаж, хуваарьт ажилтнаас санал авч зохих өөрчлөлтийг хуваарьт оруулна.

115.401(c)(2), (3) Энэ заалт нь үйл ажиллагаа эрхлэгчийг чөлөөт нислэгийн нислэг болон хөлс, эсхүл шан урамшуулалтай нислэгийн болон газрын ажил үүргийг багтаасан ажлын цагийн бүртгэлийг хадгалахыг шаардана. Үүнийг бүх төрлийн захиргааны журман дотор оруулж, заасан хугацаанд хадгалж болно.

115.403 Нисэх багийн гишүүний үүрэг хариуцлага - нислэгийн болон үүрэг гүйцэтгэх цаг

115.403(a) Энэ заалт нь агаарын хөлөг, эсхүл түүний бүхээгт байгаа хүмүүсийн аюулгүй байдалд аюултай болохоор ядарсан, эсхүл ядарна гэдгээ мэдэж байгаа этгээдийг нисэх багийн гишүүний үүрэг гүйцэтгэхийг хориглоно.

115.403(b) Энэ заалт нь тухайн этгээдээс түүнд хамааралтай хуваарьт заасан хязгаарлалт хэтрээгүй болохыг бататгаснаас бусад тохиолдолд, этгээдийг ЧНҮА-нд нисэх багийн гишүүний үүрэг гүйцэтгэхийг хориглоно.

Иймд багийн гишүүнээс хуваарийн нэмэгдэж буй нийт дүн болон хязгаарлалтыг мэдэж байхыг шаардана. Багийн гишүүн нь нислэгийн төлөвлөх явцад төлөвлөсөн нислэг, эсхүл цуврал нислэгийн болон ажлын цагийг төлөвлөх чадвартай байх ёстой. ИН-ийн тухай Хуулийн 13 А Хэсэгт заасан нөхцөлд болон зохих мэдээдэл хийгдсэн тохиолдолд хязгаарлалтыг хэтрүүлж болно.

Чөлөөт байдлаар ажиллаж байгаа багийн гишүүд нь өөрсдийн нислэгийн болон ажлын цагийн хувь хүний тэмдэглэл хөтөлж, ингэснээр нислэгт гарахын өмнө үйл ажиллагаа эрхлэгчид үзүүлнэ.

Н Бүлэг - Заавар, бүртгэлийн дэвтэр болон бүртгэл

115.451 Үйл ажиллагааны мэдээлэл

ЧНГ эзэмшигч нь багийн гишүүний ажил үүрэгтэй холбоотой Ерөнхий зааврын хэсэг нь шинэлэг бөгөөд багийн гишүүн болон газрын баг гишүүн түүнийг ашиглах боломжтой болохыг бататгах үүрэгтэй. Ерөнхий зааврын хэсгийн хүчинтэй байдлыг ерөнхий өөрчлөлтийн үйл явцад хариуцна. Ихэвчлэн үйл ажиллагаа эрхлэгч нь тараах жагсаалтаар багт бүх, эсхүл зөвхөн чухал хэсгийг бэлэн байлгана. ЧНГ эзэмшигч нь олон баазтай бол Ерөнхий зааврын зохих хэсгийг тэдгээр баазад байлгана.

115.453 Бүхээгт авч явах баримт бичиг

ЧНҮАГ эзэмшигч нь нислэг бүрд 91.111-д шаардсан баримт бичгийн жагсаалтанд орсон баримт бичгийг авч явахыг бататгах үүрэгтэй. Тэдгээр шаардлагыг нислэгт бэлдэх ажиллагааны явцад хариуцна. Жнь: үйл ажиллагааг явуулдаг зарим бүсэд НОТАМ болон НМҮ-ний мэдээлэл байдаггүй байж болно.

115.455 Нислэгийн бүртгэлийн дэвтэр

ЧНГ эзэмшигч нь агаарын хөлөг бүрийн хувьд, өдөр тутмын нислэгийн үнэн зөв бүртгэлийг хөтлөх үүрэгтэй бөгөөд бүртгэлд дүрэмд заасан мэдээлэл орсон байна. Энэ Дүрэм 91.619-ээс шаарддаг техникийн бүртгэл дээр нэмж шаардана, гэхдээ Ерөнхий зааварт тохирох тайлбарласан журам орсон бол, эдгээр хоёр дүрмээс шаардсан дэлгэрэнгүй мэдээллийг хүсвэл нэг баримт бичиг болгон нийлүүлж болно.

Дүрмийн (11)-ээс (15)-т заасан мэдээллийг өдөр тутмын бүртгэлд нислэг бүрийн дэлгэрэнгүй оруулсан байх байдлаар цуглуулж болно. Зорчигчийн мэдүүлгээс илүү энэхүү мэдээллийг өдөр тутмын нислэгийн бүртгэлд оруулснаар үйл ажиллагаа эрхлэгч үүнийг хийж дуусгахад илүү уян хатан байдлаар хангана. Гэхдээ үйл

ажиллагаа эрхлэгч нь жин болон төвлөрөлтийн мэдээлэл нисгэгчид нислэгийн өмнө бэлэн байх тогтолцоотой байх ёстой.

115.457 Хадгалах хугацаа

ЧНГ эзэмшигч нь бүртгэлийг заасан хугацаанд хадгалахыг баталгаажуулах ёстой. Энэ нь бүртгэлийг цуглуулж, янз бүрийн хугацаагаар хадгалахыг шаарддаг олон дүрмийн нэг бөгөөд хадгалах бүр бүртгэлийг нэг төв бүртгэлийн системд авчрах боломж юм. 115.67-оос лавлагаа харах ёстой.

Тохиромжтой байдлын тулд, бүх дүрмийн хэсгийн ИНД-115-ын үйл ажиллагааны бүртгэл хөтлөх шаардлагын хураангуй нь дараах болно:

- **115.65** - үнэмлэх, зэрэглэл, гэрчилгээ, томилгоо, эсхүл үйл ажиллагаа эрхлэгчээс зөвшөөрөл авах шаардлагатай хүмүүсийн бүртгэл. Тухайн этгээд ажлаас гарсны дараа 72 сар хүртэл хадгална.
- **115.67** - аюулгүй байдлын-эрсдэлтэй үйл ажиллагаанд ашигладаг төхөөрөмжийн тест, шалгалт, тохиргоо (жин, өргөх төхөөрөмж, түлш шахагч, шүүгч)-ны бүртгэл. Дэлгэрэнгүй мэдээллийг бүртгэсэн өдрөөс хойш хоёр жил хадгална.
- **115.71** - Нислэг дагах хяналтын үйлчилгээний болон нислэгийн төлөвлөлтийн мэдээлэл. Нислэгийн өдрөөс хойш 12 сар хадгална.
- **115.313** - Сургалт, шалгалт болон мэргэшлийн бүртгэл. Нисэх багийн гишүүн гэрчилгээ эзэмшигчийн ажлаас гарснаас хойш 12 сар хадгална.
- Захиалгын, давхар хөлсөлсөн, эсхүл түрээсийн гэрээний хуулбар. Тухайн гэрээний дагуу хийсэн сүүлчийн нислэгийн өдрөөс хойш нэг жил хадгална.
- **115.361** - Багийн гишүүний ур чадварын шалгалт болон нислэгийн шалгалт. Шалгалтын нислэгийн өдрөөс хойш 12 сар хадгална.
- **115.455** - Өдөр тутмын нислэгийн бүртгэл. Нислэгийн өдрөөс хойш 12 сар хадгална.
- **115.457** - Нислэгийн болон үүрэг гүйцэтгэх цагийн бүртгэл. Бүртгэснээс хойш 12 сар хадгална.

Хавсралт А - Гэрээ - Ерөнхий зүйл

Удиртгал

Энэ зүйлд чөлөөт нисэхийн үйл ажиллагаа эрхлэгч нь ИНЕГ-аас гэрчилгээжсэн, эсхүл гэрчилгээжээгүй байж болох гэрээлэгч нартай гэрээ байгуулахдаа анхаарах зүйлсийг дэлгэрэнгүй оруулсан.

Энэхүү гэрээлсэн ажлыг гэрчилгээжсэн чөлөөт нисэхийн үйл ажиллагаа эрхлэгчийн гүйцэтгэж байгаа ажлын хэсэг гэж үзэх бөгөөд үйл ажиллагаа эрхлэгчийн үйл ажиллагааны журам болон үйл ажиллагааны менежментийн системийн дагуу байх ёстой гэж үзнэ.

Шаардлагатай баримт бичиг болон чөлөөт нисэхийн үйл ажиллагаа эрхлэгчтэй хийх харилцан ажиллагааг хийх үүрэг хариуцлага.

Ерөнхий нөхцөл

Үйл ажиллагааг гэрээлэхдээ гэрээлсэн үйл ажиллагаатай холбоотой гэрээлэгчийн байр, ажилтан, журам нь ИНД-115 болон тухайн үйл ажиллагааны явцад тавигдах үйл дүрмийн шаардлагыг биелүүлэх ёстой.

Дүрэм нь ИНЕГ-ын гэрчилгээ шаардлагатай гэж заагаагүй учраас, үйл ажиллагаа эрхлэгч нь өөрийн Ерөнхий зааварт гэрээлэх талаар нөхцөл оруулсан бол гэрчилгээжээгүй байгууллагад үйл ажиллагааг гэрээлж болно. Үйл ажиллагаа эрхлэгч нь тухайн гэрээлэгч шаардлагатай стандартыг биелүүлж байгаа эсэх болон аливаа үйл ажиллагааг үйл ажиллагаа эрхлэгчийн зааврын дагуу явуулж байгаа эсэхийг шийдэх өөрсдийн мэдлэг туршлагатай байх ёстой.

Үйл ажиллагаа эрхлэгч нь ажиллагааг нь дэмжих сургалт болон ТҮ-ний үйл ажиллагааг явуулахын тулд Ерөнхий заавартаа хэд хэдэн мэргэжлийн гэрээлэгчийн оруулах шаардлагатай болж болно. Үйл ажиллагаа эрхлэгч нь ИНЕГ-ын Даргад гэрээлэгч нарыг хянах мэдлэг туршлага болон журамтай гэдгээ баримтаар батлах ёстой.

Үйл ажиллагаа эрхлэгч нь гэрээлэгч нарын явуулах бүх үйл ажиллагааг хариуцна. Үйл ажиллагаа эрхлэгч нь гэрээлэгчийг хянаж чадахгүй бол өөрсдийн ИНД-115 гэрчилгээжилтэнд эрсдэл үүсгэх болно.

Гэрээлэх хүрээ нь зөвхөн мэдлэг туршлага болон ИНД-115-ын журмаар хязгаарлагдана. Гэрээлэгчдийг удирдах болон тэдгээр гэрээлэгчийн жагсаалт бүхий тусгай хэсэгтэй Ерөнхий зааврыг ИНЕГ-ын Дарга хүлээн зөвшөөрөх нь гэрээг хүлээн зөвшөөрснийг үзүүлнэ.

Журам

Гэрээлэгч удирдах журмыг боловсруулахдаа дараах мэдээллийг харгалзан үзнэ:

- Гэрчилгээжсэн байгууллага нь аливаа ажлыг гэрээлэхийн өмнө төлөвлөсөн гэрээлэгч дээр очиж үзэх хэрэгтэй. Гэрчилгээжсэн байгууллага нь гэрээлэгчтэй аливаа үйл ажиллагаа явуулахын өмнө төлөвлөсөн гэрээлэгч дээр очиж үзэх үнэлгээний өмнөх журмыг гэрээлэгчтэй хийнэ. Очиж үзсэнээр ашиглахыг хүсч байгаа гэрээлэгчийн мэдлэг туршлага, эсхүл үйлчилгээнд нь ЧНГ эзэмшигчийн шаардлагыг биелүүлж байгаа эсэхийг тогтооно.
- Хэрэв дэд гэрээлэгч нь шаардлагыг хангахгүй бол гэрээлэгчийн мэдлэг туршлага, эсхүл үйлчилгээг ИНД-115-г биелүүлэхээр болгохын тулд чухал хэсгийг сайжруулахыг баталгаажуулах журам хэрэгтэй болно.
- ЧНГ эзэмшигчийн гэрээлэгчийн мэдлэг туршлага, эсхүл үйлчилгээг ашиглах хүрээний үнэлгээ
- Гэрээлэгч дээр очсон уулзалтыг бүртгэх, залруулах арга хэмжээ авах төлөвлөгөөтэй байх, гэрээлэгчийг хэзээ ашиглахыг үзүүлэх гэрээлэгчийн хяналтын журам

Хавсралт В - ТҮ-г гэрээлэх

Удиртгал

Энэ хэсэг нь үйл ажиллагаа эрхлэгчийн ТҮ-ний ажлын заримыг, эсхүл бүхэлд нь ТҮ-ний байгууллагаар гүйцэтгүүлэх зорилгоор ЧНҮА эрхлэгч ТҮ-ний байгууллагатай гэрээ хийх үед дагаж мөрдөх журмыг нарийвчлан тодорхойлсон болно. Энэ мэдээлэл нь мөн ИНД-145-аар гэрчилгээжсэн бөгөөд чөлөөт нисэхийн үйл ажиллагаа эрхлэгчийн ТҮ-ний ажлыг гэрээлэх хүсэлтэй ТҮ-ний байгууллагад хэрэгцээтэй юм.

Үүрэг хариуцлага

Агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгч нь агаарын хөлгийн ТҮ-ний дараах бүх асуудлыг хариуцна:

- бүх шаардлагатай ТҮ-г зөв төлөвлөх
- үйл ажиллагаа эрхлэгчийн ТҮ-ний заавар, агаарын хөлгийн ТҮ, засвар болон эд ангийн гарын авлага, ТҮ-ний хөтөлбөр болон төлөвлөсөн ТҮ-г гүйцэт хийж бүртгэсэн болохыг бататгах шаардлагатай холбогдох бүртгэлийн баримт бичгийг багтаасан хангалттай баримт бичгээр хангах
- агаарын хөлгийн найдвартай байдлын хөтөлбөр болон ТҮ-ний хөтөлбөрийн боловсруулалтын хяналтаар хангах
- гэмтлийг мэдээлэх, хянахыг багтаасан НТЧ-ын хэрэг явдлыг хянах
- бүх холбогдох НТЧ-ын удирдамжийг дагаж мөрдөх

- бүх үйлдвэрлэгчийн үйлчилгээний бюллетин, эсхүл бусад үйлчилгээний зөвлөмжийг үнэлэх, зохих ёсоор дагаж мөрдөх
- ТҮ-г зохих ёсоор гүйцэтгэхийн тулд хангалттай бэлтгэгдсэн техникийн ажилтнаар хангах
- ТҮ-г зохих ёсоор гүйцэтгэхийн тулд хангалттай байр, төхөөрөмж, багаж хэрэглэл, тохируулга болон байгууламжаар хангах
- агаарын хөлгийн сэлбэгээр хангах, хүлээн авах, хадгалах
- ТҮ шаардлагатай үед ТҮ гүйцэтгэх хүмүүст агаарын хөлгийг бэлэн байлгаж, хийх ажлын талаар хангалттай техникийн чиглэл өгөх
- агаарын хөлөг болон агаарын хөлгийн иж бүрдлийн шаардлагатай үйлчилгээ үзүүлэх
- нислэгийн бүх шаардлагатай бүртгэл, бүртгэлийн дэвтрийг бөглөж, шаардлагатай бичлэгийг хийх
- агаарын хөлгийн нислэгийн гарын авлага болон тэдний зөв статусыг жагсаасан холбогдох хамгийн бага тоног төхөөрөмжийн жагсаалт г.м агаарын хөлгийн бүх бичиг баримтыг хадгалах.

Тайлбар: Үйл ажиллагаа эрхлэгч нь дээрх үүргийн аль нэгийг, эсхүл бүгдийг гүйцэтгүүлэхээр бусад хүмүүс, эсхүл байгууллагыг гэрээлэхийг сонгож болно. Гэхдээ эдгээр үүргийг биелүүлэх гэрээлсэн зохицуулалт нь үйл ажиллагаа эрхлэгчийг агаарын хөлгийнхөө үйл ажиллагаа болон НТЧ-г үргэлжлүүлэх эцсийн үүрэг хариуцлагаас чөлөөлөхгүй.

Ерөнхий нөхцөл

Дээр дурьдсан үүргийн аливаа хэсгийг гүйцэтгэхээр чөлөөт нисэхийн үйл ажиллагаа эрхлэгч болон ТҮ-ний байгууллагын хооронд гэрээ байгуулахдаа чөлөөт нисэхийн үйл ажиллагаа эрхлэгч нь дараах ерөнхий нөхцөлийг харгалзан үзэх хэрэгтэй:

- ТҮ-ний байгууллага нь дүрмийн ТҮ-ний шаардлагыг хангаж чадна гэдгийг ИНЕГ-т батлах зохицуулалт
- ямар үүргийг гэрээлэхийг тодорхойлсон хоёр талын хооронд байгуулсан албан ёсны гэрээ. Энэ гэрээ нь зохих ёсоор тал бүрийн Ерөнхий зааврын хэсэгт орох ёстой.
- Гэрээний асуудлаар гэрээлэгч байгууллагатай харилцах, үйл ажиллагаа эрхлэгчийн компаний дотроос удирдах ажилтныг нэр дэвшүүлэх
- Тухайн агаарын хөлгийн маягийн хувьд, үйл ажиллагаа эрхлэгчээс нэгээс илүү ТҮ-ний байгууллагыг нэр дэвшүүлсэн бол зохицуулалтыг ТҮ-ний баазад биш өөр баазад явуулсан үүргээс бусад тохиолдолд ИНЕГ-ын Дарга ихэвчлэн хүлээн зөвшөөрөхгүй.
- Жагсаасан аливаа үүргийг гэрээлэхээр үйл ажиллагаа эрхлэгчийн хийсэн зохицуулалтыг үнэлэхдээ ИНЕГ нь талуудын хоорондох бүх техникийн гэрээг

шалгах хэрэгтэй болж болно. Гэрээ нь байгууллага тус бүрийн Ерөнхий зааварт орсон байх ёстой.

- Гэрээ болон техникийн гэрээг их хэмжээгээр өөрчлөх аливаа саналд ИНЕГ-аас эхлээд зөвшөөрөл авах шаардлагатай бөгөөд аль болох хурдан мэдэгдэх ёстой.

Тайлбар: Жишээлбэл ТҮ-ний байгууллагаа өөрчлөх санаа, гэрээнд байгууллагын, журмын, эсхүл техникийн өөрчлөлт оруулах. Удааширч мэдэгдсэнээр тухайн өөрчлөлтийг цагт нь оруулахаар боловсруулж амжихгүй болж болно.

ТҮ-ний гэрээний дэлгэрэнгүй агуулга

Тайлбар: Бичгийн гэрээ нь ТҮ-ний байгууллага урьдчилан зөвлөлөгүй ямар арга хэмжээ авахыг мөн ямар үүрэгт оперэторын зөвшөөрөл шаардлагатай болохыг тодорхой заасан байх ёстой.

Тайлбар: Агаарын хөлгийг хуваарьт болон хуваарьт ТҮ-нд оруулахад шаардлагатай шалгалтын талаар тодорхой заалт өгөх ёстой. Бүх мэдэгдсэн эвдрэлийн талаар шаардлагатай бол ТҮ-ний байгууллагатай зөвшөлцсөний дараа шаардлагатай нэмэлт ажлын хамт баримтжуулна.

Албан ёсны бичгийн гэрээ нь тодорхой гэрээнд таарснаар, дараах зүйлсийг харгалзан үзэх ёстой:

- Байгууллагын бүтэц - агаарын хөлгийн нийт дэмжихэд хоёр талын хоорондах үүргийн ерөнхий хэсэг, хууль ёсны дүрэм болон бусад чухал шаардлагыг биелүүлэх
- 2 талын хоорондах харилцаа - НТЧ-ын асуудлаар санал солилцох холбогдох цэг
- хор хөнөөлгүй шалгалт, агаарын хөлгийг жинлэх, эсхүл будах зэрэг аливаа хоёрдагч эрх болон дэд гэрээлэх үүрэг
- тохирох сургалтанд хамрагдсан, мэргэшсэн инженерийн ажилтныг хангалттай тоогоор хангах
- ТҮ-ний хүн хүчийг хуваарилах, хянах төлөвлөгөө
- ТҮ-ний хуваарь гаргах, шалгах, өөрчлөлт хийх журам. Хуваарийн өөрчлөлтийг зөвшөөрөх зохицуулалт
- Хуваарийн шаардлагыг биелүүлэхэд хэрэгтэй баримт бичгийг бэлтгэх
- үйлчилгээний бюллетин, өөрчлөлт болон үйлдвэрлэгчийн техникийн хөтөлбөрийг үнэлэх, оруулах журам
- найдвартай байдлын хөтөлбөрийн менежмент болон ажиллагаа
- ТҮ-нд орж байгаа агаарын хөлөгт зориулсан битүү байрны хангалт
- хуваарьт болон хуваарьт бус ажилд зориулсан төхөөрөмж, хэрэгслийн хангалт

- иж бүрдлийн болон материалын хяналт - сэлбэг хэрэгслийн хангалт, тэдгээрийн эх сурвалж, хүлээн авах, хадгалах. Гэмтлийг засах болон нөөц сэлбэгийн зохицуулалтын хувьд тодорхой анхаарлыг орлуулах хэсэг, иж бүрдлийн хангалтанд тавих хэрэгтэй.
- техникийн гарын авлага, хэвлэл болон зургийг хянах, тараах, өөрчлөх
- техникийн бүртгэлийг хийх, хянах, НТЧ-ын удирдамжийн биелэлт, иж бүрдлийн хүчинтэй хугацааны хяналт болон бүртгэлийн дэвтрийг бөглөх
- эвдрэлийн хяналт болон менежмент - хойшлуулсан болон давтагдсан эвдрэлийн хяналт
- шугамын станцыг дэмжих зохицуулалт болон баазаас хол эвдрэлийг засах
- менежмент болон техникийн инженерийн зааврын хангалт
- НТЧ-ын зөрчлийг хянах, мэдээлэх
- чанарын баталгаажуулалт, чанарын баталгаажуулалтын хөтөлбөрийн тодорхойлолтын үүрэг
- Асуулт Хариултын мэдээллийн дараа хоёр тал асуудлыг үр дүнтэй шийдвэрлэх үүрэг
- Үйл ажиллагаа эрхлэгчийн нэр болон чөлөөт нисэхийн үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээний дугаар. Байгаа бол гэрээлэгч байгууллагын Нэр болон ИНЕГ-ын гэрчилгээний дугаар
- Гэрээлэх зохицуулалтын талаар дурдсан Ерөнхий заавар, эсхүл инженерчлэлийн заавар дах нэр болон лавлах дугаар.

Хавсралт С - Цахилгаан бүртгэл болон баримт бичиг

Ерөнхий мэдээлэл

Баримт бичиг болон бүртгэлийг амархан үзэж болохоор хэлбэрээр хадгалах шаардлагатай, ингэснээр ажиллагаа болон бусад шаардлагын сүүлд шаардлагатай бол амархан олно. Эдгээр баримт бичиг нь мөн бусад ажиллагаа, ажилтны сургалт болон ЧНҮА эрхлэгчийн байнгын үүрэг хариуцлагат лавлагааны чухал хэсэг болно.

Бүртгэлийг электрон хэлбэрээр хадгалж болно, гэхдээ систем нь мэдээллийн аюулгүйн хамгаалалт, үнэн зөв байдал, авах боломжийг баталгаажуулсан байна. Электрон өгөгдлийг хуулж хадгалах систем чухал. Электрон бүртгэл болон бичиг баримтыг хадгалах журам нь дараахийг харгалзан үзэх ёстой:

- цахилгаан тасалдсан тохиолдолд өгөгдөл алдагдахаас сэргийлэх
- программ хангамжийн хяналт, үүнд өөрчлөлт болон эвдрэлээс сэргийлэх
- эрхгүй этгээд нэвтрэхээс сэргийлэх
- аудитын зам байгууламж
- өгөгдлийг хатуу хэлбэртэй адилхан байдлаар адилхан хугацаанд архивлах

- болвол өдөрт нэг удаа чухал мэдээллийг хуулж хадгалах, мэдээллийн хадгалалтыг нэмэлт хуулж хадгалах
- өгөгдлийг нэвтрэх, гарахад шалгах
- хэвлэлийн хангалт
- мэргэшлийн сургалт
- хадгалсан өгөгдлийг өөрчлөх
- асуудлын дэлгэрэнгүй болон шийдлийг оруулсан асуудлын мэдээлэх бүртгэл.

Тайлбар: Бүртгэлийг үзэхэд хялбар болгохын тулд бичил хальсанд буулгах, соронзон хальсанд хадгалах, CD, эсхүл ижил төрлийн зүйлд хуулан, аюулгүй нөхцөлд хадгалах ёстой.

Хавсралт D

Жишиг хөтөлбөр

Энэхүү ТҮ-ний хөтөлбөр жишээ бүтэц нь хүснэгтэн хэлбэр болон бичгийн хэлбэрийг хослуулан шаардлагатай шалгалтыг заасан байна. Хөтөлбөр нь өөрөө харьцангуй шулуун бөгөөд жижиг үйл ажиллагаа эрхлэгч ихтэй. Хөтөлбөрт шалгуудын тодорхойлолт, хугацаа болон шалгалтын хуваарь болон бусад ТҮ-ний стандартыг багтаасан үйлдвэрлэгчийн ТҮ-ний гарын авлагын лавлагааг багтаасан.

ИНД-115-т шаардсан ТҮ-ний хөтөлбөр

ИНД-115 нь гэрчилгээ эзэмшигчийн ашигладаг агаарын хөлөг болон шүхрийн иж бүрдэл бүрд ТҮ-ний хөтөлбөрийг шаардана (ханг-глайдер болон параглайдерыг оруулж болно).

ТҮ-ний хөтөлбөрт дараах орох ёстой:

- тоног төхөөрөмжийн төрөл
- серийн дугаар
- бүртгэлийн тэмдэг (, эсхүл бусад танигдахуйц хуваарь).

Хөтөлбөр нь дараахийг багтаасан, НТЧ-ыг хадгалах шаардлагатай ТҮ-ний гүйцэтгэлд зориулсан зааварчилгаа болон журмыг дүрсэлсэн байх ёстой:

- Ихэвчлэн үйлдвэрлэгчээс гаргасан, дараахтай холбоотой шаардсан ТҮ-ний талаар дэлгэрэнгүй хуваарь:
 - үйлчилгээний цаг
 - мөчлөг
 - календарийн цаг
 - системийн үйл ажиллагааны дугаар
 - дээрх үзүүлэлтийн аливаа нийлбэр.

Тайлбар: Үйлдвэрлэгчийн хуваарьт байгаа зүйлсийг лавлагаагаар оруулж болно, хөтөлбөрт дахин бичих хэрэггүй.

- Шалгалт болон тест
- Шалгах бүс
- Шаардлагатай хэсэг
- ТҮ-ний зөв гүйцэтгэл
- Хэрэглэсэн зөв хэсэг болон материал.

Дараах журмыг хөтөлбөрт оруулсан байх ёстой:

- “агаарын хөлөг”-ийг хөтөлбөрт оруулах
- Шаардлагатай бүх шалгалтыг явуулсныг баталгаажуулах журам
- Гэмтлийг бүртгэх болон гэмтлийн бүртгэлийн жишээ
- Илэрсэн гэмтлийг засалтыг үзүүлэх болон шаардлагатай бол гэмтлийг хойшлуулах талаар журам хэрэгтэй.
- 91.623-т шаардсан бүртгэл
- ханг-глайдер, эсхүл параглайдерын хувьд:
 - Гүйцэтгэсэн ажлын тодорхойлолт, эсхүл чухал хүлээн зөвшөөрөх өгөгдөл.
 - Тухайн этгээдийг гэрээлсэн бол гүйцэтгэсэн ажлыг баталж байгаа этгээдийн нэр.

Боловсруулсан ТҮ-ний хөтөлбөр нь ИНД-91-ийн G Бүлгийн шаардлагатай дүйцэхүйц байна.

Боловсруулсан ТҮ-ний хөтөлбөр нь 115.61-ийн шаардлагыг биелүүлнэ.

Боловсруулсан ТҮ-ний хөтөлбөр нь тоног төхөөрөмж үйлдвэрлэгчийн ТҮ-ний хуваарийн шаардлагыг биелүүлэх ёстой.

Боловсруулж болох “Шаардлагатай шалгалтын зураг”-ийн жишээ загвар:

Зүйл	Хугацаа	Стандарт
91.605(е)(1)-д шаардсан радио станц болон навигацийн төхөөрөмжийн тест, шалгалт	24 сар	ИНД-43 Хавсралт B
91.605(е)(2)-т шаардсан өндөр хэмжигч болон далайн түвшнээс дээш өндөр мэдээлэх төхөөрөмжийн тест болон шалгалт	24 сар	ИНД-43 Хавсралт D
	Системийн тунадаст ашиглах болон өөрөө түгжигдих нь холбогдохгүй бол өөр атмосферийн ачааллыг даралтаас шахуургыг хослуулснаас бусад тохиолдолд атмосферийн ачааллын системийн нээлт болон хаалтын дараа.	
	Суурилуулт, эсхүл ТҮ-ний дараа өгөгдөл дамжуулагчийн алдаа заахад автомат атмосферийн даралтын өндөр мэдээлэх систем.	

Зүйл	Хугацаа	Стандарт
91.605(е)(3)-т шаардсан SSR дамжуулагчийн тест	24 сар	ИНД-43 Хавсралт E
91.605(е)(4)(i)-ын ELT тест болон шалгалт	12 сар / 100 цагийн аль түрүүлж дууссанд	ИНД-43 Хавсралт F
91.605(е)(4)(ii)-ын ELT тест болон шалгалт	24 сар бүр	Үйлдвэрлэгчийн зааварчилга
91.605(е)(5)-т шаардсан компасыг шалгах	24 сар	ИНЕГ-ын АС43-7
	Компасны хэмжээст нөлөөлж болох үе шатанд багтаагүй үйл явдлын дараа.	
Анхан шатны тусламжийн материал	12 сар	Үйлчлэх хугацаа, солих хугацаа болон хугацаа нь дууссан зүйл байгааг шалгах
Гал унтраагч	12 сар	Үйлдвэрлэгчийн шаардлага
Хоосон жин болон хүндийн төвийг дахин тогтоох	Хоосон жин болон хүндийн төвд нөлөөлж болох өөрчлөлтийг агаарын хөлөгт хийсэн байх	Үйлдвэрлэгчийн зааварчилгаа
	Агаарын хөлгийн нислэгийн зааврын мэдээлэл үнэн зөв биш гэж үзэх үндэслэл байвал	
Агаарын хөлгийг жигнэх	120 сар	Үйлдвэрлэгчийн зааварчилгаа
НТЧ-ыг шалгах	365 хоног	ИНД-43 D Бүлэг

Шалгах хуудас	Агуулга	Хугацаа
50 цаг	Үйлдвэрлэгчийн хуваариас бүх 50 цагийн шалгах зүйлс	50 нислэгийн цаг, эсхүл 12 сарын аль түрүүнд болсныг тооцно
100 цаг	Үйлдвэрлэгчийн хуваариас бүх 50 болон 100 цагийн шалгалтын зүйлс	100 нислэгийн цаг, эсхүл 12 сарын аль түрүүнд болсныг тооцно
200 цаг	Үйлдвэрлэгчийн хуваариас бүх 50, 100 болон 200 цагийн шалгалтын зүйлс	200 нислэгийн цаг, эсхүл 12 сарын аль түрүүнд болсныг тооцно
НТЧ-ын шалгалт	САА24066/06	91.615 бүрд 365 хоног + 36 өдрийн хүрээ